

Монгол Улсад орчин цагийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага  
үүсч, хөгжсөний түүхт 100 жилийн ойд зориулан бүтээв.

---

**Судалгааны захиалагч:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий  
газар  
Шийдвэр гүйцэтгэх алба

**Ажлын хэсгийн ахлагч:**

А.Намсаманд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий  
газрын дэд дарга бөгөөд Шийдвэр  
гүйцэтгэх албаны дарга, ерөнхий  
шийдвэр гүйцэтгэгч, хурандаа

**Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:**

Б.Алтангэрэл Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм  
шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын  
төвийн эрхлэгч, хууль зүйн доктор  
/Ph.D/, дэд профессор, хурандаа

**Гишүүд:**

Ч.Өнөрцэцэг Шийдвэр гүйцэтгэх албаны Мэргэжлийн  
удирдлагын хэлтсийн дарга, хурандаа  
М.Хүрэлбат Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын  
төвийн эрдэм шинжилгээний ахлах  
ажилтан-багш, хошууч

## Агуулга

Өмнөх үг		4
Удиртгал		5-10
<b>НЭГ. ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ</b>		
1.1.	Монгол Улсад Шүүхийн журмаар хүүхдийн тэтгэлэг гаргуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал	11-19
1.2.	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт	20-41
<b>ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ</b>		
2.1.	Монгол Улсын хэмжээнд хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд хийсэн шинжилгээ	42-54
2.2.	Аймаг, орон нутгийн хэмжээнд хүүхдийн тэтгэлэг гаргуулж буй байдалд хийсэн шинжилгээ	55
2.2.1.	Архангай аймаг	55-58
2.2.2.	Баян-Өлгий аймаг	59-62
2.2.3.	Баянхонгор аймаг	63-67
2.2.4.	Булган аймаг	68-71
2.2.5.	Говь-Алтай аймаг	72-75
2.2.6.	Говьсүмбэр аймаг	76-79
2.2.7.	Дархан-Уул аймаг	80-83
2.2.8.	Дорноговь аймаг	84-87
2.2.9.	Дорнод аймаг	88-91
2.2.10.	Дундговь аймаг	92-95
2.2.11.	Завхан аймаг	96-99
2.2.12.	Орхон аймаг	100-104
2.2.13.	Өвөрхангай аймаг	105-109
2.2.14.	Өмнөговь аймаг	110-114
2.2.15.	Сүхбаатар аймаг	115-119
2.2.16.	Сэлэнгэ аймаг	120-123
2.2.17.	Увс аймаг	124-128
2.2.18.	Төв аймаг	129-133
2.2.19.	Ховд аймаг	134-138
2.2.20.	Хөвсгөл аймаг	139-143
2.2.21.	Хэнтий аймаг	144-147
2.2.22.	Улаанбаатар хот	148-151

2.3.	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаарх судалгаа	152-156
<b>ГУРАВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА</b>		
3.1.	БНСУ-ын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт	157-165
3.2.	БНХАУ-ын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт	166-169
3.3.	Оросын Холбооны улсын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт	170-173
3.4.	Швед Улсын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт	174-182
3.5.	ХБНГУлсын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт	183-194
<b>ДӨРӨВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ</b>		
4.1.	Дүгнэлт	195-197
4.2.	Зөвлөмж	198
<b>ТАВ.ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ</b>		199
<b>ЗУРГАА.ХАВСРАЛТ</b>		200-207

## **Өмнөх үг**

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэх явц дахь эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, харьцуулсан судлалын чиглэлээр олон төрлийн хавсрага судалгааг хийсээр ирлээ.

Энэ удаагийн судалгааны онцлог нь Шийдвэр гүйцэтгэх албаны холбогдох алба хаагчидтай хамтран Монгол Улсад анх удаа гэр бүл цуцлалтын улмаас хүүхдийн тэтгэлэг гаргуулж буй байдалд дүн шинжилгээ хийн, тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, улмаар боловсронгуй болгохтой холбоотой дүгнэлт-зөвлөмжийг дэвшүүлсэнд оршиж байна.

Аливаа улс, үндэстний оршин тогтнох нэг гол үндэс суурь нь гэр бүлийн бат бэх харилцаа байдаг. Гэр бүлийн үнэт зүйл болох үр хүүхдээ тэжээн тэтгэх асуудал нь хүний ёс зүй, хариуцлагатай салшгүй уялдаатай бөгөөд нэгэнт гэр бүл цуцалсан тохиолдолд хүүхдийн тэтгэлэгийн асуудал яригддаг.

Энэхүү судалгааны ажлаар хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны хэрэгжилтийн талаар нийт аймаг, орон нутгийн хэмжээнд зорилтот бүлгүүдээс судалгаа авч дүнг боловсруулан гаргасан нь судалгааны цар хүрээ, ач холбогдлыг нэмж байгаа юм.

Түүнчлэн гадаадын зарим оронд хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаарх эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийж холбогдох зөвлөмжид тусгаж өгсөн.

Та бүхэн манай судалгааны ажилтай холбоотой санал, зөвлөмжөө Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвд ирүүлнэ гэдэгт бид найдаж байна.

Бидний судалгааны ажилд оролцсон судалгааны багийн гишүүддээ гүнээ талархал илэрхийлье.

**ХҮНДЭТГЭСЭН:**  
**ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР,**  
**ДЭД ПРОФЕССОР, ХУРАНДАА**

**Б.АЛТАНГЭРЭЛ**

## Удиртгал

Нийгмийн бичил хэлбэр болох гэр бүл, түүний зохион байгуулалт буюу гэр бүлийн тогтолцоог чулуун зэвсгийн үеэс үүсэлтэй гэж үздэг бөгөөд үүнээс өмнө гэр бүл болох явдал замбараагүй байснаас цус ойртолт элбэг байжээ.

Гэр бүл гэдэг ухагдахууныг эрдэмтэд “Нийгмийн хөгжлийн анхдагч орчин, Хууль ёсоор харилцах хүйсийн харилцаа буюу хууль ёсны гэрээ /И.Кант/”, “Байгаль, ёс суртахууны холбоо /Г.В.Гегель/”, “Амьдралын нөхөн үйлдвэрлэл явуулах зориулалттай /Ф.Энгельс/” зэргээр тодорхойлсон байдаг ба гэр бүл гэж хамтдаа амьдардаг, бие биетэйгээ ямар нэгэн холбоотой /цусан холбоотой, гэрлэсэн г.м/ бүлэг хүмүүс, гэрлэлт болон үрчлэлтэд суурилсан хүмүүсийн харилцааг гэр бүл гэнэ гэх мэт олон янзаар тодорхойлж тайлбарласан байдаг.

Гэр бүлийг судлах зүйл, судалгааны зорилго, зорилт, арга зүйн хувьд харилцан ялгаатай байдлаар социологи, философи, эдийн засаг, түүх, антрологи, сэтгэл судлал, эрх зүй зэрэг олон салбарт хамааруулан судалдаг нийлмэл тогтолцоо юм.

Дан гэр бүл /эцэг, эх, үр хүүхдүүдээс бүрдсэн гэр бүл/, нийлмэл гэр бүл /төрсөн болон төрөл садангийн хүн, хадмууд, хамаатан/, өрөөсгөл гэр бүл /эцэг ба хүүхдүүд, эх ба хүүхдүүд, хүүхдүүд, эмээ, өвөө, ач зээ/, ганц бие гэр бүл /байнга, аргагүйн эрхэнд, сайн дурын үндсэн дээр гэрлэхээс татгалзах/ гэх мэт гэр бүлийн сонгодог хэв маяг байдаг бол орчин үед гэр бүлийн харилцаанд улс дамнасан гэр бүл /гэр бүлийн хосууд хамтдаа амьдрахгүй өөр өөр улсад амьдрах/, олон соёлт гэр бүл /өөр хэл, соёл, ёс заншил бүхий иргэд гэрлэлтийн харилцаа/, хамтран амьдрах гэр бүл /гэрлээгүй хамт амьдардаг, гэр бүлийн амьдарлаар амьдрах/, гэрээт гэр бүл /эхнэр, нөхөр хоёр харилцан тохиролцсоны үндсэн дээр амьдрах/, ижил хүйстэн гэр бүл /сэтгэл санаа болон бэлгийн харилцаа тогтоон, гэр бүлийн амьдралаар амьдарч буй бэлгийн ижил чиг хандлага бүхий хос/ гэх мэт шинэ хэв маяг илэрч байна.


Монгол Улсын хэмжээнд 2010-2019 оны хооронд жилд дунджаар 16,305 гэр бүл шинээр бүртгүүлсэн байх ба 2019 оныг өмнөх жилүүдийн дундажтай харьцуулахад 26,1 хувиар өссөн байна.

*Зураг 1. Гэр бүл шинээр бүртгүүлсэн болон цуцалсан байдал /2010-2019/*




Гэрлэгчдийн 1.1 хувь нь 18-19, 22.5 хувь нь 20-24, 37.3 хувь нь 25-29, 20.3 хувь нь 30-34, 8.4 хувь нь 35-39, 4.3 хувь нь 40-44, 3.1 хувь нь 45-49, 3.2 хувь нь 50-аас дээш насандаа гэр бүл болжээ.

*Зураг 2. Гэрлэгчдийн насны байдал /2019 он/*




Гэрлэгчдийн тоо өсөх үзэгдлийг даган гэр бүл цуцлуулах байдал мөн өссөн байна. Тухайлбал, жилд дунджаар 3630 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байх ба 2019 оныг өмнөх жилүүдийн дундажтай харьцуулахад 19,7 хувиар өссөн үзүүлэлт гарч байна.

*Зураг 3. Гэр бүл цуцалсан тоо /2010-2019/*



Тэгвэл гэр бүл цуцлалтыг гэр бүл байсан хугацаагаар нь авч үзвэл 1.3 хувь нь 1 хүртэл жил, 6.3 хувь нь 1-3 жил, 12.6 хувь нь 4-6 жил, 14.9 хувь нь 7-9 жил, 64,6 хувь нь 10-аас дээш жилийн хугацаанд амьдраад гэр бүлээ цуцалсан байдаг байна. Үүнээс үзэхэд 10-аас дээш жил амьдарсан хосууд гэр бүл цуцлалтын дийлэнх хувийг эзэлж байна.

*Зураг 4. Гэр бүл цуцалсан тоо /гэр бүл байсан хугацаагаар 2019 он/*



Үндэсний статистикийн хорооноос гаргасан дээрх тоо баримтаас үзэхэд гэрлэлт түүнтэй харьцах цуцлалтын тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Жилд дунджаар 16,000 хос гэрлэж, 4,000 орчим хос гэрлэлтээ цуцлуулдаг бол өдөрт 40 гаруй хос гэрлэж, 10 гаруй хос гэрлэлтээ цуцлуулдаг гэсэн үзүүлэлт гарч байна.

Гэр бүл салалтын шалтгааныг маш олон талаас тайлбарладаг ба гэр бүл салалтын нийтлэг шалтгааныг судлаачид соёлын ялгаа /харь орны хүнтэй гэрлэсэн, мөн хоёр өөр гэр бүлийн соёлын мөргөлдөөн/, гэр бүлийн гишүүд хариуцлагаа бүрэн ухамсарлаагүй, гэрлэх хүнээ сайн таньж мэдээгүйгээс үүсэх хэрүүл маргаан, үл ойлголцол, санхүүгийн хомсдол, цалин орлого, амьдралын батлагаа, шилжилт хөдөлгөөн,

архидалт, муу зуршил, гэр бүлээс гадуурх харилцаа, хууралт, хүчирхийлэл, дарамт шахалт гэж тайлбарлаж байна.

#### Салалтаас үүдэх хохирол

-Хүүхдийн эрүүл мэнд, харилцаа зан үйлд өөрчлөлт эмзэглэл үүсэх, хүүхэд өөртөө итгэлгүй байдалтай өсөх;

-Эдийн засгийн хувьд хүүхэдтэй болон хүүхэдгүй гэр бүлд хөрөнгө хуваах хуваарилах, эзэмших эрх гэх мэт зүйлтэй нүүр тулгардаг энэ нь тухайн салж буй хосууд нэг хэсэгтээ хөрөнгө мөнгөний хуваалтаас болж таагүй харилцаа үүсгэх болдог;

-Хүүхэд хариуцах эцэг эхийн аль нэг нь хэт их ачааллыг хүлээдэг;

-Ачаалал стрессээс үүдэлтэйгээр хүүхэдтэй зүй бус харьцах;

-Өсвөр насны хүүхдүүдийн хувьд салалтаас үүдэлтэйгээр эцэг эхийн голд хаягдаж хараа хяналтгүй буруу зан үйлд автах магадлалтай байдаг,

-Тогтвортой бэлгийн амьдралгүй болох. Үүнээс үүдэлтэй өвчлөл, тохиолдлын бэлгийн харилцаа гэх мэт хүчин зүйлтэй тулгарах;

-Гэмт хэрэг гарах магадлалтай. Салагч хосуудын хувьд өс хонзонгийн сэдэл үүсэх магадлалтай;

-Сэтгэл гутрал, хямралтай нүүр тулгарах гэх мэт.


Гэр бүл цуцлалт нь дээрх олон сөрөг нөлөөтэй бөгөөд энэхүү сөрөг нөлөөлөл нь хүүхдэд хүндээр тусдаг нь хамгийн харамсалтай юм. Салж буй гэр бүлийн хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогоос шалтгаалан сөрөг үйл явц ажиглагддаг ба дунд, ахлах ангийн хүүхдэд гэр бүл салалт илүү хүндээр тусдаг гэсэн судалгаа байна. Тухайлбал: хүүхэд аав, ээжийнхээ аль нэгийг сонгох болдог, эсвэл дунд нь хаягддаг, мөн гэр бүл салалтын шалтгааныг өөртөөгөө холбон ойлгож гутралд ордог гэх мэт асуудлууд бий болдог байна. Мөн түүнчлэн гэр бүл салалтаас үүдэн эцэг, эхээс хүүхдэд тавих хараа хяналт суларснаас хүүхэд муу зуршилтай хүмүүстэй нийлэх, цаашлаад гэрээсээ дайжих, өрхийн орлогод өөрчлөлт орж, санхүүгийн асуудал үүссэнээс хүүхэд хөдөлмөр эрхлэх гэх мэт сөрөг үр дагаварууд үргэлжилсээр байна.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага /насанд хүрээгүйчүүдийн хорих анги /-д 2020 оны 09 дүгээр сарын 01-ны байдлаар гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй 30 хүүхдээс судалгаа авахад 10 нь буюу 30% нь эцэг эхтэйгээ амьдардаг, үлдсэн 20 нь буюу 70% нь эцэг эх нь салсан, гэр бүлээсээ дайжсан хүүхдүүд байна.

Монгол Улсад жилд дунджаар иргэний хэргийн шүүхээр 43,000 орчим хэрэг шийдвэрлэгддэгийн 11.5 хувь нь гэр бүлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн хэрэг байна.

*Зураг 5.Шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг /2011-2019/*





Гэр бүлийн хуулийн дагуу шийдвэрлэсэн нийт хэргийн 71 хувийг гэр бүл цуцлалт, 9 хувийг эцэг тогтоосон, 0,3 хувийг эцэг, эх байх эрхээ хасуулсан, 16 хувийг хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 0,7 хувийг гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, 3 хувийг бусад хэрэг маргаан эзэлж байна.

*Хүснэгт 1. 2010-2019 онд Гэр бүлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн хэрэг<sup>1</sup>*

Он	Улсын дүн	Гэрлэлт цуцалсан	Эцэг тогтоосон	Эцэг, эх байх эрхээ хасуулсан	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	Гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох	Бусад
2010	4732	3856	382	6	354	3	131
2011	4449	3642	325	7	364	9	102
2012	3878	3100	278	4	370	11	115
2013	4276	3382	313	6	454	11	110

<sup>1</sup> ШЕЗ

2014	4207	3182	430	21	478	32	64
2015	4539	2978	531	37	825	59	109
2016	4674	2980	450	17	1006	47	174
2017	4566	2791	467	24	1056	50	178
2018	4763	2945	392	11	1146	64	205
2019	4449	2736	465	26	1047	27	148

***Судалгааны ажлын зорилго, зорилт:***

Судалгааны ажлын зорилгыг Монгол Улсад хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, цаашид боловсронгуй болгохтой холбоотой дүгнэлт-зөвлөмж боловсруулах явдал гэж тодорхойлсон ба өмнөө тависан зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг өмнөө тавилаа. Үүнд:

1. Монгол Улсад гэр бүлийн маргааныг шийдвэрлэж ирсэн байдал, тухайлан хүүхдийн тэтгэлэгийг гаргуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлалыг судлах

2. Өнөөгийн байдлаар хэрэгжиж буй хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг судлах

3. Монгол Улсын хэмжээнд хүүхдийн тэтгэлэг гаргуулж буй байдалд дүн шинжилгээ хийн, тэтгэлэг авагч болон иргэдээс тухайн ажиллагаанд өгч буй үнэлгээг гаргах

4. Гадаадын зарим оронд хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх

5. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг холбогдох санал асуулга, судалгааны үндсэн дээр тодорхойлон шийдвэрлэх арга замын талаарх дүгнэлт-зөвлөмж боловсруулах зэрэг болно.

***Судалгааны ажлын арга зүй:***

Судалгааны ажилд нийгмийн шинжлэх ухааны нийтлэг аргууд болох түүхчлэх, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, харьцуулах, асуулгын болон ярилцлагын аргыг өргөнөөр ашигласнаас гадна 21 аймгийн 599 иргэн, 380 төлбөр авагч, 140 шийдвэр гүйцэтгэгчээс хүүхдийн тэтгэлгийн төлбөр гаргуулах ажиллагаатай холбоотой асуудлаар санал асуулга авч дүнг судалгааны ажилдаа ашигласан болно.

# **НЭГ. ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ**

## **1.1. Монгол Улсад шүүхийн журмаар хүүхдийн тэтгэлэг гаргуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал**

Дэлхийн улс орон бүр өөрийн улсын онцлог, нийгмийн хэв маягт тулгуурлан боловсруулсан хууль, дүрэм, журмын хүрээнд гэр бүлийн харилцааг зохицуулдаг. Монгол Улс ч мөн адил түүхэн хөгжлийнхөө үе шатуудад тухайн цаг үеийн нийгмийн хэрэгцээ, шаардлагад тохирсон эрх зүйн актуудыг батлан гаргаж, мөрдөж иржээ.

Гэр бүлийн эрх зүй болон бусад эрх зүй, нийгмийн түүх нь хэзээ ч ямар ч нөхцөлд уламжлал шинэчлэлийн замаар тасралтгүй үргэлжлэн хөгжиж ирсэн үйл явц юм.

Эрт дээр үеэс Монголчуудын гэр бүл, төрөл төрөгсөд, нутаг нутгийнхаа орчинд өөрсдийн зан заншил, хэв уламжлалаараа өрх гэр үүсгэж, эхнэр нөхөр бололцон, үр хүүхдээ хүмүүжүүлж, хүний дайтай хүн болгож, ахуй амьдралаа дээшлүүлэн, төр нийгмийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн юм. Дэлхийн томоохон төрийн зүтгэлтнүүд, эрдэмтэн судлаачид Монголчуудын өрх айлыг нийгмийн амьдралын тулгуур багана болгож өргөн дээдэлсэн үзэл санааг олонтаа магтан сайшааж өөрсдийнхөө зохиол бүтээлүүдэд тэмдэглэн үлдээсэн байдаг. Гэр бүл хэмээх бичил нийгмийн орчинд хүний хамгийн эрхэм нандин харилцаа үүсэж, цусан ба ясан төрлийн холбоо тогтоож, улс үндэстний ирээдүй үе мэндэлж, иргэний төлөвшил биеллээ олж, соёл дэвшил уламжлалыг өвлөн авах үнэт зүйл биелэгдэж байдаг билээ.<sup>2</sup>

Гэр бүл нь нийгмийн хамгийн анхдагч нэгж гэж тодорхойлогддог. Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд аймаг нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана<sup>3</sup> гэж заасан бөгөөд баг хороо нь айл өрхөөс бүрдэх тул айл өрх бол засаг захиргааны нэгжийн үндсийн үндэс болдог. Энэ бол нүүдэлчин ард түмний соёл иргэншлээс улбаатай үндэсний нэгэн өвөрмөц тогтолцоо юм. Айл гэрийн багана болсон эхнэр, нөхөр хоёрыг үр хүүхдүүд нь хангай шиг ханагар аав, алтай шиг ариун ээж хэмээн хайрлан хүндэтгэж, өргөж асарч ирсэн түүхэн сайхан уламжлал заншил нь аль эртнээс зохицуулагдаж ирж өдгөө ёс заншил, зарчим болон хэвшжээ.

<sup>2</sup> Т.Намжил. Гэр бүл судлал. 2004 он, 131 дэх тал

<sup>3</sup> Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. 17.1 дэх хэсэг

**Чингис хааны Их засаг хуульд** гэр бүлийн эрх зүйн зохицуулалтыг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

Чингис хаан Их засаг хуулийг анх 1189 онд, дараа нь 1206 онд буюу Чингис хаан их ор суух үед Их хуралдайг хуралдуулснаар баталжээ. Их засаг хуулийн 3 дугаар зүйл “хүүхэд нь эцэг, эхээ, залуус нь ахмадаа, эхнэр нь нөхрөө үйл сонсвол хуулийн хариуцлага хүлээлгэ” энэхүү заалтын гол агуулга нь Монгол төрийн үндэс айл, өрх хэмээж айлыг дээдэлсэн төрийн бодлогын үзэл санааг дэвшүүлсэн байна. Ингэхдээ айл баян бол төр улс, нийгэм баян чинээлэг байх болно гэсэн үзэл санааг хуулиар хамгаалсан. Монгол төрийн тулгуур багана 1-рт, өрхийн тэргүүн аав, 2-рт, сурган хүмүүжүүлэгч ээж, 3-рт, ах, дүү, төрөл төрөгсөд ахмад настай хүмүүс, 4-рт, ноёд, түшмэл гэсэн ангилалд хувааж эдгээр хүмүүсийн эрх дархыг хуульчлан хамгаалж оногдох үүргийг нь тодорхой зааж, хүлээх үүрэг хариуцлагыг бий болгожээ. Их засаг хуулийн 21 дүгээр зүйлд Цэргийн албанд мордсон эрчүүдийн ажлыг гэргий нар нь эрхлэн гүйцэтгэх эрхтэй, 26 дугаар зүйлд Хөвгүүд охид эцэг эхээ үл хүндлэгдсэд, гэргий нь эрийнхээ зарлигийг үл дагагсад, харъяат иргэд нь захирагчаа үл хүндлэгсдийг хүндээр шийтгэмой гэсэн ба мөн 46 дугаар зүйлд Эр хүн санааны зоргоор олон эхнэр авч болно. Анхны эхнэр эрхэм хүндтэй, онцгой эрхтэй байна. Энэхүү эрх нь үр хүүхдүүдэд нь хамаарна. Татвар эхнэрээс гарсан хүүхдийг хууль ёсонд тооцож зохих хувь олгож өвлүүлнэ. 47 дугаар зүйлд Ах нь нас барвал дүү нь, дүү нь нас барвал ах нь эхнэрийг нь гэргий болгон авах ба гэргий болгон авахдаа хүрмын ёслол хийнэ. Энэ нь нийгмийн амьдралыг цэгцтэй зохион байгуулалттай байлгах бодлоготой холбоотой ба үр хүүхэд нь өнчирч, эхнэр нь бэлэвсэрч амьдрал ахуй нь доройтохоос сэргийлж, тэдний аж төрөх баталгааг хангахад чиглэжээ. Мөн эцэг эх нь хөвгүүддээ өмч хуваарилаж олгоно, ах нь дүүгээсээ илүү хувь авна, отгон хүү нь эцгийнхээ гал голомтыг өвлөхөөр заасан. Нас барсан хүний өв хөрөнгийг хууль ёсоор залгамжлах эрх бүхий хүнээс өөр хүн уг эрхийг эдэлж болохгүй. Хэрэв нас барагсдыг залгамжлах үр хүүхэд байхгүй бол эд хөрөнгөний талыг нь түүний шавь буюу зарцад нь өгч болно. Байлдааны талбарт амь үрэгдэгсдийг хэрэв боол буюу зарц нь уг газраас авчирсан байвал тэрхүү нас барагсдын мал хөрөнгийг боол буюу зарцад нь өөрт нь олгоно. Харин байлдааны талбараас тэрхүү нас барсан хүнийг өөр хүн авч ирсэн бол нас барагсдын эхнэр болон боол зарц хийгээд мал хөрөнгийг тэр хүнд олгож байх тухай хуулиар зөвшөөрсөн байна.<sup>4</sup>

---

<sup>4</sup> Н.Ням-Очир. Мөнх тэнгэрээс соёрхсон Чингис хааны тайлбар буюу Их засаг хуулийн тайлбар. 2003 он. 125 дахь тал

**Алтан хааны цааз бичигт** гэр бүлийн холбогдолтой зүйл нь: Эр, эм гэр бүлийн хэрэг. Жирэмсэн эхийн ураг хөндөх, эр нь эмийнхээ үсийг тасдах, хувцасыг тасдах, ураг, эр, эмийн аль аль нь самууран явалдах, ор дэвсгэрээс нь татах, эцэг, эх нь элдэв аргаар охиноо эрд өгөх, санаа муутай хүнтэй зөвшилцөх, эр нь эхнэрээ ирт үзүүрт мод, чулуугаар цохих, эм нь эрийгээ ам хэлээр дайрах зэрэгт ес таваар торгох, занчих, нэг бод буюу бог малаар торгох шийтгэл оноохоор заасан.

Мөн заяаны хүргэн болзоот хуримандаа явж байгаад зам зуураа нас нөхчвөл бүсгүйг хүргэний эцэг эх нь авах, бүсгүйн эцэг эх нь мэдэхээр хүүхнийг хоёр хуримлахыг хориглосон байжээ.

**Монгол Ойрдын хуульд** эмэгтэй хүнийг 14 наснаас нөхөрт гарч болохыг зөвшөөрсөн. Ураг тогтсоноос хойш хүүхнийг 20 нас хүртэл хадам нь гэрт аваачихгүй бол хадам эцэг, эхэд нь 3 удаа мэдэгдэх ёстой. Тэгээд амжилт олохгүй бол дараа нь хоёр талын ноёд мэдэгдэж болно. Эдгээр бүх арга авсны дараа хүүхнийг өөр айлд шинээр бэр болохыг зөвшөөрч болох тухай хуульчилжээ. Мөн охиноо эрд гаргахын урьд нөхөр болох хүнээс инж буулгаж сүй авч бай. Хуримласан охин үхвэл инж эдийг өгнө. Эс хуримталсан бол малаа хасаглаж ав. Бэр нь нас барвал инжийг буцаана. Эм хүн дахин хүнтэй хуримлавал морь, тэмээ авахаар заажээ. 9-15 насны эмэгтэй хүүхдийг үрчлэхэд нэг ёс өгнө. Эцэг нь хүүдээ өмч өгөх, өрх тусгаарлан гарах, хүү өв залгамжилж, охин инж авна<sup>5</sup> гэх зэргээр зохицуулсан байна.

**Халх журам хуульд:** 1709-1770 оны хооронд Монголын нөлөө бүхий ноёдын чуулганаар 24 хуулийн эмхтгэл бүхий Халх журам хуулийг баталжээ. Тус хуульд гэр бүлийн талаарх зохицуулалтыг нэг бүлэг болгон хуульчилсан байна. ноёд тавнангуудын охиныг гуйваас мөнгөн аяга, сувд, архи, хүргэвээс тооцно. Үгүй бөгөөс тооцохгүй. Бас харц хүн өөр зуураан сүйлэх аваас архи болоод хонины гэдэс дотор, эвэр туурай, гүйцэд болбоос тооцох гэсэн нь гэр бүл болохын тулд сүй заавал тавих ёстой ба энэ нь гэр бүлийг илүү бат бэх болгоход чиглэсэн байна. эм авсан тул авай уурлаж тавнангаас хагацваас хамт явсан харц эмийг хагацуулъя. Тавнан авайг гээвэл ташуураа барьж гарах. Авай инжээ авч хошуундаа бие мэдэх. Тавнангийн талсан эд малыг хувааж хагасыг нь засагтаа авах, хагасыг нь авайд өгөх. Ноёд ноёдын хатан дор орвоос /явалдах/ ноёд зуураа сүй эвдсэн лугаа адил. Анзаа эс гүйцвээс биеийг нь авъя. Ноёд харц хүний эмд орвоос зуун тавин адуугаар торго. Харц хүн хатан дор орвоос хамаг биеийг нь халаад халуун амийг нь цөм ноёд албатын дотор Хятад барьж өгье. Хятад авай нар нэгэн адил гэж

---

<sup>5</sup> Э.Авирмэд, Д.Дашцэдэн. Монгол хууль. 1997 он. 72 дахь тал

заажээ<sup>6</sup>. Эдгээр заалтууд нь өөр хүний нийгмийн гарлаас шалтгаалж өөр өөр заасан ба хариуцлагын биелэлтийг хангахад чухал ач холбогдолтой байна.

**Монгол цаазын бичиг буюу Хууль зүйлийн бичигт:** гэр бүл, тэжээн тэтгэх харилцаа хэрхэн тусгагдсан талаар: Нөхөр нь эхнэрээ сонгож сүй тавих, эцэг эх нь охиноо эрд өгөхөд дагуул болгон эд хөрөнгө инж өгөх ба богтлох мал инжийн хэмжээг зааж өгчээ. Өөрийн төрсөн эрэгтэй хүүхэдгүй айл овог дотроосоо хүүхэд үрчилж авч болно. Ингэхдээ эцгийн овгийг авч түүний хөрөнгийг залгамжлах боломжтой зэрэгцээ үрчлэлийг заавал бүртгүүлдэг байсан байна. бүртгүүлээгүй бол хүүхдийг заавал буцааж төрүүлсэн эцэг эхэд нь өгдөг байжээ. Галзуурсан хүнийг эцэг эх, өвөг эх, бага авга хийгээд ах дүү өөрийн хөвгүүн ба ач нар ураг төрөлд нь өгч сахиулахаар заасан ба энэ нь асран хамгаалалтыг тогтоосон байна. хэрэв энэ үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хуульд заасны дагуу хариуцах хүн нь эрүүгийн хариуцлага хүлээж байхаар зохицуулжээ.

### **Шинэ үеийн гэр бүлийн эрх зүй**

1926 онд батлагдсан Иргэний хуулийн<sup>7</sup> “гэр бүлийн эрх үүргийн тухай” хэмээх 3 дугаар бүлэг<sup>8</sup> нь бүхэлдээ гэр бүлийн харилцааг зохицуулж байсан. Энэхүү хуулиар гэрлэлт, салалт, төрөлт, нас баралтыг орон нутгийн захиргааны байгууллагаас эрхлэн бүртгэж байхаар тогтсон.

Гуравдугаар бүлэг нь 6 ангитай. Энэ нь:

Нэгдүгээр анги – Аливаа төрсөн, үхсэн, үрчилсэн ба эр эм бололцсон, салсан хүмүүсийг дансанд тэмдэглэсэн нь

Хоёрдугаар анги – Аливаа төрсөн, үхсэн, үрчилсэн ба эр эм бололцсон, салсан этгээдийг данснаа тэмдэглэх заавар

Гуравдугаар анги – Эр эм бололцоход баримтлах зүйлүүд нь

Дөрөвдүгээр анги – Эр эм салалцах тухай

Тавдугаар анги – Эр эмийн завсрын эрх үүргийн тухай

Зургаадугаар анги – Үр хүүхэд, эцэг, эх ба ураг төрлийн хүмүүсийн завсрын эрх үүргийн тухай зэрэг болно.

Гэр бүлийн эрх зүйн гол эх сурвалж нь 1973 онд батлагдсан гэр бүлийн хууль юм. Уг хууль нь бүтцийн хувьд 5 хэсэг 13 бүлэг 113 зүйлээс бүрдэнэ.

---

<sup>6</sup> А.Батбаатар. Гэр бүлийн эрх зүй. 2007 он. 52 дахь тал

<sup>7</sup> Монголын Шүүх. Хууль тогтоомжийн эмхтгэл нэгдүгээр хэсэг. УБ., 2016 он. 297-321 дэх тал

<sup>8</sup> Энэхүү хуулийг арван есөн оны 10-н сард Засгийн газрын 32 дугаар хурлын 4 дүгээр зүйлд баталжээ. Үүнийг 20 дугаар онд Засгийн газрын 52 дугаар сэтгүүлд хэвлүүлэн нийтэлжээ.

Нэгдүгээр бүлэгт үндсэн зүйл, хоёрдугаар бүлэгт гэрлэх үндэс, гуравдугаар бүлэгт гэрлэгсдийн эрх, үүрэг, дөрөвдүгээр бүлэгт гэрлэснийг цуцлах, тавдугаар бүлэгт гэрлэснийг хүчингүйд тооцох, зургаадугаар бүлэгт эцэг, эх, хүүхдийн эрх үүрэг, долоодугаар бүлэгт хүүхэд үрчлэх, наймдугаар бүлэгт эцэг, эх хүүхдээ болон төрөл саднаа тэжээн тэтгэх үүрэг, есдүгээр бүлэгт тэжээн тэтгүүлэх үйл ажиллагаа, аравдугаар бүлэгт улсаас асран хамгаалах, харгалзан дэмжих тухай ойлголт, арваннэгдүгээр бүлэгт хүүхдээ гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, арванхоёрдугаар бүлэгт иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, арвангуравдугаар бүлэгт тус улсад суугаа гадаадын харъяат буюу аль ч улсын биш иргэдийн гэр бүлийн байдлыг бүртгэх зэрэг гэр бүлийн харилцаанд үүсэх асуудлуудыг багтаан хуульчилсан байдаг.

### **Нэн шинэ үеийн гэр бүлийн эрх зүй /1990-ээд он/**

Монгол Улсад өрнөсөн улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэл нь социалист байгуулалтын харилцааг зохицуулж байсан хууль тогтоомжийг үндсээр нь өөрчлөн шинэчлэх бодит шаардлагад хүргэсэн. Иймд хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах зорилтыг тодрхойлсон энэ үеийн төр, нийгэм, эдийн засаг, ард олны оюун санааны харилцааны эрх зүйн үндсийг бататгасан Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг баталсан. Монгол Улсын Үндсэн хуульд гэр бүлийн харилцааны талаар дараах заалтууд багтсан байдаг. Энэ нь

1. ... гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй.
2. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ.
3. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх журамт үүрэгтэй.
4. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашиг сонирхлыг төр хамгаална.
5. ...хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд мөнгөний тусламж авах эрхтэй зэрэг болно.

Ингээд 1999 онд Ардчилсан Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийг баталсан.

Өнөөдөр мөрдөж буй Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд<sup>9</sup> “гэр бүл гэж гэрлэлтийн үр дүн бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг. Энэ хуулийн зорилтыг гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцөлийг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд өрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран

---

<sup>9</sup> 1999 оны 06 дугаар сарын 11-ний өдөр батлагдаж, 1999 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн.

хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино хэмээн тодорхойлоод гэр бүлийн харилцаатай холбоотой нэр томъёог дараах байдлаар тайлбарлан тусгасан байна.

"Гэрлэлт"- гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоср, сайн дурын, чөлөөтэй тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг;

"Гэрлэгчид"-гэж гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг;

"Гэр бүлийн гишүүн"-гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг;

"Төрлийн хүн"-гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ас охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг;

"Садангийн хүн"-гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг;

"Овог"-гэж нэг өвөг дээдсээс гаралтай эцгийн талын холбоо бүхий бүлэг хүмүүсийн дунд үе уламжлан хэрэглэгддэг нэрийг ойлгоно.

*Хүснэгт 2.Эцэг эх, хүүхдээ тэжээн тэтгэх харилцааны зохицуулалтыг гэр бүлийн тухай хуулиудад хэрхэн тусгагдсан талаарх харьцуулалт*

№	Батлагдсан он, бүлэг, зүйл	Хуулийн зорилт	Эцэг эхийн хүлээх үүрэг	Хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой зохицуулалт
1	1928 оны Иргэний хууль нь 10 бүлэг 217 зүйлтэй ба гэр бүлийн эрх, үүргийн тухай 6 анги 27 зүйлийг багтаасан байна.	Тус улсын дотор аливаа төрсөн, үрчилсэн, үхсэн ба эр эм бололцон, салсны тухай зэргийг нарийн нягт тодорхойлж, хойч өдөр байцаах тэмдэг болговоос зохих тул орон нутгийн захиргааны газрууд өрх амын дансанд оруулан тэмдэглэвээс зохимой гэснийг тайлбарлавал: эр эм бололцох зэргийг тусгай	Эцэг эх болбоос өөрийн насанд хүрээгүй үр хүүхдээ сурган боловсруулах, алсдаа ард улсад тустай хүмүүнийг бэлтгэх эрх ашигийг хамгаалах мөн болох тулд шүүх таслах буюу бусад газар аливаа хэргийн учир төлөөлвөөс зохимой. Эцэг эх нь хүүхдийнхээ сурч боловсрох	Аливаа эхнэр хүүхэд төрүүлсний хойно түүний эцгийг нэр зааж илтгэсүгэй хэмээх авхул шүүх туслах газраа мэдүүлэх бөгөөд тийнхүү нэр заасан эцэг болох хүмүүнээс хүүхдийг тэтгүүлэх ба тэжээх сурган хүмүүжүүлэх тухайн зарлага сүйтгэлийг гаргалцуулахаас гадна эхийн жирэмсэн явсан цагийн ба хүүхэд



		тэмдэглэх явдлыг эдүгээ гүйцэтгэхийн уг бодлого болвоос хүмүүний завсартаа харилцах эрх үүргийг тодорхойлж эр эм, хүүхдийн эрх ашгийг тус тус хамгаалах хэргийг дөхмөөр явуулах бодлого	эрх ашгийг нь хамгаалах үүрэгтэй төдийгүй энэ үүргийг хамтдаа гүйцэтгэх ёстойг зааж өгсөн.	төрүүлсний хойно зургаан сарын хугацаанд амьдрал зэрэгт зарцуулсан ба зарцуулах зүйлийг мөн эцгээс гаргалцуулваас зохимой гэжээ.
2	1958 оны Гэрлэх ба гэр бүл, асрамж тэтгэмжийн хууль нь 4 анги 116 зүйлтэй.	БНМАУ-ын ард иргэн гэрлэхдээ харилцан сэтгэлтэйгээ илэрхийлэн эрх тэгш, бие биеэ хүндэтгэн амьдралаа үүрд сайн дураараа нэгтгэн бие биеэ дэмжин нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, гэр бүл болж эрэгтэй эмэгтэй зөвхөн 2 хүний ханилан суух зарчмыг баримталж, түүнчлэн гэрлэгсэд тэдний үр хүүхдийн амин хувийн ба эд хөрөнгийн эрх, ашгийг хамгаалах зорилгоор гэрлэснээ иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх газар заавал бүртгүүлэх ёстой.	Эцэг эх нв насанд хүрээгүй хүүхдийнхээ эрүүл мэнд, биеийн бойжилт зөв хүмүүжлийн төлөө санаачлах ба түүнийг сургах, нийгэмд ашиг тустай ажил хийх явдалд бэлтгэх үүрэгтэй. Үр хүүхдэд холбогдсон бүхий л арга хэмжээг эцэг эх хоёроос хамтран гүйцэтгэвэл зохино.	Хүүхдийн тэтгэвэр олгохдоо насанд хүрээгүй нэг хүүхдэд хариуцагчийн сар тутмын орлогын 25 хувийг, хоёр хүүхдэд 35 хувийг, 3 ба түүнээс дээш хүүхдэд бол 50 хувиар бодож гаргуулвал зохино. Биеийн хүчээ үнэлдэггүй хүмүүсээс тэтгэвэр гаргуулахдаа жилийн бүх орлогоос нь энэ зүйлд заасан хувиар бодож гаргуулна. Хөдөлмөрийн чадваргүй, гачигдаж байгаа, насанд хүрсэн хүүхдэд эцэг эхээс нь тэтгэвэр гаргуулахдаа тэтгэх хөрөнгийн байдлыг харгалзан шүүх тогтоовзол зохино гэж заажээ.

3	1973 оны Гэр бүлийн хууль нь 5 хэсэг 13 бүлэг, 113 зүйлтэй.	Коммунист ёс суртахууны зарчмаар үүссэн гэр бүлийг дэмжин бэхжүүлэх эцэг эх, үр хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүний эрх ашгийг хамгаалах, гэрлэгсдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг дээшлүүлэн гэр бүл, гэр ахуйн харилцаанд үлдсэн аливаа хоцрогдмол дадал заншлыг арилгахад оршино.	Хууль ёсоор тогтоосон эцэг эх, хүүхдийн хооронд энэ хуульд заасан эрх, үүрэг үүснэ. Эцэг эх нь хүүхдээ асран хамгаалж, тэжээн тэтгэж өсгөн хүмүүжүүлэх үүрэгтэй. Эцэг эх гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд энэ үүрэг хэвээр хадгалагдана. Насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн хувьд эцэг эх хүүхдийнхээ эрх ашгийг шүүх болон улс олон нийтийн бусад байгууллагын өмнө хариуцан хамгаална.	Насанд хүрээгүй хүүхдэд тэжээн тэтгүүлэх, тэтгэвэр гаргуулахдаа шүүх тэтгэвэр авах хүүхдийн тоо, хариуцагч болон хүүхэд гардан хүмүүжүүлэгчийн орлого, аж ахуйн чадвар, хөдөлмөрийн чадваргүй хүмүүсийн тоог харгалзан хариуцагчийн сар бүрийн цалингаас /орлого/ нэг хүүхдэд 15-25 хувь хүртэл, хоёр хүүхдэд 35 хувь хүртэл, гурав буюу түүнээс дээш тооны хүүхдэд 50 хувь хүртэл хэмжээгээр тогтооно. Тэжээн тэтгэх тэтгэврийг гагцхүү хүүхдийн хэрэгжээнд зарцуулна.
4	1999.06.11-ний өдөр батлагдсан гэр бүлийн тухай хууль нв 9 бүлэг 76 зүйлтэй.	Хуулийн зорилт нь гэрлэх нөхцөл журам, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, түүний үр дагавар, эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаа, тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа, хүүхэд	Эцэг эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Эцэг эх харилцан тохиролцож чадаагүй бол шүүх тэтгэлгийг тогтооно.	Хүүхдийн тэтгэлгийг 11 нас хүртлэх хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар, 11-16 нас /суралцаж бйагаа бол 18-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй/ хүүхдэд амьжиргааны доод түвшингийн

		үрчлэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.		хэмжээгээр зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй тэтгэлгийг мөнгөн хэлбэрээр олгоно. Тэтгэлгийг сар, улирал, хагас жил, жилээр нэг удаа олгоно.
--	--	---	--	---

Дээрх харьцуулсан хүснэгтээс харахад эцэг эхийн хүүхдээ тэжээн тэтгэх харилцаа нь ардын хувьсгал ялсан тусгаар тогтносон улс болсноос эхлэн хуулиар зохицуулагдаж байсан нь тодорхой харагдаж байна. 1973 оны гэр бүлийн хуульд дээр дурдсан нэгдүгээр аргын үндсэн дээр буюу тэжээгчийн сар бүрийн цалингаас /орлого/ нэг хүүхдэд 15-25 хувь, хоёр хүүхдэд 35 хувь хүртэл, гурав ба түүнээс дээш тооны хүүхдэд 50 хувь хүртэл хэмжээгээр тогтоодог байжээ. Харин манай улс зах зээлийн харилцаанд шилжсэнтэй уялдан ажилгүйдэл нилээд их хувийг эзлэх болсон учраас тэтгэлэг төлөгч, тэжээгч ажилгүй, цалин орлогогүй болсон гэсэн үндэслэлээр хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй, хүүхдийн эрх ашиг зөрчигдөх болсон. Тийм учраас УИХ-аас 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг батлахдаа хүүхэд тус бүрт тухайн нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр буюу тодорхой мөнгөн дүнг тогтоож өгдөг болсон байна. Түүнчлэн дээрх байдлаар тогтоосон хэмжээний тэтгэлгийг мөнгөн хэлбэрээр үү эсвэл эд хөрөнгөөр олгох уу гэдэгт тэжээгч, тэтгүүлэгч харилцан тохиролцож болох боломжийг олгосон байна.

## **1.2.Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

Гэр бүлийн харилцаа нь зөвхөн эд хөрөнгийн бус нийгэм, соёл, зан үйлд чиглэсэн олон талт харилцаа байдаг. Монгол Улсын тухайд гэр бүлийн харилцаа, тэр дундаа үр хүүхдээ тэжээн тэтгэхтэй холбоотой дараа эрх зүйн зохицуулалт байдаг.

### ***Нэг. Монгол Улсын Үндсэн хууль:***

Арван долдугаар зүйл.

2.Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.

### ***Хоёр.Иргэний хууль:***

Гуравдугаар дэд бүлэг.Гэр бүлийн хөрөнгийн эрх

125 дугаар зүйл. Гэр бүлийн хөрөнгө, түүний зохицуулалт

125.1.Гэр бүлийн хөрөнгө нь гэрлэгчдийн, гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөөс бүрдэнэ.

125.2.Гэрлэгчдийн хөрөнгийн эрхийн зарим харилцааг гэрээгээр зохицуулж болно.

126 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө

126.1.Гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч мөн.

126.2.Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчид дараахь хөрөнгө хамаарна:

126.2.1.гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн болон тэдгээрийн хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон болон бусад орлого, мөнгөн хуримтлал, шинээр бий болсон хөрөнгө;

126.2.2.гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн орлогоор олж авсан үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө;

126.2.3.ногдол хувь, үнэт цаас;

126.2.4.гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө;

126.2.5.гэр бүлийн гишүүн өөрийн хуваарьт хөрөнгөөс дундаа хамтран өмчлөхөд зориулж шилжүүлсэн хөрөнгө, мөнгөн хуримтлал.

126.3.Гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгийг гэр бүлийн бусад гишүүд их засвар хийсэн, шинэчилсэн, өөрчлөн тоноглогсны улмаас үнэ нь үлэмж нэмэгдсэн, эсхүл анх гэр бүл болоход нь зориулагдсан /орон сууц, гэр, хашаа, байшин зэрэг/ бол хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болгон тогтоож болно.

126.4.Гэрлэснээс хойш гэр ахуйн ажил эрхэлсэн, хүүхэд асарсан, өвчтэй байсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн хөрөнгөө хамтран өмчлөх эрх эдэлнэ.

127 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгө

127.1.Гэр бүлийн гишүүний дараахь хөрөнгийг хамтран өмчлөх дундын өмчлөлд шилжүүлэхээр тохиролцоогүй бол хуваарьт хөрөнгөд хамаарна:

127.1.1.гэрлэхийн өмнө олж авсан эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, эд хөрөнгийн эрх;

127.1.2.өв, бэлэглэлийн журмаар шилжүүлэн авсан мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг худалдсан, арилжсаны үр дүнд олж авсан эд хөрөнгө, мөнгө;

127.1.3.амин хувийн хэрэгцээг хангахад зориулсан эд хөрөнгө;

127.1.4.оюуны өмчлөлийн зүйлийн үнэ буюу зохиогчийн шагнал;

127.1.5.хувийн авъяас, чадвар, ололт амжилтыг сайшаан шагнасны орлого;

127.1.6.хуваарьт эд хөрөнгөөрөө олж авсан, мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хөрөнгө, мөнгө.

127.2.Гэр бүлийн гишүүн хуваарьт эд хөрөнгөө өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй.

127.3.Гэр бүлийн гишүүд өөрөөр тохиролцоогүй бол тэдгээр нь хувийн үйл ажиллагаатай холбогдсон үүргээ өөрийн хуваарьт эд хөрөнгөөрөө хариуцна.

128 дугаар зүйл. Хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах

128.1.Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

128.2.Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна.

128.3.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 128.2-т заасны дагуу зөвшөөрөл аваагүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

128.4.Гэрлэснээс хойш гэр бүлийн гишүүний хэн нэг нь эд хөрөнгөө дур мэдэн бусдад шилжүүлсэн, олсон ашиг, орлогоо санаатайгаар нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсэн гэр бүлийн гишүүн зөрчигдсэн эрхээ сэргээлгэх эрхтэй.

129 дүгээр зүйл. Гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох

129.1.Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг дараахь тохиолдолд тодорхойлно:

129.1.1.гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарахад ногдох хэсгийн талаар маргавал;

129.1.2.гэрлэгчдээс төлбөр гаргуулахад тэдгээрийн хуваарьт эд хөрөнгө хүрэлцэхгүй бол;

129.1.3.гэр бүлийн бусад гишүүнээс төлбөр гаргуулбал;

129.1.4.гэр бүлийн гишүүн нас барснаар өв нээгдсэн бол.

129.2.Гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэмжээ нь насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна.

129.3.Гэрлэлт цуцалсан буюу гэрлэлтийг хүчингүйд тооцсоноос гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно.

129.4.Энэ хуулийн 129.3-т зааснаас бусад гэр бүлийн гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болгоход оруулсан түүний хөдөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан багасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж болно.

129.5.Гэр бүлийн гишүүн нь цэргийн жинхэнэ алба хаах, сургуульд суралцах, удаан хугацаагаар өвчлөх зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бүрэлдэхэд хөдөлмөрөөр буюу хөрөнгөөрөө оролцож чадаагүй бол энэ хуулийн 129.4 дэх хэсэг хамаарахгүй.

129.6.Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

129.7.Гэр бүлийн гишүүдийн хамтран олсон, эсхүл гэр бүлийн гишүүний хэн нэгний хүлээх үүргийн дагуу олсон ашиг орлогыг гэр бүлийн хэрэгцээнд ашигласан нь нотлогдсон бол гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болох бөгөөд уг эд хөрөнгө хүрэлцэхгүй бол гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгөөс гаргуулна.

129.8.Бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс, олсон ашиг орлогоо гэр бүлийн бусад гишүүдийн хуваарьт эд хөрөнгөд, эсхүл хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд шилжүүлсэн нь нотлогдсон бол тэр хэмжээгээр уг эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно.

130 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах

130.1.Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг гэрлэгчдийн хэн нэгний буюу гэр бүлийн насанд хүрсэн бусад гишүүний шаардлагаар гэрлэлт хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэлт цуцалсны дараа, эсхүл гэр бүлийн гишүүн хэн нэгний нь хуваарьт эд хөрөнгө төлбөр гаргуулахад хүрэлцэхгүй бол нэхэмжлэгчийн шаардлагаар хувааж болно.

130.2.Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө харилцан тохиролцох журмаар хувааж болно.

130.3.Маргаан гарсан тохиолдолд гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс гэр бүлийн гишүүнд ногдох хэсгийг шүүх тогтоох бөгөөд энэ нөхцөлд гэр бүлийн гишүүний хэнд нь ямар хөрөнгө шилжихийг тодорхойлж аль нэг гишүүнд шилжүүлсэн хөрөнгийн үнэ нь түүнд ногдох хэсгээс давсан бол үнийн зөрүүг бусдад нь олгож болно.

131 дүгээр зүйл. Гэр бүлийн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарах

131.1.Гэр бүлийн нэг буюу хэд хэдэн гишүүн гэр бүлийн бүрэлдэхүүнээс гарвал хамтран өмчлөх дундын хөрөнгөөс ногдох хэсгээ авах боловч гэр бүлийн аж ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах хөрөнгийг авах эрхгүй.

131.2.Ногдох хэсгийг эд хөрөнгөөр өгөх боломжгүй бол үнийг нь төлнө.

132 дугаар зүйл. Гэрлэгчид хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулах

132.1.Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох хөрөнгийг тодорхойлох, хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг энэ хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болно.

132.2.Гэрлэгчид хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлэх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

132.3.Гэрлэгчид хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг гэрлэлтээ бүртгүүлэхийн өмнө болон гэрлэсний дараа хэдийд ч байгуулж болно.

132.4.Гэрлэлтээ бүртгүүлэхийн өмнө байгуулсан гэрээ гэрлэлтийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

132.5.Гэрлэгчид гэрээндээ хөрөнгийн бус харилцааг зохицуулсан, гэрлэгчдийн хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илтэд доройтуулсан, эрхийн чадамжийг хязгаарласан нөхцөл тусгахыг хориглоно.

133 дугаар зүйл. Гэрээг өөрчлөх, цуцлах

133.1.Гэрлэгчдийн тохиролцсоноор, эсхүл эхнэр, нөхрийн аль нэгний шаардсаны дагуу шүүхийн шийдвэрээр гэрээг цуцалж болох бөгөөд гэрээг өөрчлөх, цуцлах тухай тохиролцоог анхны гэрээтэй адил хэлбэрээр хийнэ.

***Гурав.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль:***

Арван хоёрдугаар бүлэг.Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

125 дугаар зүйл.Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх

125.1.Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасны дагуу ердийн журмаар шийдвэрлэнэ.

125.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан үндэслэлээр эвлэрүүлэн зуучлал дуусгавар болж, шүүхэд нэхэмжлэл гаргасан бол энэ хуульд заасны дагуу шүүх ердийн журмаар шийдвэрлэнэ.

125.3.Энэ хуулийн 125.2-т заасан үндэслэлээр хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх явцад эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дахин явуулж болно.

126 дугаар зүйл.Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл

126.1.Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

126.2.Нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй буюу тахир дутуу, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газар очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

126.3.Зохигч маргааныг хэний оршин суугаа газрын шүүхэд шийдвэрлүүлэхийг тохиролцон тогтоож болно.

126.4.Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлд гэрлэгчдийн овог, эцгийн нэр, нэр, гэрлэлтээ хэзээ, хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлуулах шалтгаан, насанд хүрээгүй хүүхэдтэй бол түүний нэр, төрсөн он, сар, өдөр, түүнчлэн насанд хүрээгүй хүүхдийг хүмүүжүүлэх, түүнд асрамж тогтоох, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаархи хүсэлт, энэ талаар хоорондоо хэлэлцэн тохиролцсон гэрээ байгаа эсэхийг зааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

127 дугаар зүйл.Тэтгэвэр гаргуулах ба гэрлэгчдийн дундын эд хөрөнгө хуваах

127.1.Гэрлэлт цуцлах үед эхнэр буюу нөхөр нь хүнд өвчтэй, хөдөлмөрийн чадваргүй, эдийн засгийн хувьд зайлшгүй туслалцаа шаардлагатайгаас тэтгэвэр гаргуулах, хамтран өмчлөх дундын эд



хөрөнгө хуваах, насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх талаар гарсан маргааныг шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж болно.

128 дугаар зүйл. Гэрлэгчдийн эд хөрөнгийн буюу тэжээн тэтгэх гэрээг биелүүлэх тухай шүүгчийн захирамж гаргах

128.1. Гэрлэгчид харилцан тохиролцож эд хөрөнгийн болон тэжээн тэтгэх тухай гэрээг тус тус байгуулсан бөгөөд тэдгээрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд аль нэг талын хүсэлтээр эдгээр гэрээг биелүүлэхтэй холбогдуулан шүүгч захирамж гаргана.

129 дүгээр зүйл. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ

129.1. Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ дараахь арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно:

129.1.1. насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх;

129.1.2. насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах;

129.1.3. гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах;

129.1.4. гэрлэгч хэн нэгийг тэжээн тэтгүүлэх;

129.1.5. орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох;

129.1.6. шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх;

129.1.7. зохигчид эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрэх хугацаа заах.

130 дугаар зүйл. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох, дуусгавар болгох

130.1. Шүүгч энэ хуулийн 129 дүгээр зүйлд заасан гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг зохигчийн хүсэлтээр өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.

130.2. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ дараахь нөхцөлд дуусгавар болсонд тооцно:

130.2.1. гэрлэгчид эвлэрч шүүгч эвлэрлийг баталсан захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгосон;

130.2.2. гэрлэлт цуцлах, тэжээн тэтгэхтэй холбогдсон хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарсан.

131 дүгээр зүйл. Гэрлэгчид шүүх хуралдаанд ирэх

131.1.Зохигчийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа ч гэсэн гэрлэгчид өөрсдөө шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй.

131.2.Гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулж болно.

131.3.Гэрлэгчид хоёр дахь удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэргийг хариуцагчийн байхгүйд хянан шийдвэрлэж болно. Харин нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд нэхэмжлэлийг буцаана.

131.4.Хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийгөө байхгүйд хэрэг хянан шийдвэрлэхийг хүсч энэ тухай бичгээр мэдэгдсэн бол нэхэмжлэгчийг оролцуулалгүй шүүх хуралдаанаар нэхэмжлэлийг хянан шийдвэрлэнэ.

132 дугаар зүйл.Гэрлэлт цуцлах тухай хэрэг хянан шийдвэрлэх

132.1.Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна.

132.2.Энэ хуулийн 132.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон байх нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах үндэслэл болохгүй.

132.3.Гэрлэгчид эвлэрвэл шүүгч эвлэрлийг баталсан захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгоно.

132.4.Харин Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч энэ хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.

3. Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй удааширч байгаа шалтгааныг та хэрхэн үздэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 20% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 70% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, 10% нь бусад, **төлбөр авагчдын** 10% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 70% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, 20% нь бусад шалтгааны улмаас удааширч байна гэж үзжээ.



4.1. Хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 10% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нь бүрэн тогтоож, хураан авах, 75% нь төлбөр төлөгч этгээдийг албадан ажил хийлгэж, цалин хөлсийг нь тооцох, 15% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд шийтгэл оногдуулах гэсэн хариултыг өгчээ.




4.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөө та ямар хэлбэрээр авах сонирхолтой байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 80% нь бэлэн мөнгөөр, 10% нь эд хөрөнгөөр, 10% нь хүүхдийн данс руу шилжүүлэн, хадгалах гэсэн хариултыг өгсөн байна.



5.1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг сайжруулах талаарх таны бодол? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 50% нь төрөөс хүүхдийн тэтгэлгийн мөнгийг эхний ээлжинд бүрэн гарган, төлбөр авагчийн дансанд шилжүүлэн, дараа нь тэтгэлэг төлөгчөөс шийдвэр гүйцэтгэгч албадан гаргуулж, төрийг хохиролгүй болгох, 20% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг бүрэн тогтоож, хөрөнгөнөөс албадан гаргуулах, 30% нь төлбөр төлөгчийг албадан хөдөлмөр эрхлүүлж, тэтгэлгийг гаргуулах арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.




5.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөний таны амьдралд үзүүлэх нөлөө юу вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 20% нь амьжиргааны эх үүсвэр, 50% нь хүүхдийнхээ ирээдүйд зориулан хадгалдаг, 20% нь хүүхдийнхээ хэрэглээнд зарцуулдаг, 10% нь өдөр тутмын хэрэглээндээ хэрэглэдэг гэсэн хариултыг өгсөн байна.



## 2.2.17. Увс аймаг

Тус аймаг нь 2019 оны байдлаар 83,223 хүн амтай гэж бүртгэгдсэн ба хүн амын тоогоор улсын хэмжээнд 12 дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн онд 600 гэрлэлт, 29 гэр бүл цуцлалт бүртгэгдсэн байна.

### а/ 2010-2019 оны хүүхдийн тэтгэлэг барагдуулалтын байдал




б/ Иргэд, төлбөр авагчдаас авсан санал асуулгын дүн: Нийт 25 иргэн, 25 төлбөр авагчаас 5 асуулт бүхий санал асуулга авахад дараах байдлаар хариулжээ. Үүнд:


1. Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийн хувь хэмжээний талаарх таны санал? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 40% нь хангалттай, 40% нь хангалтгүй, 16% нь холбогдох хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай, 4% нь сайн мэдэхгүй байна гэсэн бол **төлбөр авагчдын** 24% нь хангалттай, 68% нь хангалтгүй, 8% нь холбогдох хуульд тэтгэлгийн хувь хэмжээг нэмэх талаар өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн хариултыг өгсөн байна.




2. Шийдвэр гүйцэтгэгчээс хүүхдийн тэтгэлэг гаргуудах талаар гүйцэтгэж буй байдалд өгөх таны үнэлгээ? гэсэн асуултанд судалгаанд оролцогч **иргэдийн** 44% нь сайн, 48% нь дунд зэрэг, 8% нь хангалтгүй гүйцэтгэдэг гэсэн бол **төлбөр авагчдын** 60% нь сайн, 40% нь дунд зэрэг гүйцэтгэдэг гэсэн хариултыг өгсөн байна.




3. Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй удааширч байгаа шалтгааныг та хэрхэн үздэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 4% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 52% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 44% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, **төлбөр авагчдын** 16% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хийж чадахгүй байна, 32% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 52% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул тул удааширч байна гэж үзжээ.



4.1. Хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 20% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нь бүрэн тогтоож, хураан авах, 52% нь төлбөр төлөгч этгээдийг албадан ажил хийлгэж, цалин хөлсийг нь тооцох, 28% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд шийтгэл оногдуулах, 10% нь бусад гэсэн хариултыг өгчээ.




4.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөө та ямар хэлбэрээр авах сонирхолтой байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 64% нь бэлэн мөнгөөр, 20% нь эд хөрөнгөөр, 12% нь хүүхдийн данс руу шилжүүлэн, хадгалах, 4% нь ямар ч хэлбэрээр хамаагүй авах нь чухал биш гэсэн хариултыг өгсөн байна.



5.1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг сайжруулах талаарх таны бодол? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 28% нь төрөөс хүүхдийн тэтгэлгийн мөнгийг эхний ээлжинд бүрэн гарган, төлбөр авагчийн дансанд шилжүүлэн, дараа нь тэтгэлэг төлөгчөөс шийдвэр гүйцэтгэгч албадан гаргуулж, төрийг хохиролгүй болгох, 44% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг бүрэн тогтоож, хөрөнгөнөөс албадан гаргуулах, 20% нь төлбөр төлөгчийг албадан хөдөлмөр эрхлүүлж, тэтгэлгийг гаргуулах, 8% нь бусад арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.



5.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөний таны амьдралд үзүүлэх нөлөө юу вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 20% нь амьжиргааны эх үүсвэр, 64% нь хүүхдийнхээ ирээдүйд зориулан хадгалдаг, 12% нь хүүхдийнхээ хэрэглээнд зарцуулдаг, 4% нь чухал биш гэсэн хариултыг өгсөн байна.






## 2.2.18.Төв аймаг

Тус аймаг нь 2019 оны байдлаар 94,250 хүн амтай гэж бүртгэгдсэн ба хүн амын тоогоор улсын хэмжээнд 9 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Мөн онд 423 гэрлэлт, 63 гэр бүл цуцлалт бүртгэгдсэн байна.

### а/ 2010-2019 оны хүүхдийн тэтгэлэг барагдуулалтын байдал




**б/ Иргэд, төлбөр авагчдаас авсан санал асуулгын дүн:** Нийт 20 иргэн, 13 төлбөр авагчаас 5 асуулт бүхий санал асуулга авахад дараах байдлаар хариулжээ. Үүнд:

1. Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийн хувь хэмжээний талаарх таны санал? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 65% нь хангалттай, 5% нь хангалтгүй, 10% нь холбогдох хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай, 20% нь сайн мэдэхгүй байна гэсэн бол **төлбөр авагчдын** 69,2% нь хангалттай, 15,3% нь хангалтгүй, 15,3% нь холбогдох хуульд тэтгэлгийн хувь хэмжээг нэмэх талаар өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн хариултыг өгсөн байна.




2. Шийдвэр гүйцэтгэгчээс хүүхдийн тэтгэлэг гаргуудах талаар гүйцэтгэж буй байдалд өгөх таны үнэлгээ? гэсэн асуултанд судалгаанд оролцогч **иргэдийн** 65% нь сайн, 35% нь дунд зэрэг гүйцэтгэдэг гэсэн бол **төлбөр авагчдын** 69,2% нь сайн, 23% нь дунд зэрэг, 7,6% нь хангалтгүй гүйцэтгэдэг гэсэн хариултыг өгсөн байна.




3. Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй удааширч байгаа шалтгааныг та хэрхэн үздэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 5% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 40% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 50% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, 5% нь бусад, **төлбөр авагчдын** 30,7% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 23% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 46,1% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул тул удааширч байна гэж үзжээ.



4.1. Хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 10% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нь бүрэн тогтоож, хураан авах, 65% нь төлбөр төлөгч этгээдийг албадан ажил хийлгэж, цалин хөлсийг нь тооцох, 25% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд шийтгэл оногдуулах гэсэн хариултыг өгчээ.




4.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөө та ямар хэлбэрээр авах сонирхолтой байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 15,3% нь бэлэн мөнгөөр, 23% нь эд хөрөнгөөр, 46,1% нь хүүхдийн данс руу шилжүүлэн, хадгалах, 15,3% нь ямар ч хэлбэрээр хамаагүй авах нь чухал биш гэсэн хариултыг өгсөн байна.



5.1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг сайжруулах талаарх таны бодол? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 10% нь төрөөс хүүхдийн тэтгэлгийн мөнгийг эхний ээлжинд бүрэн гарган, төлбөр авагчийн дансанд шилжүүлэн, дараа нь тэтгэлэг төлөгчөөс шийдвэр гүйцэтгэгч албадан гаргуулж, төрийг хохиролгүй болгох, 30% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг бүрэн тогтоож, эд хөрөнгөнөөс нь албадан гаргуулах, 60% нь төлбөр төлөгчийг албадан хөдөлмөр эрхлүүлж, тэтгэлгийг гаргуулах арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.




5.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөний таны амьдралд үзүүлэх нөлөө юу вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 53,8% нь хүүхдийнхээ ирээдүйд зориулан хадгалдаг, 46,1% нь хүүхдийнхээ хэрэглээнд зарцуулдаг гэсэн хариултыг өгсөн байна.



## 2.2.19.Ховд аймаг


Тус аймаг нь 2019 оны байдлаар 89,712 хүн амтай гэж бүртгэгдсэн ба хүн амын тоогоор улсын хэмжээнд 10 дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн онд 615 гэрлэлт, 43 гэр бүл цуцлалт бүртгэгдсэн байна.

### а/ 2010-2019 оны хүүхдийн тэтгэлэг барагдуулалтын байдал




б/ Иргэд, төлбөр авагчаас авсан санал асуулгын дүн: Нийт 16 иргэн, 13 төлбөр авагчаас 5 асуулт бүхий санал асуулга авахад дараах байдлаар хариулжээ. Үүнд:

1. Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийн хувь хэмжээний талаарх таны санал? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 68,7% нь хангалттай, 18,7% нь хангалтгүй, 12,6% нь холбогдох хуульд тэтгэлгийн хувь хэмжээг нэмэх талаар өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн бол **төлбөр авагчдын** 23% нь хангалттай, 46% нь хангалтгүй, 31% нь холбогдох хуульд тэтгэлгийн хувь хэмжээг нэмэх талаар өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн хариултыг өгсөн байна.




2. Шийдвэр гүйцэтгэгчээс хүүхдийн тэтгэлэг гаргуудах талаар гүйцэтгэж буй байдалд өгөх таны үнэлгээ? гэсэн асуултанд судалгаанд оролцогч **иргэдийн** 68,7% нь сайн гүйцэтгэдэг, 18,7% нь дунд зэрэг, 12,6% нь хангалтгүй гүйцэтгэдэг гэсэн бол **төлбөр авагчдын** 31% нь сайн гүйцэтгэдэг, 54% нь дунд зэрэг, 15% нь хангалтгүй гүйцэтгэдэг гэсэн хариултыг өгсөн байна.



3. Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй удааширч байгаа шалтгааныг та хэрхэн үздэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 6,2% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 37,5% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 56,3% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, **төлбөр авагчдын** 46% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 31% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 23% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул тул удааширч байна гэж үзжээ.




4.1. Хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 25% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийн бүрэн тогтоож, хураан авах, 75% нь төлбөр төлөгч этгээдийг албадан ажил хийлгэж, цалин хөлсийг нь тооцох гэсэн хариултыг өгчээ.




4.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөө та ямар хэлбэрээр авах сонирхолтой байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 61,5% нь бэлэн мөнгөөр, 31% нь хүүхдийн данс руу шилжүүлэн, хадгалах, 7,5% нь ямар ч хэлбэрээр хамаагүй авах нь чухал биш гэсэн хариултыг өгсөн байна.






5.1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг сайжруулах талаарх таны бодол? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 18,7% нь төрөөс хүүхдийн тэтгэлгийн эхний ээлжинд бүрэн гарган, төлбөр авагчийн дансанд шилжүүлэн, дараа нь тэтгэлэг төлөгчөөс шийдвэр гүйцэтгэгч албадан гаргуулж төрийг хохиролгүй болгох, 12,5% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг бүрэн тогтоож, эд хөрөнгөнөөс нь албадан гаргуулах, 68,7% нь төлбөр төлөгчийг албадан хөдөлмөр эрхлүүлж, тэтгэлгийг гаргуулах арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.




5.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөний таны амьдралд үзүүлэх нөлөө юу вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 38,4% нь хүүхдийнхээ ирээдүйд зориулан хадгалдаг, 53,8% нь хүүхдийнхээ хэрэглээнд зарцуулдаг, 7,8% нь өдөр тутмын хэрэглээнд зарцуулдаг гэсэн хариултыг өгсөн байна.



## 2.2.20.Хөвсгөл аймаг

Тус аймаг нь 2019 оны байдлаар 135,095 хүн амтай гэж бүртгэгдсэн ба хүн амын тоогоор улсын хэмжээнд 2 дугаарт эрэмбэлэгдэж байна. Мөн онд 710 гэрлэлт, 113 гэр бүл цуцлалт бүртгэгдсэн байна.

### а/ 2010-2019 оны хүүхдийн тэтгэлэг барагдуулалтын байдал




**б/ Иргэд, төлбөр авагчдаас авсан санал асуулгын дүн:** Нийт 20 иргэн, 11 төлбөр авагчаас 5 асуулт бүхий санал асуулга авахад дараах байдлаар хариулжээ. Үүнд:

1. Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийн хувь хэмжээний талаарх таны санал? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 60% нь хангалттай, 25% нь хангалтгүй, 15% нь сайн мэдэхгүй байна гэсэн бол **төлбөр авагчдын** 63,6% нь хангалттай, 36,3% нь хангалтгүй, 9% нь холбогдох хуульд тэтгэлгийн хувь хэмжээг нэмэх талаар өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн хариултыг өгсөн байна.



2. Шийдвэр гүйцэтгэгчээс хүүхдийн тэтгэлэг гаргуудах талаар гүйцэтгэж буй байдалд өгөх таны үнэлгээ? гэсэн асуултанд судалгаанд оролцогч **иргэдийн** 70% нь сайн гүйцэтгэдэг, 30% нь дунд зэрэг гүйцэтгэдэг гэсэн бол **төлбөр авагчдын** 45,5% нь сайн гүйцэтгэдэг, 36,3% нь дунд зэрэг, 18,2% нь хангалтгүй гүйцэтгэдэг гэсэн хариултыг өгсөн байна.




3. Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй удааширч байгаа шалтгааныг та хэрхэн үздэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 10% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 25% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 65% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, **төлбөр авагчдын** 9% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 36,3% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 54,7% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул тул удааширч байна гэж үзжээ.



4.1. Хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 60% нь төлбөр төлөгч этгээдийг албадан ажил хийлгэж, цалин хөлсийг нь тооцох, 40% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд шийтгэл оногдуулах гэсэн хариултыг өгчээ.




4.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөө та ямар хэлбэрээр авах сонирхолтой байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 81,8% нь бэлэн мөнгөөр, 18,2% нь хүүхдийн данс руу шилжүүлэн, хадгалах гэсэн хариултыг өгсөн байна.



5.1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг сайжруулах талаарх таны бодол? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 20% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг бүрэн тогтоож, эд хөрөнгөнөөс нь албадан гаргуулах, 80% нь төлбөр төлөгчийг албадан хөдөлмөр эрхлүүлж, тэтгэлгийг гаргуулах арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.




5.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөний таны амьдралд үзүүлэх нөлөө юу вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 54,7% нь амжиргааны эх үүсвэр, 27,3% нь хүүхдийнхээ ирээдүйд зориулан хадгалдаг, 18% нь хүүхдийнхээ хэрэглээнд зарцуулдаг гэсэн хариултыг өгсөн байна.



## 2.2.21.Хэнтий аймаг

Тус аймаг нь 2019 оны байдлаар 77,957 хүн амтай гэж бүртгэгдсэн ба хүн амын тоогоор улсын хэмжээнд 14 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Мөн онд 313 гэрлэлт, 55 гэр бүл цуцлалт бүртгэгдсэн байна.


### а/ 2010-2019 оны хүүхдийн тэтгэлэг барагдуулалтын байдал




б/ Иргэд, төлбөр авагчаас авсан санал асуулгын дүн: Нийт 13 иргэн, 11 төлбөр авагчаас 5 асуулт бүхий санал асуулга авахад дараах байдлаар хариулжээ. Үүнд:

1. Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийн хувь хэмжээний талаарх таны санал? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 58,8% нь хангалттай, 15,3% нь хангалтгүй, 15,3% нь холбогдох хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай, 15,3% нь сайн мэдэхгүй байна гэсэн бол **төлбөр авагчдын** 72,7% нь хангалттай, 9% нь хангалтгүй, 18,1% нь холбогдох хуульд тэтгэлгийн хувь хэмжээг нэмэх талаар өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн хариултыг өгсөн байна.






2. Шийдвэр гүйцэтгэгчээс хүүхдийн тэтгэлэг гаргуудах талаар гүйцэтгэж буй байдалд өгөх таны үнэлгээ? гэсэн асуултанд судалгаанд оролцогч **иргэдийн** 61,5% нь сайн, 23% нь дунд зэрэг, 15,3% нь хангалтгүй гүйцэтгэдэг гэсэн бол **төлбөр авагчдын** 63,6% нь сайн, 18,1% нь дунд зэрэг, 18,1% нь хангалтгүй гүйцэтгэдэг гэсэн хариултыг өгсөн байна.




3. Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй удааширч байгаа шалтгааныг та хэрхэн үздэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 15,3% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 38,4% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 46,1% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, **төлбөр авагчдын** 54,5% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 45,5% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул тул удааширч байна гэж үзжээ.




4.1. Хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 30,7% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нь бүрэн тогтоож, хураан авах, 61,5% нь төлбөр төлөгч этгээдийг албадан ажил хийлгэж, цалин хөлсийг нь тооцох, 7,6% нь бусад гэсэн хариултыг өгчээ.




4.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөө та ямар хэлбэрээр авах сонирхолтой байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 27,2% нь бэлэн мөнгөөр, 45,4% нь хүүхдийн данс руу шилжүүлэн, хадгалах, 27,2% нь ямар ч хэлбэрээр хамаагүй авах нь чухал биш гэсэн хариултыг өгсөн байна.



5.1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг сайжруулах талаарх таны бодол? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 23% нь төрөөс хүүхдийн тэтгэлгийн мөнгийг эхний ээлжинд бүрэн гарган, төлбөр авагчийн дансанд шилжүүлэн, дараа нь тэтгэлэг төлөгчөөс шийдвэр гүйцэтгэгч албадан гаргуулж, төрийг хохиролгүй болгох, 38,4% нь төлбөр төлөгч этгээдийн эд хөрөнгийг бүрэн тогтоож, эд хөрөнгөнөөс нь албадан гаргуулах, 38,4% нь төлбөр төлөгчийг албадан хөдөлмөр эрхлүүлж, тэтгэлгийг гаргуулах арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.




5.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөний таны амьдралд үзүүлэх нөлөө юу вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 45,5% нь хүүхдийнхээ ирээдүйд зориулан хадгалдаг, 36,3% нь хүүхдийнхээ хэрэглээнд зарцуулдаг, 18,1% өдөр тутмын хэрэглээндээ хэрэглэдэг гэсэн хариултыг өгсөн байна.



## 2.2.22.Улаанбаатар хот

### а/ 2010-2019 оны хүүхдийн тэтгэлэг барагдуулалтын байдал




б/ Иргэд, төлбөр авагчаас авсан санал асуулгын дүн: Нийт 25 иргэн, 22 төлбөр авагчаас 5 асуулт бүхий санал асуулга авахад дараах байдлаар харигджээ. Үүнд:

1. Шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийн хувь хэмжээний талаарх таны санал? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 28% нь хангалттай, 72% нь хангалтгүй гэсэн бол **төлбөр авагчдын** 81,8% нь хангалттай, 13,6% нь хангалтгүй, 4,5% нь холбогдох хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн хариултыг өгсөн байна.



2. Шийдвэр гүйцэтгэгчээс хүүхдийн тэтгэлэг гаргуудах талаар гүйцэтгэж буй байдалд өгөх таны үнэлгээ? гэсэн асуултад судалгаанд


оролцогч **иргэдийн** 44% нь сайн, 56% нь дунд зэрэг гүйцэтгэдэг гэсэн бол **төлбөр авагчдын** 45,5% нь сайн, 45,5% нь дунд зэрэг, 9% нь хангалтгүй гүйцэтгэдэг гэсэн хариултыг өгсөн байна.




3. Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй удааширч байгаа шалтгааныг та хэрхэн үздэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 16% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 20% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 60% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, 4% нь бусад, **төлбөр авагчдын** 22,7% нь шийдвэр гүйцэтгэгч ажлаа хангалтгүй хийж байна, 59% нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 18% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул тул удааширч байна гэж үзжээ.



4.1. Хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 22,7% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нь бүрэн тогтоож, хураан авах, 76% нь төлбөр төлөгч этгээдийг албадан ажил хийлгэж, цалин хөлсийг нь тооцох, 4% нь бусад гэсэн хариултыг өгчээ.




4.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөө та ямар хэлбэрээр авах сонирхолтой байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 54,5% нь бэлэн мөнгөөр, 22,7% нь эд хөрөнгөөр, 4,5% нь хүүхдийн данс руу шилжүүлэн, хадгалах, 9% нь ямар ч хэлбэрээр хамаагүй авах нь чухал биш гэсэн хариултыг өгсөн байна.



5.1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг сайжруулах талаарх таны бодол? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 85% нь төрөөс хүүхдийн тэтгэлгийн мөнгийг эхний ээлжинд бүрэн гарган, төлбөр авагчийн дансанд шилжүүлэн, дараа нь тэтгэлэг төлөгчөөс шийдвэр гүйцэтгэгч албадан гаргуулж, төрийг хохиролгүй болгох, 4% нь төлбөр төлөгч этгээдийн эд хөрөнгийг бүрэн тогтоож, эд хөрөнгөнөөс гаргуулах, 8% нь төлбөр төлөгчийг албадан хөдөлмөр эрхлүүлж, тэтгэлгийг гаргуулах, 4% нь бусад арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.




5.2. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөний таны амьдралд үзүүлэх нөлөө юу вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч **төлбөр авагчдын** 9% нь амжиргааны эх үүсвэр, 31,8% нь хүүхдийнхээ ирээдүйд зориулан хадгалдаг, 18,1% нь хүүхдийнхээ хэрэглээнд зарцуулдаг, 40,9% чухал биш гэсэн хариултыг өгсөн байна.



### **2.3. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаарх судалгаа**

Хүүхдийн тэтгэлгийн гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх зорилго бүхий асуултыг 140 шийдвэр гүйцэтгэгчээс авахад дараах хариултыг өгсөн байна.

1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг та хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 7,8% нь хангалттай, 14,2% нь хангалтгүй, 77,8% сайжруулах шаардлагатай гэсэн хариултыг өгсөн байна



Дээрх хариулт нь нийт судалгаанд оролцогчдын 80% нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалт нь өнөөгийн нөхцөлд шаардлага хангахгүй шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

2. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг дурдана уу?

- төлбөр төлөгч бүртгэлтэй хаяг дээрээ оршин суудаггүй -46
- төлөгчийн талаарх хаягийн мэдээлэл тухайн аймаг, сумын багийн дарга, нийгмийн ажилтан нарын зүгээс мэдээлэл байхгүй, мэддэггүй
- тэтгэлэг төлөгчдийн гэр бүлээс тэтгэлэг төлөгчийн талаар мэдээлэл өгөх болон мэдэгдэл хүлээн авахаас татгалздаг, тэтгэлэг төлөгч оршин суух хаягаа санаатай нуун дарагдуулдаг
- тэтгэлэг төлөгч нар төлбөрийн чадваргүй, ажилгүй, орлогогүй, эд хөрөнгөгүй байх-57
- эд хөрөнгөө бусдын нэр дээр шилжүүлж нуун дарагдуулах-8
- хувиараа хөдөлмөр эрхэлж олсон орлогоо нуун дарагдуулдаг /арилжааны банкны дансанд хаалт хийсэн ч дахин өөр данс нээлгэх, бэлэн мөнгөөр цалингаа авах гэх мэт/-4
- цалин бага, 2 ба түүнээс дээш хүүхдийн тэтгэлэг төлдөг учир орлого нь хүүхдийн тэтгэлгийн сарын хэмжээнд хүрдэггүй-2



-амьжиргааны доод түвшин жил бүр нэмэгдэж байгаа нь ажилгүй төлбөр төлөгч нарт хүндрэл үүсгэдэг

-Цагдаагийн байгууллагад эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр хандахад шийдвэрлэж өгдөггүй

-Прокурорын газар тухайн асуудалд ач холбогдол өгдөггүй

-Тэтгэлэг төлөгч гадаад улсад ажиллаж, амьдрахаар явсан -7

- тэтгэлгийн хэмжээ өндөр

-шийдвэрт тэтгэлэг төлөгчийн төлөх тэтгэлэг нь түүний орлогын 50%-аас хэтрэхгүй байх талаар дурдагдсан байдаг. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй-2

-ажиллагааны зардал хүрэлцэхгүй-2

-шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын ачаалал их, хамгаалах тусгай хэрэгсэлгүй-2

-дундын эд хөрөнгөөс тэтгэлэг гаргуулахад хэцүү /гэрлэлтийн баталгаагүй байдаг/

- шүүхээр шийдвэрлээгүй эд хөрөнгийн маргаан гардаг

- эрэн сурвалжлах ажиллагаа хангалтгүй, орон нутагт явуулахад хүндрэлтэй, хариуцсан нэгж байхгүй-16

-төлбөр төлөхгүй байгаа төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлага сул -4

-нийгэмд ажиллах ажлын байр хомс -2

- төлбөр төлөгчөөс гаргуулсан хүүхдийн мөнгийг зориулалтын дагуу хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавих боломжгүй, эрх зүйн зохицуулалт тодорхойгүй-2

-үүрэн холбооны газрууд үнэгүй дугаар тараадагтай холбоотойгоор нэг тэтгэлэг төлөгч хэд хэдэн дугаар ашигладаг үүнтэй холбоотойгоор лавлагаа авах боломжгүй

- шийдвэрлэх асуудал шат дараалал ихтэй, бүрдүүлэх баримт их шаарддаг

- төлбөр төлөгч хорих ял эдлэж байгаа -2

-иргэд ухамсаргүй-3

-хуулийн зохицуулалт сул-6

-шүүхийн шийдвэр ойлгомжгүй

-шийдвэр гүйцэтгэгч тэтгэлэг төлөгчийг түр саатуулах баривчлах эрх байхгүй

- баривчлах ялын хугацаа бага

- торгуулийн арга хэмжээ авдаггүй

*3. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг боловсронгуй болгох талаарх таны санал?*

- тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, ажил эрхлэлтийг үндэслэж тэтгэлгийн хэмжээ, хувийг тогтоодог байх -14
- албадан хөдөлмөр эрхлүүлж, цалин хөлсийг суутгах-47
- хөдөлмөрийн хөлсний 50 хувиас илүү суутгал хийх -5
- Эрүүгийн хуульд холбогдох зүйл заалтыг нарийн тусгах -4
- ШШГТХ-ийн 27.1.5-д зааснаар 31.2 заасныг баримтлан ажиллаж, түдгэлзүүлэн буцаах
- ШШГТХ-д тодорхой асуудлаар өөрчлөлт оруулах -2
- Зөрчлийн тухай хуулинд тодорхой зохицуулалтыг нэмж тусгаж, боловсронгуй болгох -10
- Гэр бүлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах -2
- шүүхийн шийдвэр дээр тэтгэлэг төлөгчийн хариуцлагыг тодорхой тусгах, хүлээлгэх хариуцлагыг чангатгах -9
- шийдвэр гүйцэтгэгчид 72 цаг шууд саатуулах эрх олгох -6
- 2-3 сар баривчлах шийтгэл оногдуулах -10
- баривчлах ял болон нийтэд тустай ажил хийх ялаар шийтгэх
- тэтгэлгийн мөнгийн тэтгүүлэгч хүүхдэд зорцуулсан эсэх тайлан, тодорхойлолтыг тэтгэлэг авагч ирүүлж байх, хяналт тавих -4
- тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд олон нийтийн талбай болон сошиалаар тэтгэлэг төлөгчийн зурагтай нийтлэх-3
- шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын асуудлыг шийдвэрлэх-4
- тэтгэлэг төлөгч, авагч нарын дундын эд хөрөнгийг битүүмжилж хураадаг байх-2
- эрэн сурвалжлах ажиллагааг бодитой үр дүнтэй зохион байгуулах, орон нутгийн албадуудад эрэн сурвалжлах ажил хариуцсан нэгжтэй болгох-14
- санаатайгаар тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн, оршин суух тодорхой хаяггүй тэтгэлэг төлөгч нарт байршил тогтоогч суулгах
- төрийн байгууллагаар үйлчлүүлж, үйлчилгээ авах эрхийг нь хязгаарлах -2
- сургалт, семинар зохион байгуулах-3
- иргэний бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох, цахим санд төлбөр төлөгчийн мэдээллийг харах боломжтой болгох -7
- тэтгэлэг төлөөгүй тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хорих ял оноох, хорих ялыг 3-5 жил болгох -3
- Гадаад улсад суугаа тэтгэлгийн хуримтлалтай тэтгэлэг төлөгчдийг албадан авчрах эрх зүйн зохицуулалттай болох
- хүүхдийн тэтгэлгийг хариуцсан шийдвэр гүйцэтгэгч тусдаа байх-6
- хүүхдийн тэтгэлгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын эрх зүйн зохицуулалт практикийн уялдаа холбоог бий болгох -2

- мэргэжлийн удирдлагаар хангах-2
- шүүхийн шийдвэр гарснаас хойш олон жилийн дараа өгсөн ГББ-т хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэн тооцож ШГА-г эхлүүлэх
- хүүхдийн тэтгэмжийн мөнгийг 50%-ийг өөрийнх нь хадгаламжид хийх-2
- жолооны эрхийг нь хасдаг болох
- шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах
- төлбөр төлөгчийн шилжилт хөдөлгөөнийг хаах, зорчих эрхийг хязгаарлах -4
- Шүүхээс ирж буй гүйцэтгэх баримт бичигт төлөгчийн хаягийг байнга оршин суух хаягаар нь бичиж ирүүлэх /худлаа хаяг маш их бичүүлж ирүүлдэг/-4
- эрэн сурвалжлагаар олдсон төлбөр төлөгчийг тодорхой хугацаагаар саатуулах зохицуулалтыг хуульд тогтоомжид тусгах-4
- төлбөр авагч шийдвэр гүйцэтгэгч нарын хамтын ажиллагааг сайжруулах
- гэр бүл салалт, хүүхэд хамгаалал тал дээр анхаарч ажиллах, түүнчлэн урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, бусад хуулийн байгууллагатай хамтран ажиллах
- цахим иргэний үнэмлэхэд чип суулгаж аль ч байгууллагад ажилд ороход тухайн байгууллагын санхүү хуулиар шууд суутгал хийх эрх олгох
- төрөөс тэтгэлгийг олгож, төр өөрөө тэтгэлэг төлөгчөөс гаргуулж авдаг байх
- тогтмол орлоготой тэтгэлэг төлөгчийн тэтгэлгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар ажиллагааг хийлгүүлэхгүйгээр тэтгэлэг авагч мөнгөө авах боломжтой болгох-2
- хүүхдийн тэтгэлгийг шүүхээс эцэг, эхийн аль боломжтой талаар төлүүлэхээр шийдэх
- бүтэц орон тоог нэмэгдүүлэх-2
- тэтгэлэг төлөгчийн харъяа сум, дүүрэг дэх цагдаад мэдэгдэж, түр саатуулдаг байх -2
- шийдвэр гүйцэтгэгчид тусгай эрх олгох /эрэн сурвалжлах ажиллагааны явцад олдсон төлбөр төлөгчийг шийдвэр гүйцэтгэгч нь 24 цагаар саатуулах эрхтэй болох/-2
- тэжээн тэтгэх үүргээс зайлсхийсэн, тэтгэлгийн мөнгийг төлөхгүй байгаа тэтгэлэг төлөгчид ажил албан тушаалаас түдгэлзүүлэх арга хэмжээг авах зохицуулалттай болох

-тэтгэлэг төлөгчид оногдуулах шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлж байгаатай ижил хэмжээгээр тэтгэлэг авагчийн хүлээх хариуцлага, үүргийг нэмэгдүүлэх шаардлагатай

-төрийн албанд ажилд орж ажиллах эрхийг хасах

- төлбөр төлөгч өөрөө ямар ч орлогогүй, хөрөнгөгүй бол гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогоос суутгах зохицуулалтыг бий болгох гэсэн саналыг тус тус гаргасан байна.

## **ГУРАВ.ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Гэр бүлийн эрх зүйн салбарт улс орнуудын эрх зүйн тогтолцоо нь хоорондоо ихэд ялгаатай байдаг онцлогтой. Энэ нь гэр бүлийн харилцааг зохицуулахад үндэсний онцлог хийгээд зан заншил ихээхэн нөлөөлдөгтэй холбоотой юм. Гэр бүлийн харилцааны зохицуулалт нь зуугаад жилийн түүхтэй юм. Эрх зүйн хэм хэмжээ, ялангуяа гэр бүлийн эрх зүйн салбар дахь хэм хэмжээг боловсруулахад сүм, шашны үзэл суртал нөлөөлдөг. Иймд энэ салбарт олон улсын нэгдмэл эрх зүйн материаллаг хэм хэмжээ байдаггүй.

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүүхэд аз жаргал, хайр ойлголцол бүхий орчинд хүүхдийн бүрэн өв тэгш хөгжлийг хангах, онцгой халамж, туслалцаа авч байх, аж төрөх жам ёсны орчин, тийм гэр бүлд өсөж бойжих, тэрхүү гэр бүлийг нийгмийн үндсэн нэгж болохын хувьд нийгэмд хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээгээр үзүүлэх, төрөөс тэрхүү гэр бүлд шаардлагатай хамгаалалт, туслалцаа үзүүлэх талаар заасан байдаг ба гэр бүлээс хүүхэд нийгэмд бие даан аж төрөхөд бүрэн бэлтгэгдэх ёстойг тусгасан байдаг байна. Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай. Ялангуяа хөгжиж байгаа орнуудад хүүхдийн амьдралын нөхцөлийг сайжруулах талаар Хүүхдийн эрхийн тухай 1942 оны Женевийн тунхаглал, 1959 оны Хүүхдийн эрхийн тунхаглал болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, түүнчлэн хүүхдийн аж байдлын асуудал эрхэлсэн олон улсын болон төрөлжсөн байгууллагуудын холбогдох баримт бичиг, дүрэмд илүүтэй тусгагдсан байна.

Хүүхэд бусдын хайр халамж, материаллаг дэмжлэгээр эсэн мэнд, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой иргэн болж өсөн бойжих ёстой нь дээрх эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрдөг баримт бичигт тусгагдсан байна. Ихэнх улсад хүүхэд насыг дунджаар 18 наснаас доошгүй байх шаардлагыг хүлээн зөвшөөрсөн байна. Герман, Норвеги зэрэг улсад хүүхдэд суралцаж байгаа бол 18-аас дээш насны хүмүүсийг хамруулан ойлгодог байна. Австри улсад хүүхдийн тэтгэлгийг 28 нас хүртэл үргэлжлүүлдэг хуулийн заалттай байна.

### **3.1.БНСУ-ын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

Өмнөд Солонгосын дээд шүүх нь шинэ гэр бүлийн бүртгэлийн хуулийг хэлэлцэн 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү шинэ тогтолцоо нь уламжлалт “Хожу” тогтолцоог өөрчлөн, учир нь Солонгосийн Үндсэн хуулийн шүүх уг тогтолцоо нь жендерийн тэгш эрхийг зөрчин Үндсэн хуульд харшилж байгааг тогтоосон ба Хожу системийн үед гэр бүлийн бүх гишүүдийг зөвхөн эрэгтэй нь л тэргүүлдэг байжээ.

Хожу /hoju/-гаар эрэгтэй, эмэгтэйн харилцааны нөхцөлийг гэр бүлийн гишүүн нэг бүрээр нарийн тодорхойлсон. Нөхөр нь нас барсан үед түүнийг эхнэр нь биш хамгийн ахмад хүү нь голдуу өв залгамжилдаг, охин нь гэрлэхэд тэрээр эцгийнхээ гэр бүлийн бүртгэл /hojeok /-с гарч нөхрийнхөө бүртгэлд шилждэг. Хүүхдүүд нь эцгийнхээ гэр бүлийн бүртгэлд /hojeok / нэмэгддэг. Эхнэр, нөхөр салах үед хүүхдүүдийг асран хүмүүжүүлэх эрх эхэд хадгалагдана, хүүхдүүд эцгээрээ овоглох ба шилжүүлэхээр бол зөшөөрөл авна, үгүй бол гэр бүлийн бүртгэлд хэвээр үлдэнэ. Хүүгүй гэр бүл удмын төгсгөлтэй байна.

Шинэ системийн дагуу хожу-гийн дээрх ойлголт нь хэрэггүй болж, хожеок болсон.

Гэр бүлийн гишүүн бүр өөрийн шинэ хувийн тэмдэглэлийн дэвтэрт бүртгэгдэнэ, түүнчлэн хүний төрөлт, нас баралт, гэрлэлт, хүүхэд үрчлэлтийн мэдээлэл, эцэг, эх, хүүхэд, эхнэр, нөхрийн үндсэн мэдээллийг хамтад нь багтаана. Шинэ бүртгэлийн систем нь гэрлэлтийн бүртгэлийн хугацаанд эцэг, эхийн харилцан зөвшилцсөнөөр эхийнхээ нэрээр овоглохыг зөвшөөрдөг. Мөн түүнчлэн хүүхэд овог нэрээ хойд эцэгийн зөвшөөрөл, шүүхийн зөвшөөрлөөр өөрчилж болно.

Ингэхдээ төрсөн эцэгээсээ зөвшөөрөл авах шаардлагагүй. Мөн ээжийнхээ гэр бүлийн нэрээр удмаа бүртгүүлэх нь эцгээрээ овоглох, эцэгийн бүртгэлээс гарах, өөрчлөхөөс бага байдаг. Одоог хүртэл, үрчлэгдсэн хүүхэд болон дагавар хүүхэд нас барсан эцэг, эхийн хүндэтгэлийн Жеса гэгддэг тодорхой ёслол байхгүй, өв залгамжлах эрхгүй байна.

Шинэ хуулийг хүчин төгөлдөр болох хугацааны үед, дагавар хүүхэд хойд эцгийнхээ төрсөн хүүхэдтэй хуулиар ижил эрхтэй байна, тухайлбал: хууль ёсны эцгээрээ овоглох, бүртгэгдэх нөхцөлд, эцэг, эх нь гэрлээд нэгээс илүү жил болж байх ёстой г.м.

Гэрлээд гурваас илүү жил болж байгаа хосууд хүүхэд үрчилж авахыг хүсвэл төрсөн эцэг, эх нь зөвшөөрөгдөх нөхцөл хуулиар ижил эрхтэй байна.

Шинэ систем бол Солонгосын эмэгтэйчүүдийн эрхийг бэхжүүлэхэд ихээхэн найдвар болж, олон нийтийн тогтсон буруу хандлагыг өөрчлөх,

гэр бүлийн үндэсний үзэл, гэр бүлийн амьдралд хоёуланд нь их нөлөө үзүүлж байна.

Солонгос улсын Иргэний хуулийн 800 дугаар зүйлд зааснаар “насанд хүрсэн хүн чөлөөтэйгөөр гэр бүлийн сүй тавьж болно”, 801-р зүйлд “Эрэгтэй хүн арван найман насанд хүрсэн, эмэгтэй хүн арван зургаан насанд хүрсэн бол тэдний эцэг, эх, тэжээгчийн зөвшөөрлөөр гэрлэлтийн сүй тавьж болно” гэж заасан нь их онцлог зохицуулалт бөгөөд гэрлэхээсээ өмнөх хоёр тал гэрлэх сүй тавих гэсэн өвөрмөц зохицуулалтыг тусгасан байдаг.

Хэн ч гэрлэлтийн сүйг албадан биелүүлэхээр шүүхэд нэхэмжилж болохгүй. Доорх нөхцөл байдлын нэг л шалтгаан гэр бүлийн сүй тавьсан талуудын нэгэнд байвал сүйг цуцалж болно. Үүнд:

- Хэрвээ талуудын нэг нь ял шийтгэгдсэн;
- Хэрвээ талуудын нэг нь гэрлэлтийн сүйн шийдвэрийг мэдээгүй эсхүл мэдээгүй байснаа нягталж үзэхээр бол;
- Хэрвээ талуудын нэг нь арьс өнгөний өвчин, сэтгэцийн эдгэрэшгүй өвчтэй, мөн өөр бусад эдгэрэшгүй хорт халдварт өвчтэй бол;
- Хэрвээ талуудын нэг нь өмнө нь сүй тавьсан, гэрлэлтийн сүй тавих шийдвэрийн дараа өөр хүнтэй гэрлэхээр сүй тавьсан;
- Хэрвээ талуудын хэн нэгэн нь гэрлэлтийн сүй тавих шийдвэрийн дараа өөр хүнтэй завхайрсан;
- Хэрвээ талуудын хэн нэгэн нь нас барсан, гэрлэлтийн сүй тавьсаны дараа нэгээс илүү жил хаана байгаа нь мэдэгдэхгүй бол;
- Хэрвээ талуудын хэн нэгэн нь татгалзсан эсхүл гэрлэлтээ шалтгаангүйгээр хойшлуулсан.

Гэрлэлтийн сүй бол гэрлэхээс өмнө онцгой харилцаа байхаар Солонгос улсад өвөрмөц зохицуулалтыг оруулсан нь тухайн орны соёл, ёс заншилтай холбоотой болов уу.

Харин гэрлэх насны хувь эрэгтэй 18 насанд хүрсэн, эмэгтэй 16 насанд хүрсэн бол гэрлэж болно. Насанд хүрээгүй бол гэрлэх зорилгоор хоёулангийнхаа эцэг, эхийн зөвшөөрлийг авсан байна. Хэрвээ нэг талын эцэг, эх нь зөвшөөрөх эрхээсээ татгалзвал, насанд хүрээгүй хүн нөгөө эцэг, эхийнхээ зөвшөөрлийг авна, мөн аль байхгүй бол тэжээгчийнхээ саналд үндэслэнэ.

Гэрлэлтэнд хориглох нөхцөлийг заахдаа:

-Талуудын аль алиных нь овог, нэр, удам ижил, цусан төрлийн хамаатан бол гэрлэж болохгүй.

- Талууд Эрэгтэйн цусан төрлийн хамаатан эхнэр, нөхөр байсан бол тэдгээрийн хэнийг ч, нөхрийн цусан төрлийн хамаатан, садангийн найм дахь үеийн дотор бол гэрлэхийг хориглоно.

-Гэрлэсэн бол өөр хүнтэй гэр бүл болохыг хориглоно, эмэгтэй хүн өмнөх гэрлэлт дуусгавар болсон өдрөөс хойш зургаан сар өнгөрөөгүй бол дахин гэрлэж болохгүй. Харин түүний өмнөх гэрлэлтийн харилцаа дуусгавар болсны дараа хүүхэдтэй болсон бол хамаарахгүй.

Гэрлэх нөхцөлийн хувь Гэр бүлийн бүртгэлийн журамд заасны дагуу мэдээллийг хийлгэн гэрлэдэг. Энэхүү дурьдсан мэдээлэлд аль аль талаас насанд хүрсэн хоёр гэрчийг гарын үсэг зуруулж баталгаажуулна. Гэр бүлийн бүртгэлийн хувьд эхнэрийн нэр нь нөхрийнхөө гэр бүлийн бүртгэлд орно. Эхнэр нь өрх тэргүүлдэг, эцэг, эхийнхээ тэргүүлсэн гэр бүлийн өв залгамжлагч бол нөхөр нь эхнэрийнхээ гэр бүлийн бүртгэлд орж болно.

**“Хүүхдийн тэтгэмж тогтоолгох болон гаргуулахтай холбоотой хууль тогтоомж, шинэчилсэн журам” /2019.6.27 өдрөөс хэрэгжиж эхэлсэн/  
1-р бүлэг. Ерөнхий зүйл**

1-р зүйл.Зорилго

Энэхүү журам нь “Хүүхдийн тэтгэмж тогтоолгох болон гаргуулахтай холбоотой хууль тогтоомж” болон тухайн хуулийн хэрэгжүүлэх тогтоомжоос итгэмжлэгдсэн зүйл, заалт болон хэрэгжилтэнд шаардлагатай зүйл, заалтыг тогтооход оршино.

**2-р бүлэг.Хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах**

2-р зүйл.Хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах хүсэлт гаргах

2.1. Дараах заалтуудад хамаарах тэтгэлгийг авах хүн нь 1-р тоот маягтын Хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах хүсэлтийг “Хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулахтай холбоотой хууль тогтоомж”-ийн (цаашид “Тухайн хууль” гэнэ) 7-р зүйлд заасны дагуу Хүүхдийн тэтгэмж тогтоолгох байгууллагын (цаашид “Байгууллага” гэнэ) даргад уламжлана.

2.1.1.Тухайн хуулийн 10-р зүйлд заасны дагуу хүүхдийн тэтгэмжтэй холбоотой тохиролцох тэтгэлэг (цаашид “Тохиролцох тэтгэлэг” гэнэ)

2.1.2.Тухайн хуулийн 11-р зүйлийн 11.1 болон 11.2 -т заасны дагуу хүүхдийн тэтгэмж нэхэмжлэх болон тогтоолгох хууль ёсны тэтгэлэг (цаашид “Хууль ёсны тэтгэлэг” гэнэ)

2.1.3.Тухай хуулийн 11-р зүйлийн 11.2 -т заасны дагуу хүүхдийн тэтгэмж нөхөн гаргуулах тэтгэлэг (цаашид “Нөхөн гаргуулах тэтгэлэг” гэнэ)



2.2. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах эцэг юмуу эх нь 2.1-р заалтад тусгасан хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах хүсэлтийг дараах бичиг баримттай хамт хавсаргана.

1.Хууль ёсны тэтгэлэг авах хүсэлт гаргасан тохиолдолд хууль ёсны тэтгэлгийн төрлийн дагуу эмэгтэйчүүд Гэр бүлийн яамны сайдын баталж нийтэд зарласан бичиг баримт

2.Нөхөн гаргуулах тэтгэлэг авах хүсэлт гаргасан тохиолдолд:

а. хүүхдийн тэтгэмж нөхөн гаргуулах итгэмжлэх 1 хувь;

б. дансны дугаартай хадгаламжийн дэвтрийн хуулбар 1 хувь;

в. хүүхдийн тэтгэмжийн төлбөртэй холбоотой бичиг баримт /цахим албан бичиг багтсан/1 хувь.

2.3. Байгууллагын дарга хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах хүсэлтийг хүлээн авч, холбогдох бичиг баримтыг хавсаргаагүй бол хүүхдийн тэтгэлэг гаргуулах эцэг юмуу эхэд хугацаа зааж, холбогдох бичиг баримтыг гүйцээж өгөхийг шаардаж болно.

2.4. Хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд хариуцсан ажилтан “Цахим Засгийн газрын хууль”-ийн 36-р зүйлийн 1-т заасны дагуу захиргааны мэдээлэлийн сангаар дамжуулан иргэний бүртгэлийг шалгана. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах эцэг юмуу эх зөвшөөрөөгүй тохиолдолд зөвхөн бичиг баримтыг хавсаргана.

2.5. Хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах хүсэлт нь албан бичигт тооцогдоно. Факс “Мэдээлэл холбоо сүлжээний хэрэглээг дэмжих болон мэдээлэлийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомж”, 2-р зүйлийн 2.1.1 –т заасны дагуу мэдээлэл холбооны сүлжээг (цаашид “Мэдээлэл холбооны сүлжээ” гэнэ) ашиглаж болно. Энэ тохиолдолд байгууллагын дарга хүүхдийн тэтгэлэг гаргуулах эцэг юмуу эх хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар хавсралт 1-р тоот маягтын хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах хүсэлтийг шууд бөглөж чадахгүй тохиолдолд байгууллагын ажилтан оронд нь бөглөхийг зөвшөөрнө.

2.6. Байгууллагын дарга хүүхдийн тэтгэмж тогтоолгох, гаргуулах хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд хавсралт 2-р тоот маягт буюу бичиг баримт хүлээн авсан маягтыг хэвлэж өгнө.

3.1.Хүүхдийн тэтгэлэгийг тохиролцох арга зам, процесс

3.1.1.Байгууллагын дарга тэтгэмж гаргуулах эцэг юмуу эхээс тохиролцох тэтгэлэг гаргуулах хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд нэн түрүүнд тэтгэмж төлөгч тал хүүхдийн тэтгэмжтэй холбоотой тохиролцоог зөвшөөрсөн эсэхийг шалгана.

3.1.2.Байгууллагын дарга тэтгэмж төлөгч тал хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой тохиролцоог зөвшөөрсөн тохиолдолд талуудад шуудан, утас,

факс, имэйл зэрэг аль тохиромжтой арга замаар тохиролцох газар, тохиролцох өдөр болон оролцох этгээд зэргийг тогтоож мэдэгдэнэ. Мэдэгдэлийн агуулгын дагуу тохиролцох процесс явагдана.

3.1.3. Байгууллагын дарга талууд тохиролцож “Нотариатын тухай хууль”-ийн дагуу бичиг баримтыг нотариатаар баталгаажуулж өгөхийг шаардана.

3.2. Хүүхэдтэйгээ уулзах хүсэлт гаргах арга зам

3.2.1. Тухайн хуулийн 10-р зүйлийн 2.1-т заасны дагуу хүүхэдтэйгээ уулзах хүсэлт гаргах тал нь хавсралт 2-р тоот маягтын хамт /цахимаар гаргасан хүсэлт багтана/ дараах холбогдох бичиг баримтыг хавсаргаж байгууллагын даргад уламжлана.

1. Иргэний бүртгэлийн хуулбар;

2. Хүүхэдтэйгээ уулзах хүсэлттэй холбоотой тохиролцооны бичиг болон шүүхийн дүгнэлт, шийдвэр зэрэг бичиг баримт

3.2.2. Байгууллагын дарга хүүхэдтэйгээ уулзах хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд нэн түрүүнд дараах заалтуудыг шалгана.

а. Хүүхэдтэйгээ уулзах хүсэлттэй холбоотой хүүхдийн санаа бодол, хоёр талын санаа бодол;

б. “Иргэний хууль”-ийн 837-р зүйлийн 2.3-т заасны дагуу хүүхэдтэйгээ уулзахыг хязгаарласан эсвэл хассан эсэх;

в. 1-р заалт болон 2-р заалтад зааснаас бусад тохиолдолд хүүхэдтэйгээ уулзах хүсэлт гаргах процесс болон арга замтай холбоотой 2-р зүйлийн 3-6 хүртлэх заалтаар хүсэлт гаргана.

3.2.3. Байгууллагын дарга тухайн хуулийн 10-р зүйл 2.1-т заасны дагуу дараах арга замуудаар хүүхэдтэйгээ уулзах хүсэлтийг дэмжинэ.

1. Хүүхэдтэйгээ уулзах газраар хангах;

2. Хүүхэдтэйгээ уулзах хөтөлбөр гаргах;

3. Хүүхэдтэйгээ уулзах хүсэлт гаргах боловсон хүчнээр хангах;

4. Байгууллагын даргын шаардлагатай гэж хүлээн зөвшөөрсөн арга зам

4-р зүйл. Хууль ёсны тэтгэлэгийн процесс

4.1. Байгууллагын дарга хүүхдийн тэтгэмж гаргуулах эцэг юмуу эхээс шүүхээр тогтоолгож тэтгэлэг авах хүсэлт хүлээн авсан тохиолдолд шууд тогтоох эсвэл “Хүүхдийн тэтгэмж тогтоолгох болон гаргуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжүүлэх тогтоол”-ийн 18-р зүйлийн 2-т заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар нэн түрүүнд хүүхдийн тэтгэмж тогтоолгоход шаардлагатай арга хэмжээг авна.

4.2. Байгууллагын дарга хуулийн байгууллагаар тэтгэлэг тогтоолгох процессд судалгаа хийсний дүнд шүүхэд ялах магадлал

багатай зэрэг бодит орлого юмуу хууль зүйн үндэслэлгүй байх тохиолдолд хууль ёсны тэтгэлэгийг зогсоож болно.

5-р зүйл. Хүүхдийн тэтгэлэг нөхөн гаргуулах процесс/

5.1. Байгууллагын дарга хүүхдийн тэтгэмж гаргуулах эцэг юмуу эхээс хүүхдийн тэтгэлэг нөхөн гаргуулах хүсэлт хүлээн авсан тохиолдолд шууд нөхөн гаргуулах эсвэл тогтоолын 18-р зүйлийн 3-т заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар нэн түрүүнд хүүхдийн тэтгэмж нөхөн гаргуулахад шаардлагатай арга хэмжээг авна.

5.2. Байгууллагын дарга нөхөн гаргуулах тэтгэлэгийн процессд судалгаа хийсний дүнд хүүхдийн тэтгэмж төлөгчид нөхөн төлөх эд хөрөнгө, орлого байхгүй зэрэг бодит орлого юмуу хууль зүйн үндэслэлгүй байх тохиолдолд нөхөн гаргуулах тэтгэлэгийг зогсоож болно.

6-р зүйл. Санал хүсэлтийн мэдүүлэг

6.1. Тухайн хуулийн 12-р зүйлд заасны дагуу санал хүсэлтээ хэлэх мэдүүлэг өгөх хүсэлт гаргах гэж байгаа хүүхдийн тэтгэмж төлөгч нь хавсралт 3-р тоот маягтыг бөглөж байгууллагын даргад уламжлана.

6.2. Байгууллагын дарга 6.1-т заасны дагуу хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд мэдүүлэг өгөх өдөр болон газрыг зааж өгч хүүхдийн тэтгэмж төлөгчид мэдүүлэг өгөх өдрөөс 7 хоногийн өмнө мэдэгдэнэ.

6.3. Хүүхдийн тэтгэмж төлөгч нь санал хүсэлтээ хэлэх, мэдүүлэг өгөх тохиолдолд мэдүүлэгтэй холбоотой нотлох баримт, бусад бичиг баримтыг уламжлана.

6.4. Байгууллагын дарга хүүхдийн тэтгэмж төлөгч мэдүүлэг өгөх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэдүүлэг өгөхийн оронд санал хүсэлтээ албан бичгээр хүргүүлэхийг зөвшөөрч болно.

7-р зүйл. Хүүхдийн тэтгэлэгийн мөнгө яаралтай гаруулах хүсэл гаргах

7.1. Хүүхдийн тэтгэлэгийн мөнгийг яаралтай гаруулах хүсэлт гаргах гэж байгаа хүүхдийн тэтгэлэг нөхөн гаргуулагч нь хавсралт 4-р тоот маягтыг бөглөж доорх бичиг баримтуудыг хавсаргаж байгууллагын даргад уламжлана.

1. Орлого, эд хөрөнгийг нотлох бичиг баримт 1 хувь;

2. Дансны дугаар бичсэн хадгаламжийн дэвтэрийн хуулбар 1 хувь.

7.2. Хүүхдийн тэтгэлэг нөхөн гаргуулагч нь 14-р зүйлийн 2.2-т заасны дагуу дараах заалтуудын аль нэгтэй холбоотой нөхцөл үүссэн тохиолдолд тэрхүү нөхцлийн талаар нэн түрүүнд байгууллагын даргад шуудан, факс, мэдээлэл холбооны сүлжээ зэргээр дамжуулан мэдэгдэнэ.

1. Хүүхдийн тэтгэлэг төлөгч хүүхдийн тэтгэмжийг төлсөн;

2. Тогтоолын 8-р зүйл 8.1-т заасны дагуу хүүхдийн тэтгэмж яаралтай гаргуулах хүсэлт нийцэхгүй;

3. "Иргэдийн суурь амжиргааг хамгаалах хууль"-ийн 7-р зүйлийн 1.1-т заасны дагуу халамжийн мөнгөнөөс авах болсон;

4. "Яаралтай нийгмийн халамжийн тусламж үйлчилгээний тухай хууль"-ийн 9-р зүйл 1.1-т заасны дагуу халамжийн мөнгөнөөс авах болсон.

7.3. Хүүхдийн тэтгэлэг нөхөн гаргуулагч нь тухайн хуулийн 14-р зүйлийн 3.1-т заасны дагуу эсрэг саналтай байгаа тухай хүсэлт гаргах тохиолдолд хавсралт 4-р тоотын 2 маягтыг бөглөж байгууллагын даргад уламжлана.

8-р зүйл. Хүүхдийн тэтгэлэг нэхэмжлэх мэдэгдэл

8.1. Байгууллагын дарга хүүхдийн тэтгэмж гаргуулах эцэг юмуу эхээс хүүхдийн тэтгэлэг нөхөн гаргуулах хүсэлт хүлээн авсан тохиолдолд тухайн хуулийн 15-р зүйлийн 1-т заасны дагуу хавсралт 5-р тоот маягтын хүүхдийн тэтгэлэгийн нэхэмжлэх бичигт дараах заалтуудын дурьдаж хүүхдийн тэтгэмж төлөгчид мэдэгдэнэ. /шинэчилсэн 2018.09.05/

1. Хүүхдийн тэтгэлэг авах талаас хүүхдийн тэтгэмж нөхөн гаргуулах итгэмжлэл авсан тухай баримт;

2. Хүүхдийн тэтгэмж нөхөн гаргуулах нэхэмжлэл;

3. Хүүхдийн тэтгэлэг авах тал нөхөн гаргуулах мөнгөн дүн зэрэг нөхөн төлүүлэхтэй холбоотой нөхцөл;

4. Нөхөн төлөх хэлбэр;

5. Нөхөн төлөхгүй тохиолдолд авах арга хэмжээ;

6. Хүүхдийн тэтгэмж нөхөн төлөгч санал хүсэлтийн мэдүүлэг өгөх боломж олгохтой холбоотой нөхцөл.

8.2. 8.1-т заасны дагуу мэдэгдлээ шуудангаар юмуу албан бичгээр хүргүүлэх бөгөөд албан бичгээр хүлээлгэн өгөх тохиолдолд хүлээн авсан гэсэн баримтыг хүүхдийн тэтгэмж төлөгчөөс авна.

9-р зүйл. Нотлох тэмдэг

9.1. Тухайн хуулийн 16-р зүйлд заасны дагуу хүүхдийн тэтгэмж төлөгчийн эд хөрөнгөд судалгаа хийх ажилтан нь эрх бүхий хүмүүст үзүүлэх нотлох тэмдэг нь 6-р тоот маягтын дагуу байна.

### **3-р бүлэг. Нэмэлт журам**

10-р зүйл. Хүүхдийн тэтгэлэг тогтоолгох, хүүхдийн тэтгэмж нэн түрүүнд олгох

10.1. Тухайн хуулийн 22-р зүйлийн 4-т "Эмэгтэйчүүд, гэр бүлийн яамны тогтоолоор нэн түрүүнд тогтоолгох хүн" гэдэг нь хүүхдийн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүний өрхийн орлого улсын хэмжээний нийт өрхийн дундаж орлогын 100%-ийн 150 хүртлэх хүнийг хэлнэ.

## 11-р зүйл.Хураамж

11.1.Байгууллагын дарга хуулийн 10-р зүйл болон 11-р зүйлд заасны дагуу хүүхдийн тэтгэлэг тогтоолгох хүсэлт гаргасан кейс нь шүүхэд нэхэмжлэл гаргах юмуу тухайн хуулийн 20-р зүйлд заасны дагуу битүүмжлэх процессыг дамжсан тохиолдолд тухайн хуулийн 23-р зүйлд заасны дагуу тухайн хүүхдийн тэтгэлэг төлөгч хураамж төлнө.

11.2.Хуулийн 11.1-т заасны дагуу хураамж нь шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд орсон бодит зардлаасаа хамаарч 2,000,000 вон хүртэл байхаар Эмэгтэйчүүд, гэр бүлийн сайд батлаж нийтэд зарласан.

11.3. Хуулийн 11.2-т заасны дагуу хураамжийг бэлэн мөнгөөр төлөх эсвэл мэдээлэл холбооны сүлжээг ашиглан цахимаар төлнө.

### **3.2.БНХАУ-ын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

Хятад улсын гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтад эцэг эх бологсод нь үр хүүхдээ асран тэжээж, сурган хүмүүжүүлэх үүрэгтэй байхаар заасан. Эцэг эх нь асран тэжээх үүргээ гүйцэтгэхгүй бол насанд хүрээгүй буюу биеэ дааж амьдарч чадахгүй хүүхэд нь эцэг, эхээсээ асран тэжээх зардал авахаар шаардах эрхтэй. Нялх хүүхдийг голж орхих ба нялх хүүхдийг хорлож хөнөөсөн бол цаазлана.

Эцэг, эх бологсод нь насанд хүрээгүй хүүхдээ хамгаалах, сурган хүмүүжүүлэх эрх, үүрэгтэй ба хүүхэд нь харилцан өв залгамжлах эрхтэй. Ураглахгүйгээр төрсөн хүүхэд нь ураглаад төрсөн хүүхэдтэй адил тэгш эрхийг эдлэх ба түүнд хор хүргэх ба гадуурхаж болохгүй. Ураглаагүй төрсөн үр хүүхдээ шууд асран тэжээх биш төрсөн эцэг тэрхүү хүүхдийн биеэ дааж амьдрал амьдралын зардал ба сурган хүмүүжүүлэх зардлыг гаргах үүрэгтэй.

Өргөсөн эцэг эх ба өргөмөл үр хүүхдийн хоорондох эрх, үүрэгт тус хуулийн эцэг, эх үр хүүхдийн харилцааны холбогдох бүхий тогтоолыг хэрэглэдэг, өргөмөл хүүхэд болон төрсөн эцэг эхийн эрх, үүрэг нь өргөж авсан харьцаа бий болсон цагаас устана. Хойд эцэг эх болон дагуул хүүхдийг гадуурхаж болохгүй.

Ураг салсны дараа эцэг, эх нь мөн хүүхдээ асран тэжээж, сурган хүмүүжүүлэх эрх, үүрэгтэй. Ураг салсны дараа хөхүүлийн хугацаанд байгаа хүүхдийг хөхүүлж байгаа эхэд нь дагуулж асран тэжээлгэхээр үүрэг болгоно. Хөхүүлийн хугацаа өнгөрсөн хүүхдийн асран тэжээх явдал дээр 2 этгээд маргалдаад хэлэлцэн тогтоож дийлэхгүй бол Ардын шүүх хорооноос үр хүүхдийн эрх ашиг ба 2 этгээдийн бодит байдлыг үндэслэн шүүн таслана. Ураг салсны дараа нэг этгээдийнхээ асран тэтгэж байгаа үр хүүхдийн амьдралын зардал ба сурган хүмүүжүүлэх зардлын хэсгийг нөгөө этгээд нь даах үүрэгтэй. Үүрэглэх зардлын их багын хэмжээ ба цаг хугацааны хэмжээ хязгаарыг 2 этгээд хэлэлцэн тохирох хэрэгтэй. Тохиролцоогүй үед Ардын шүүх хорооноос шүүн таслана.

Үр хүүхдийн амьдралын зардал ба сургалт хүмүүжлийн зардлын тухай хэлэлцээр буюу шүүн таслалт нь үр хүүхдийн чухал үед эцэг, эхийнхээ аль нэг этгээдэд хэлэлцээр буюу шүүн таслалтад хуулийн тогтоосон тоо хэмжээнээс хэтэрсэн зүй зохисгүй шаардлага гаргахыг хориглоно. Эцэг эх нь үр хүүхдээ эргэж үзэх явдал нь хүүхдийн бие, сэтгэлийн эрүүл мэндэд ашиггүй бол Ардын шүүх хорооноос хууль ёсоор зогсоно. Зогсоох шалтгаан нь арилсан байвал эргэж эрхийг нь сэргээнэ.

Гэр бүлийн харилцаа үргэлжилж байгаа хугацаандаа олсон эд хөрөнгөнөөс нэг этгээд нь үр хүүхдээ асран хамгаалах зэргээр илүү үүрэг хариуцлага хүлээсэн байвал нөгөө этгээдээс нөхөж авахаар нэхэмжлэл гаргах эрхтэй.

Тэтгэн тэжээх зардал, асран тэжээх зардал, ачлан тэжээх зардал, эд хөрөнгийг хувьдаа хуваах, өв залгамжлах, үр хүүхдээ эргэн үзэх зэрэгт шүүн таслалт буюу тогтоолыг тэвчсэн бол Ардын шүүх хороо хууль ёсоор албадан гүйцэтгүүлнэ. Холбогдол бүхий хувь хүн ба нэгж нь хасран гүйцэтгүүлэх хариуцлага үүрэглэх хэрэгтэй<sup>12</sup> гэжээ.

*Хүснэгт 5. Монгол болон Хятад улсын гэр бүл цуцлалт хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай маргааныг шийдвэрлэж буй байдлын харьцуулсан судалгаа*

### Нийтлэг тал:

Монгол	Хятад
<p><b>Гэрлэх нөхцөл:</b> эрэгтэй, эмэгтэй 2 бусдын нөлөөлөлгүйгээр, харилцан хайр сэтгэлийн үндсэн дээр гэрлэх, бүртгүүлэх, тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх гэр бүлийн гишүүд бие биенээ хүндэтгэх асарч тэтгэх, гэрлэлт цуцлах нөхцөл журам болон гэрлэхэд харшлах зүйл</p> <p><b>Агуулга:</b> Гэр бүлийн харилцаанд зайлшгүй зааж хуульчлах ёстой асуудлыг багтааснаараа адил юм.</p> <p><b>Зарчим:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1.Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэх;</li> <li>2.Гэрлэхэд нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглох;</li> <li>3.Гэр бүл нийгмийн үндсэн нэгж болох;</li> <li>4.Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төрөөс хамгаалах;</li> <li>5.Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх гэж тогтоожээ.</li> </ol> <p><b>Гэрлэхэд харшлах шалтгаан:</b> - өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол;</p>	<p><b>Гэрлэх нөхцөл:</b> эрэгтэй, эмэгтэй 2 бусдын нөлөөлөлгүйгээр, харилцан хайр сэтгэлийн үндсэн дээр гэрлэх, бүртгүүлэх, тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд бие биенээ хүндэтгэх асарч тэтгэх, гэрлэлт цуцлах нөхцөл журам болон гэрлэхэд харшлах зүйл</p> <p><b>Агуулга:</b> Гэр бүлийн харилцаанд зайлшгүй зааж хуульчлах ёстой асуудлыг багтааснаараа адил юм.</p> <p><b>Зарчим:</b> БНХАУ-ын Ургийн хуульд гэрлэлт гэр бүлийн хуулийн зарчмыг тусгайд нь бүлэг болгон жагсаан бичиглээгүй боловч хуулийн нэг хоёрдугаар зүйлүүдэд манай хуульд дурьдсан зарчмууд үндсэндээ багтсан байна. Харин давхар ураглах, хууль ёсны нөхөр эхнэртэй байгаад өөр хүнтэй эр эмийн харилцаа тогтоохыг хориглох, төлөвлөгөөтэй хүүхэд төрүүлэх гэх мэт харилцаанд баримтлах зарчмыг заасан нь онцлогтой байна.</p> <p><b>Гэрлэхэд харшлах шалтгаан:</b> 1.Шууд цусан төрөл болох ба 3 үеийн доторхи үеэл, хаяал цусан төрөл 2 эмнэлгийн ухаанд ураглаж болохгүй</p>

<sup>12</sup>Т.Мөнхжаргал, Б.Батбаяр. БНХАУ-ын Иргэний хууль, түүнд холбогдох хуулиудын эмхтгэл. 2010 он.163 дахь тал

<p>- гэрлэгсдийн хэн нэг нь насанд хүрээгүй бол;  - харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх;  - үрчлэгч, үрчлүүлэгч хоёр гэрлэх;  - гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол</p> <p><b>Гэрлэлт бүртгэх журам:</b>  Бүрдүүлэх материал  1.тус хүний өрхийн дэвтэр доторхи шууд бус цусан төрлийн харьцаагүй байхаа гэрчилсэн гарын үсэг зурсан илэрхийлэлт</p>	<p>гэж үзсэн өвчинд нэрвэгдсэн гэсэн 2 шалтгааныг заажээ.</p> <p><b>Гэрлэлт бүртгэх журам:</b>  1.гэрлэхийг хүсэгчдийн иргэний үнэмлэх  2.эрүүл мэндийн тодорхойлолт  Гэрлэхийг хүсэгч нь өмнө нь гэрлэж байсан бол гэрлэлтээ цуцлуулсан нь гэрлэгсэд өөрийн оршин суугаа газрын засаг захиргааны байгууллагад өөрсдийн биеэр очиж бүртгүүлэх, бүртгүүлэхдээ зайлшгүй шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, бүртгүүлж үнэмлэх авмагц гэрлэлтийн харилцаа үүсэх зэрэг зохицуулалт ижил байна.</p>
---	---

**Ялгаатай тал:**

<b>Монгол:</b>	<b>Хятад:</b>
<p><b>Гэрлэх нас:</b> эрэгтэй, эмэгтэй хоеулаа 18 насанд хүрсэн байх  <b>Нөхөн бүртгэх:</b> Манай хуульд ийм заалт байхгүй.</p>	<p><b>Гэрлэх нас:</b> Эрэгтэй хүн 22 нас, эмэгтэй хүн 20 насанд хүрсэн байх. Орой ураглаж, орой хүүхэд авахыг урамшуулан зоригжуулах хэрэгтэй гэжээ.  <b>Нөхөн бүртгэх:</b>Ургийн хуулийн 8 зүйлд Бүртгэлийн байгууллага хуульд нийцсэн байвал бүртгэн өгч, ургийн үнэмлэх олгоно. Ураг барилдах бүрдүүлэлт хийгээгүй байвал нөхөн бүрдүүлэх хэрэгтэй  <b>Гэр бүлийн гишүүдийн бие биеэ асран тэтгэх үүрэг:</b> Эцэг, эх нь салах өөр хүнтэй гэрлэх зэрэг гэр бүлийн харилцаанд өөрчлөлт орсон ч эцэг, эх, үр хүүхдийг асран тэжээх, сурган хүмүүжүүлэх эрх үүрэгт ямар нэг сөрөг өөрчлөлт гарахгүй.</p>



<p style="text-align: center;"><b>Гэрлэлт цуцлахад хүүхдийн асуудал:</b></p> <p>Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжинд үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхээ хэний асрамжинд үлдээх тухайгаа тохиролцож болно. Хэрэв тохиролцоогүй бол хүүхдийн нас, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжинд үлдээх тэтгэлгийн хэмжээ тогтоох асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Мөн хүүхэд 7 ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ.</p>	<p style="text-align: center;"><b>Гэрлэлт цуцлахад хүүхдийн асуудал:</b></p> <p>Ургийн хуулийн 36-р зүйлд: Эцэг эх болон үр хоорондын харилцаа нь эцэг эхийнх нь ураг салснаас болж тасрах биш, ураг салсны дараа үр хүүхдээ эцэг буюу эхийн аль нэг нь шууд асран тэжээсэн ч мөн л эцэг эх хоёр этгээдийн үр хүүхэд болно. Ураг салсны дараа эцэг эх нь мөн л үр хүүдээ асран тэжээх сурган хүмүүжүүлэх эрх ба үүрэгтэй. Мөн хуулийн 37 зүйлд Ураг салсны дараа нэг этгээдийн асран тэжээж байгаа үр хүүхдийн чухал бүхий амьдралын зардал ба сургах, хүмүүжлийн зардлын хэсгийг буюу бүгдийг нөгөө этгээд нь үүрэглэх хэрэгтэй. Үүрэглэх зардлын их багын хэмжээ ба үүрэглэх цаг хугацааны хэмжээ хязгаарыг 2 этгээдээр хэлэлцэн тохиролцох хэрэгтэй Өсгөн тэжээх зардалд үр хүүхдийн амьдралын зардал, сурган хүмүүжүүлэх зардал болон эмнэлгийн зардлыг заана гэжээ.</p>
---	--

### **3.3.Оросын Холбооны улсын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

ОХУ-ын Гэр бүлийн тухай хуулийг 1995 оны 12-р сарын 29-ны өдөр Төрийн Думаас баталсан бөгөөд 1997 оны 11 сарын 15, 1998 оны 6 сарын 27-нд тус тус нэмэлт өөрчлөлтийг хийсэн байна. Хуулийн үндсэн зорилго нь гэр бүл, эх, эцэг, хүүхдийн эрхийг төрөөс хамгаална хэмээн заасан байдаг.

ОХУ-ын гэр бүлийн эрх зүйд гэр бүл болох нөхцөл нь эрэгтэй эмэгтэй хүний сайн дурын зөвшөөрөл шаардлагатай ба гэрлэх насанд хүрсэн байна. /Гэр бүл болоход 18 нас хүрсэн байна./

Гэр бүл болохыг хүссэн хүний оршин суугаа газрын орон нутгийн захиргааны алба нь хүсэлт гаргасан этгээдүүдийн үндэслэлтэй шалтгааныг үндэслэн, тухайн хүмүүсийн хүсэлтээр, 16 нас хүрсэн хүний гэрлэлтийг зөвшөөрч болно. 18 нас хүрэхээс өмнөх онцгой нөхцөл байдлыг авч үзэх, гэрлэлтийг батлах, тайлбарлах нөхцөл, журам нь Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу байх болно.

Гэрлэлтийн эрх доорхи хүнд олгогдохгүй болно:

-өөр гэрлэлтэнд бүртгэлтэй;

-ойр төрлийн бүтэн болон бүтэн бус харилцаа (эцэг эх, хүүхэд, эмээ, өвөөтэйгэй гарал үүслээр болон удмаар шууд холбоотой), (нэг аавтай эсвэл ээжтэй байх) ах дүү нар);

-үрчилсэн эцэг эх ба үрчүүлсэн хүүхдүүд;

-оюун санааны сэтгэхүйн гажигийн улмаас хуулийн дагуу чадваргүй гэдгийг шүүхээр тогтоосон хүн.

Гэр бүлийн хэргийг бүртгэх товчоонд гэрлэлтийг цуцлахдаа өмч хөрөнгийг хуваах, хөдөлмөрийн чадваргүй, орон гэргүй эхнэр нөхөрт туслалцаа болох төлбөр, түүнчлэн шүүхээр хуулийн дагуу чадваргүй эсвэл гэмт хэрэг үйлдэн гурваас дээш жилээр хорих ял авсан гэдгийг шүүхээр тогтоогдсон эхнэр нөхрийн хооронд үүсэх хүүхэдтэй холбогдох маргааныг цуцлахаас гадна шүүхээр хянан шийдвэрлэнэ.

Хүүхдийн тэтгэлэг төлөх тохиролцоог эцэг эхчүүд байгуулж болдог ба хэрвээ тохиролцоо буюу гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийг хувиараа төлөх буюу нэхэмжлэгчийн банк дахь дансанд шилжүүлэх, шуудангаар явуулах банкны карт, хадгаламжийн сертификатаа өгөх замаар төлбөрийг барагдуулж болно. Хэрэв эцэг, эхийн хэн нэг нь эсхүл хоёулаа насанд хүрээгүй хүүхэддээ тэтгэлэг төлөхгүй буюу үүрэгт тэтгэлэг төлөх тохиролцоо хийгээгүй бол эцэг, эхээс үүрэгт тэтгэлгийг эрх бүхий хүмүүсийн нэхэмжлэлээр шүүхийн журмаар гаргуулна.

Эцэг, эхийн хэн нэг нь буюу тэдгээрийг төлөөлж хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь насанд хүрээгүй хүүхдийн тэтгэлэг авахаас татгалзах хууль зүйн эрхгүй болно.

Тэтгэлэг авах тухай шүүхэд гаргах нэхэмжлэлийг эрх бүхий этгээд хүүхдийг насанд хүрсэн бүрэн хариуцлага хүлээх чадвартай болох аль ч үед гаргаж болно. Эцэг, эхийн эрхийг хассан буюу хязгаарласан, шүүхээс эрх зүйн чадамжгүй гэж тооцсон зэрэг шалтгаанаар эцэг, эхийн асрамжгүй үлдсэн хүүхдэд тэтгэлэг төлүүлэх ерөнхий журам үйлчилдэг.

Энэ нь хэн нэгний халамжид буюу асран хүмүүжүүлэх газар байх хүүхдийн тэтгэлгээс эцэг, эхийг чөлөөлөгдөхгүй ба хүмүүжүүлэгч байгууллагад төлнө. Тухайн байгууллагын дансанд оруулж тэнд нь хүүхэд тус бүрээр тооцон зарцуулна. Ингэхдээ асран хүмүүжүүлэх байгууллагад орсон тэтгэлгийн банкны хадгаламжийн гэрээгээр банкинд байршуулан түүний эргэлтийн 50 хувийг тэтгэлэг эзэмшигч хүүхдэд ганцааранд нь бус, тухайн байгууллагад хүмүүжиж буй бүх хүүхдэд зориулан зарцуулах эрх эдэлнэ.

Насанд хүрээгүй хүүхдийн тэтгэлгийг шүүхийн журмаар эцэг, эхээс нэхэмжлэн гаргуулах сарын хэмжээг төлөгчийн цалингийн хувиар доорхи байдлаар гаргуулдаг.

№	Хүүхдийн тоо	Сар бүр орлогоос авах хэмжээ	Тэтгэлэг төлөгчийн цалин бусад орлого
1	1	1/4	
2	2	1/3	
3	3 ба түүнээс дээш	1/2	

Энэ суутгалын хэмжээг талуудын материалын болон гэр бүлийн байдал буюу анхаарвал зохих бусад нөхцөл байдлыг /ажилладаг буюу арилжааны үйл ажиллагаа явуулдаг, хариуцагч цалингүй буюу ажил олох боломжгүй, хариуцагчийн насны буюу эрүүл мэндийн хувьд хөдөлмөрийн чадваргүй, хариуцагчийн цалин хэт их, хэт бага гэх мэт/ харгалзан ихэсгэж, багасгаж болно.

Эцэг, эхэд хувь тооцох замаар насанд хүрээгүй хүүхдэдээ төлж буй тэтгэлгийн хөдөлмөрийн хөлсийг Засгийн газар тодорхойлно. Насанд хүрээгүй хүүхдэд тэтгэлэг төлөх хөдөлмөрийн хөлс гэдэг хөдөлмөрийн хөлсний бүх төрлийн үндсэн, ажлын газрын нэмэгдэл, урамшуулал хамаардаг. Засан хүмүүжүүлэх ял заагдсан этгээдийн хөдөлмөрийн хөлснөөс тэтгэлгийг суутгаж авна.

Иргэн хүнийг зөвхөн түүний эрүүл мэндийн байдал, амьдралын үйл ажиллагаа хязгаарлагдсан байдалд иж бүрэн үнэлгээ өгсөн анагаах ухаан, нийгмийн нөхцөл байдлын үзүүлэлтээр хөдөлмөрийн чадваргүй гэж үзнэ. Мөн тэтгэврийн насанд хүрсэн эцгийг хөдөлмөрийн чадваргүй гэж үзэх бөгөөд үүнтэй уялдан, насанд хүрсэн хүүхдүүд тэтгэлэг авах эрхтэй болж байгаа боловч амьдралд ийм нэхэмжлэл тун ховор гардаг. Насанд хүрсэн хүүхдийн тэтгэлгийг талуудын тохиролцооны үндсэн дээр

төлөх бөгөөд ийм хэлцэл хийгдээгүй тохиолдолд төлөх хэмжээг шүүх шийдвэрлэнэ.

Гадаад оронд байнга амьдарч буй этгээд тэтгэлэг төлөх ёстой.

Гэр бүлийн гишүүдтэй хуулийн дагуу хэлцэл байгуулах ба хэлцэлд хүрч чадаагүй тохиолдолд сонирхогч этгээд бэлэн мөнгөөр хураагдах тэтгэлгийн хэмжээг тогтоох, тэтгэлгийг нэг удаа бөөнөөр төлүүлэх, тэтгэлгийн оронд тодорхой эд хөрөнгө авах буюу түүнийг өөр аргаар төлүүлэх тухай шүүхэд хандах эрхтэй.

Шүүхээр тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх, чөлөөлөхдөө тэтгэлэг төлөх хэлцэл байхгүй бөгөөд тэтгэлгийн хэмжээг шүүх тогтоосны дараа аль нэгэн талын материалын ба гэр бүлийн байдал өөрчлөгдөн шүүх аль нэг талын шаардлагаар тогтоосон тэтгэлгийн хэмжээг өөрчлөх буюу тэтгэлэг төлөгч этгээдийг үүргээс чөлөөлөх боломжтой.

Тэтгэлэг авагчдын гэр бүлийн дотор тэтгэлэг төлөгчийн хувьд тэргүүн ээлжинд тэтгэлэг авах этгээд бий болсноор дараа ээлжинд тэтгэлэг авагчдын эрх зогсоогдоно. Тэтгэлэг авагчийн гэр бүлд тэтгэлэг авах бусад этгээд бий болбоос тэтгэлэг төлөгчийн шаардлагаар төлөх тэтгэлгийг бууруулах нөхцөлд тооцогдож болно. Тэтгэлэг авагч зохисгүй авир гаргасан тохиолдолд тэтгэлгийн нэхэмжлэл авах үндэслэлээ алдана.

Тэтгэлгийн нэхэмжлэлийг татгалзуулах нь хариуцлагын арга хэмжээ болох тул зөвхөн тэтгэлэг авагчийн гэм буруутай зан байдлын тохиолдолд л хэрэглэгдэнэ.

### ***ОХУ-ын гэрлэлтийн гэрээний тухай ойлголт:***

Эхнэр, нөхөр хоёрын хооронд өмч өмчлөх журмын талаар гэрээ байгуулах боломжийг анх удаа 1994 онд ОХУ-ын Иргэний хуульд дурдан ("Гэрлэгчдийн нийтийн өмч") дараа нь ОХУ-ын 1995 оны Гэр бүлийн тухай хуульд гэрлэлтийн гэрээ гэсэн тусдаа бүлгийг оруулсан.

ОХУ-ын Гэр бүлийн тухай хуулийн 40, 42 дугаар зүйлд гэрлэлтийн гэрээгээр эхнэр, нөхрийн дундын өмчлөл, түүнчлэн тус тусдаа захиран зарцуулах өмчлөлийн талаар хуульчлан тогтоосон. Тэд эд хөрөнгийн харилцаатай холбоотой бусад аливаа заалтыг гэрлэлтийн гэрээнд тусгаж болно. Тодруулбал, гэр бүлийн зардал гаргах, гэрлэлтийн үеэр болон гэрлэлтээ цуцлуулсны дараа бие биедээ өгөх мөнгөн тэтгэлгийн хэмжээ, хугацаа, үндэслэл, журмыг тогтоож болно.

ОХУ-д үл хөдлөх хөрөнгийн харилцаа (жишээлбэл: хүүхэдтэй салах тохиолдолд харилцах эрх) гэрлэлтийн гэрээний сэдэв байж чадахгүй.

Гэрлэлтийн гэрээг бичгээр үйлдсэн байх заавал нотариатаар батлуулах ба гэрлэлтийг улсын бүртгэлд бүртгүүлсэн үеэс эхлэн хууль ёсны хүчин төгөлдөр болно.

Гэрлэлийн гэрээ нь гэрлэлтийн туршид хүчин төгөлдөр байх бөгөөд эхнэр, нөхрийн харилцан тохиролцсоны үндсэн дээр хэзээ ч өөрчилж болон цуцалж болно. Энэ нь тодорхой эрх, үүрэг үүсэх (жишээлбэл, хүүхэд төрөх) эсвэл тохиолдохгүй байхаас хамаарч өөрчлөх боломжоос бүрдэнэ.

ОХУ-ын Гэр бүлийн тухай хуулийн 4-р зүйлд гэр бүлийн харилцааны мөн чанарт харшлахгүй тул гэр бүлийн гишүүдийн хоорондох эд хөрөнгийн харилцаанд иргэний хууль тогтоомжийг хэрэглэнэ гэж заасан байдаг. Үүний дагуу ОХУ-ын Иргэний хууль нь гэр бүлийн хуулиар зохицуулагддаг эхнэр, нөхөр хоорондын эд хөрөнгийн харилцаанд хамаарахгүй.

Гэр бүлийн тухай хуулийн 2-р зүйлд гэр бүлийн тухай хууль тогтоомжийг ... "гэр бүлийн гишүүд: эхнэр, нөхрийн хоорондох хувийн өмчийн харилцааг зохицуулна" гэж заасан ба 40-44-р зүйлд гэрлэлтийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлага тус тус ороогүй тул гэрээг нотариатаар батлуулахаар заасан. Гэр бүлийн тухай хуулийн 43-р зүйлд гэрлэлт цуцлагдсанаас хойшхи хугацаанд гэрлэлтийн гэрээнд зааснаас бусад үүрэг дуусгавар болно.

Гэрлэлтийн гэрээ нь гэрлэгчдийн хоорондох эд хөрөнгийн бус хувийн харилцааг зохицуулж чадахгүй. Энэхүү хориг нь юуны түрүүнд эдгээр харилцааг зохицуулах гэрээний нөхцлийг заавал ашиглах боломжгүй байдагтай холбоотой юм. Гэрлэлтийн гэрээ нь эхнэр, нөхрийнхөө үр хүүхэдтэй холбоотой хувийн эрх, үүрэгтэй холбоотой байж болохгүй.

Гэрлэлтийн гэрээ нь эхнэр, нөхрийн эрх зүйн чадвар, чадамж, тэдний хамгаалалтад авахаар шүүхэд хандах эрхийг хязгаарлаж чадахгүй. Энэхүү хориг нь гэрлэлтийн гэрээнд гэрлэлтийг өөрчлөх, цуцлах, хүчингүй болгох, аж ахуй эрхлэх үйл ажиллагаа эрхлэх, орлого авах, гэрээслэх, өв хүлээн авах гэх мэт нэхэмжлэлээр шүүхэд хандахыг хориглосон заалтыг гэрлэлтийн гэрээнд агуулж болохгүй гэсэн үг юм.

Гэрлэлтийн гэрээг бичгээр байгуулдаг бөгөөд ихэнх орны хууль тогтоомжийн дагуу нотариатаар батлуулахыг шаарддаг. Жишээлбэл, Австри, Франц улсад нотариатаар батлуулдаг. ОХУ-ын Гэр бүлийн тухай хуулийн 41-т талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрлэлтийн гэрээнд өөрчлөлтийг хэзээ ч хийж болно. Энэ тохиолдолд гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлнэ. Гэрлэлтийн гэрээг биелүүлэхээс дангаар татгалзах боломжгүй юм. Ийм татгалзсан тохиолдолд нөгөө тал /эхнэр-нөхөр/ нь гэрээний биелэлтийг хангуулахаар шүүхэд хандах эрхтэй.

### **3.4.Швед Улсын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

Шведийн эцэг, эхийн үүргийн тухай хуульд гэр бүл салах, хүүхдийг тэжээн тэтгэхтэй холбоотой дараах заалтууд байна.

#### **5 дугаар бүлэг. Гэр бүл салалт**

1 зүйл. Гэрлэгчид гэрлэлтээ цуцлахыг зөвшөөрвөл тэд салах эрхтэй. Эхнэр, нөхөр хоёулаа хүсэлт гаргасан, эсхүл тэдний хэн нэг нь тухайн гэр бүлийн асрамжид байгаа 16 нас хүрээгүй хүүхэдтэйгээ байнга амьдардаг бол энэ талаар эргэцүүлэн бодох хугацааг бичнэ.

2 зүйл. Хэрэв гэрлэгчдийн зөвхөн нэг нь л гэрлэлтээ цуцлуулахыг хүсч байгаа бол тэр эхнэр/нөхөр нь хэсэг хугацааны дараа л салах эрхтэй.

3 зүйл. Гэрлэлтийг цуцлуулахаар хамтарсан өргөдөл гаргах, эсвэл эхнэр/нөхрийнхөө нэг нь гэрлэлтээ цуцлуулах тухай нэхэмжлэлийг нөгөө талдаа мэдэгдсэнээр хугацаа эхэлдэг. Хэрэв хугацаа дор хаяж зургаан сар үргэлжилсэн ба эхнэр, нөхрийн аль нэг нь энэ талаар салах хүсэлт гаргасан бол гэр бүл цуцлах тухай шийдвэр гаргана. Хэрэв ийм нэхэмжлэлийн хугацаа эхэлснээс хойш нэг жилийн хугацаанд хүсэлт гаргаагүй бол гэр бүл салалтын асуудал цуцлагдана. Хэрэв гэрлэлт цуцлуулах шийдвэрийг хэрэгсэхгүй болгосон эсвэл хэргийг хаасан бол тусгах мөн хугацаа дуусна.

4 зүйл. Хэрэв эхнэр, нөхрүүд хоёроос доошгүй жил тусдаа амьдарсан бол тус бүр нь урьдчилан мэдэгдэлгүйгээр салах эрхтэй.

5 зүйл. Эхнэр/нөхрөө заавал гэрлэлтээ цуцлуулах шаардлагатай гэж үзсэн, эсвэл 18 нас хүрэхээсээ өмнө гэр бүл болсон бол эхнэр/нөхөр нь урьдчилан мэдэгдэлгүйгээр гэрлэлтээ цуцлуулах эрхтэй. Хэрэв гэрлэгчид хоорондоо цусан төрлийн холбоотой, эсвэл бүтэн ах дүүс байсан хэдий ч гэрлэлтээ батлуулсан бол эхнэр, нөхөр тус бүр урьдчилан мэдэгдэлгүйгээр гэрлэлтээ цуцлуулах эрхтэй. Гэрлэгчид аль нэг нь аль хэдийн гэрлэсэн бөгөөд өмнөх гэрлэлт нь цуцлагдаагүй тохиолдол мөн адил хамаарна.

Эхний хэсэгт дурдсан тохиолдолд гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг улсын яллагч гаргаж болно. Насанд хүрээгүй хүний байгуулсан гэрлэлтийн тухайд тухайн иргэний бүртгэлд хамрагдсан хотын захиргаанд байгаа нийгмийн халамжийн зөвлөл, эсвэл энэ улсад бүртгэгдээгүй бол түүний оршин суугаа хотын захиргаанд мэдээлэл өгөх үүрэгтэй.

6 зүйл. Гэрлэлт цуцлуулах тухай шийдвэр хууль ёсны хүчин төгөлдөр болсон тохиолдолд гэрлэлт цуцлагдана.

Гуравдугаар хэсэг.Эдийн засгийн нөхцөл байдал

1 зүйл. Эхнэр, нөхөр тус бүр хөдөлмөрлөх чадварынхаа хирээр дундын болон хувийн хэрэгцээг хангахад шаардагдах зардалд хувь нэмэр оруулна. Эцэг эхийн тухай хуульд хүүхдийн асрамжийн талаар заасан байдаг.

2 зүйл. Хэрэв эхнэр/нөхрийн оруулах зүйл нь тухайн хувийн хэрэгцээнд эсвэл гэр бүлээ тэжээхээр өөрөөр тохиролцсон төлбөрт хангалтгүй байвал нөгөө нь шаардлагатай мөнгийг оруулна.

3 зүйл. Дээрх 1, 2-р хэсгүүдийн зорилгоор эхнэр, нөхрөөс хувийн хэрэгцээнд зориулж авсан зүйл бол хувийн өмч юм.

4 зүйл. Өвчний улмаас эсвэл гэртээ байхгүйн улмаас эхнэр, нөхөр хувийн амьдралаа авч явах чадваргүй, гэр бүлээ тэжээх боломж хомс бол нөгөө тал нь шаардлагатай хэмжээгээр өвчтэй эсвэл эзгүй байгаа эхнэр/нөхрийнхөө орлогыг өсгөж, эд хөрөнгөө буцаан авч, банкны үлдэгдэл болон бусад зүйлийг авч болно. Гэсэн хэдий ч эхнэр, нөхрийн хамтын амьдрал дууссан, эсвэл эдгээр асуудалд өвчтэй эсвэл эзгүй байгаа эхнэр/нөхрийг төлөөлөх эрхтэй зөвлөх, асран хамгаалагч эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч байгаа тохиолдолд энэ нь хамаарахгүй.

5 зүйл. Нөхөр, эхнэрийн нэг нь тэжээн тэтгэх үүргээ үл тоомсорловол шүүх тухайн эхнэр, нөхрийг тэтгэлэг төлөхийг даалгаж болно.

6 зүйл. Хэрэв эхнэр, нөхрүүд байнга хамт амьдардаггүй бол нэг тал нь тэтгэлэг төлж тэжээн тэтгэх үүргээ биелүүлнэ. Шүүх нь эхнэр, нөхрүүд байнга хамт амьдардаггүй тохиолдолд аль нэгд нь хөрөнгөө үлдээхээр шийдвэрлэж болно. Энэхүү эрх нь хамтын амьдрал дуусахад гэрлэгчдэд эсвэл тэдний аль нэгэнд нь байсан өрхийн эд хөрөнгөд л хамаарна. Шүүхийн эд хөрөнгийн талаархи шийдвэрийн дараа гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ нь гэр ахуйн бараа бүтээгдэхүүнийг ашиглах эрхийг хязгаарлахгүй.

7 зүйл. Гэрлэлтээ цуцлуулсны дараа эхнэр, нөхөр тус бүрийг арчлах үүрэгтэй. Энэ үед эхнэр/нөхрийн нэг асрамжийн тэтгэмж авах шаардлагатай бол хөдөлмөрийн чадвар, бусад нөхцөл боломжийн дагуу тэтгэмж авах эрхтэй. Хэрэв гэрлэлт цуцлагдсаны дараа эхнэр/нөхрийн нэг нь өөрийгөө тэжээхэд бэрхшээлтэй байгаа эсвэл бусад онцгой шалтгаан байгаа бол илүү удаан хугацаанд нөгөө эхнэр, нөхрөөсөө тэтгэлэг авах эрхтэй. Энэ эрхийг судлахдаа нэг эхнэр/нөхөр тэтгэврийн хамгаалалт авахад буцалтгүй тусламж шаардлагатай байгаа эсэхийг харгалзан үзэх ёстой.

8 зүйл. Гэрлэлт цуцлалтын дараах тэтгэмжийг тасралтгүй төлнө. Хэрэв тэтгэвэр тогтоолгох эрх бүхий этгээд тэтгэвэр авахын тулд шимтгэл

шаардагдах гэх мэт онцгой шалтгаан байгаа бол шүүх шимтгэлийг нэг удаа олгохоор шийдвэрлэж болно.

9 зүйл. Хангамж, тэтгэмжийн талаар тогтоосон арга хэмжээг хариуцах хүн зөвшөөрөөгүй тохиолдолд шаардсан ажиллагааг уг арга хэмжээг шийдвэрлэсэн өдрөөс гурван жилийн өмнөөс дээш хугацаагаар хойшлуулж болохгүй.

10 зүйл. Тэтгэмж шаардах эрх нь анх хэрэгжсэн хугацаанаас хойш гурван жилийн дараа дуусна. Тэтгэмжийг дээрх заасан хугацаанаас өмнө хурааж авсан, эсхүл тухайн хугацаанаас өмнө өргөдөл гаргасан, дампуурсан гэж зарласан, нэхэмжлэлийн төлбөрийг дараа нь битүүмжлэгдсэн эд хөрөнгөөс гаргаж авах эсвэл дампуурлын хэлбэрээр хүлээн авч болно.

Хэрэв корпорацийг өөрчлөн байгуулах тухай хуульд заасны дагуу корпорацийг өөрчлөн байгуулах өргөдлийг дээрх хугацаанаас өмнө гаргасан бол корпорацийг өөрчлөн байгуулахыг цуцалсан шийдвэрийг зарласнаас хойш гурван сарын дотор тэтгэмж шаардаж болно. Хэрэв тохиролцоонд хүрсэн бол тооцоог дуусгаснаас хойш гурван сарын дотор нэхэмжлэлийг шаардаж болно. Хэрэв тэтгэмжийг хурааж авсан эсвэл дампуурлын өргөдлийг одоо тогтоосон хугацаанд гаргасан бол мөн адил хамаарна. Энэ хэсгийг зөрчсөн гэрээнүүд хүчин төгөлдөр бус байна.

11 зүйл. Нөхцөл байдал өөрчлөгдсөнийг харгалзан үзэх үндэслэл байгаа бол шүүхээс тэжээн тэтгэх тогтоол, гэрээг шүүх өөрчилж болно. Гэхдээ уг арга хэмжээ авахаас өмнөх хугацаанд аль нэг талын маргаанд тохируулга хийхийг зөвхөн төлөөгүй шимтгэлийг бууруулах эсвэл хасах байдлаар хийж болно.

Гэр бүл салалтын дараах тэтгэмжийг урьд нь тогтоосон тэтгэмжийн дээд хэмжээнээс хэтэрсэн онцгой шалтгаан байгаа тохиолдолд л нэмэгдүүлж болно. Тэтгэмжийг нэг удаагийн төлбөр хэлбэрээр аль нэг талын маргаанд тохируулж болохгүй. Тохиролцоо анх үүссэн нөхцөл байдал, ерөнхий нөхцөл байдлыг харгалзан үндэслэлгүй бол шүүхээс тэжээн тэтгэх гэрээг өөрчилж болно.

#### 7 дугаар хэсэг. Хөрөнгө

1 зүйл. Эхнэр нөхрийн өмч нь хувийн өмч биш гэр бүлийн хөрөнгө юм.

2 зүйл. Хувийн өмч нь:

1. гэрлэлтийн өмнөх гэрээний үр дүнд бий болсон хувийн өмч;
2. эхнэр, нөхөр нь өөр хэн нэгнээс бэлэг болгон авсан эд хөрөнгө;
3. эхнэр, нөхөр нь гэрээслэлээр хүлээн авсан эд хөрөнгө;
4. эхнэр, нөхрийнхөө өвлөж авсан эд хөрөнгө;



5.Тэтгэврийн хадгаламжийн тухай хуульд заасны дагуу эхнэр, нөхөр нь тэтгэвэр авагчийн амьдралын даатгал, ослын даатгал, эрүүл мэндийн даатгал, тэтгэврийн хадгаламжинд хүлээн авсан эд хөрөнгө;

Эхний хэсэгт дурдсан эрх зүйн баримт бичигт өөрөөр заагаагүй бол хувийн өмчийн ашиг нь гэр бүлийн хөрөнгө юм.

3 зүйл. Гэрлэхийн өмнөх гэрээний дагуу эхнэр, нөхрийн эсвэл ирээдүйд аль нэгэнд нь хамаарах буюу харьяалагдах эд хөрөнгийг түүний хувийн өмч байхаар шийдвэрлэж болно.

Гэрлэлтийн гэрээний дагуу гэрлэгчид үл хөдлөх хөрөнгийг гэр бүлийн шинж чанартай байхаар шийдэж болно. Гэрлэлтийн өмнөх гэрээг бичгээр үйлдэж, огноо, эхнэр/нөхөр гарын үсэг зурсан байх ёстой. Энэ нь тэдний аль нэг нь насанд хүрээгүй тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийг авах шаардлагатай.

Гэрлэлтийн өмнөх гэрээг Шведийн татварын албанд бүртгүүлэх ёстой. Эхнэр, нөхөр хоёрын хооронд байгуулсан гэрлэлтийн гэрээг Шведийн татварын албанд гэрлэснээс хойш нэг сарын дотор ирүүлээгүй хүчингүй болно. Түүнчлэн гэрлэх хүртэлх гэрээг зөвхөн Шведийн татварын албанд хүргүүлсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

4 зүйл. Гэрлэгсдийн хамтарсан оршин суух газрыг дараах байдлаар тогтоодог. Үүнд:

1. эхнэр, нөхөр, тэдний аль нэгнийх нь газар өмчилж, эзэмшиж байгаа үл хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн дотор гэрлэгчдийн нийтийн байшин байгаа бол уг эд хөрөнгийг голчлон эзэмшиж байгаа;

2. эхнэр, нөхөр, тэдгээрийн аль нэгнийх нь эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийг байшингийн хамт, эсвэл тэдгээрийн аль нэгнийх нь эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийг барилга байгууламжтай хамт эзэмшиж байгаа;

3. хэрэв барилга, байшингийн зарим хэсэг нь гэрлэгчдийн хамтарсан байшинд зориулагдсан бөгөөд голчлон энэ зорилгоор баригдсан бол гэрлэгчид эсвэл тэдгээрийн аль нэг нь түрээсийн, түрээсийн болон бусад ижил төстэй эрхээр эзэмшдэг барилга байгууламж;

4. гэр бүл, тэдгээрийн аль нэг нь ирээдүйд гэрээнд заасны дагуу урьдчилан тохиролцсоны дагуу эзэмших эрхтэйгээр олж авах эрхтэй барилга байгууламж эсвэл түүний хэсэг.

Гэрлэгчдийн нийтлэг гэр ахуйн бараа нь байшинд зориулагдсан тавилга, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл болон бусад дотоод хөдлөх эд хөрөнгийг хэлнэ. Гэр бүлийн нийтлэг бараанд зөвхөн нэг эхнэр / нөхрийн хэрэгцээнд ашиглагдах гэр ахуйн барааг оруулаагүй болно.

Гэрлэгсдийн хамтарсан орон сууц, гэр ахуйн бараанд голчлон чөлөөт цагаа өнгөрөөх зорилгоор ашигладаг эд хөрөнгийг оруулаагүй болно.

5 зүйл. Эхнэр, нөхөр нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр дараах үйл ажиллагааг явуулж болохгүй. Үүнд:

1. гэрлэгчдийн хамтын оршин суух газрыг бүрдүүлж буй үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах, барьцаалах, түрээслэх буюу бусад хэлбэрээр ашиглах эрхээр түрээслэх;

2. гэрлэгчдийн хамтын оршин суух газрыг бүрдүүлэх бусад хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах, барьцаалах, түрээслэх буюу бусад хэлбэрээр ашиглах эрхээр түрээслэх;

3. гэрлэгчдийн хамтарсан гэр ахуйн барааг захиран зарцуулах буюу барьцаалах.

Эхнэр, нөхрийн хувийн өмч болох орон сууц, гэр ахуйн бараа нь гэр бүлийн шинж чанартай бол эхнэр, нөхрийнхөө зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулах, барьцаалах, түрээслэх, эсхүл бусад хэлбэрээр ашиглах эрхтэйгээр үл хөдлөх хөрөнгийг түрээсэлж болохгүй. Гэсэн хэдий ч, гэр бүл цуцалсан тохиолдолд энэ нь хамаарахгүй.

Үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах, барьцаалан зээлдүүлэх зөвшөөрлийг зөвхөн бичгээр өгөх ёстой.

6 зүйл. Талийгаач эхнэр, нөхрийн үл хөдлөх хөрөнгөд мөн хамаарна.

7 зүйл. Дээрх 5, 6-д заасны дагуу эхнэр, нөхөр нь хүчин төгөлдөр зөвшөөрөл өгч чадахгүй, эсвэл зөвшөөрлийг нь боломжийн хугацаанд олж авах боломжгүй тохиолдолд зөвшөөрөл шаардагдахгүй. 5-р хэсэгт заасны дагуу гэрлэлтээ цуцлуулсны улмаас эд хөрөнгөө хувааж дууссаны дараа зөвшөөрөл авах шаардлагагүй болно.

8 зүйл. Дээрх 5, 6-д заасны дагуу зөвшөөрөл шаардагдаагүй тохиолдолд шүүх үүнийг хэрэгжүүлэхийг хүссэн этгээдийн өргөдөл дээр уг үйлдлийг зөвшөөрч болно.

9 зүйл. Хэрэв нас барсан эхнэр, нөхрийнхөө эд хөрөнгийг шаардагдах зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулсан бол шүүх үйл ажиллагааныхаа дагуу хууль эрх зүйн акт хүчин төгөлдөр бус болохыг мэдэгдэж, үл хөдлөх хөрөнгийг буцааж авна. Хэрэв нас барсан эхнэр, нөхрийн үл хөдлөх хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр дундын хөрөнгийг барьцаалсан бол мөн адил хамаарна. Гэрийн эд хөрөнгийг шилжүүлэх, барьцаалах нь шинэ өмчлөгч эд хөрөнгөө өөрийн итгэл үнэмшлээр олж авсан бол хүчин төгөлдөр бус гэж тооцогдохгүй. Нэхэмжлэлийг бусад эхнэр, нөхөр захиран зарцуулах тухай мэдсэнээс хойш гурван сарын дотор шүүхэд өгнө. Харин гэр ахуйн барааны хувьд эхнэр, нөхөр нь

шилжүүлгийг мэдсэн цагаас хойш хугацааг тооцдог. Хэрэв үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх, газар түрээслэхтэй холбогдуулан хууль ёсны бүртгэл, бүртгэлийг олгосон бол уг арга хэмжээг авч болохгүй. Хэрэв албадан нүүлгэх арга хэмжээг шүүх үндэслэлтэйгээр хойшлуулж болно.

8 дугаар хэсэг. Бэлэг

1 зүйл. Бэлэг бүртгэгдсэн бол эхнэр нөхөр хоёрын хоорондох бэлэг нь хүчин төгөлдөр болно. Бүртгүүлсэн тохиолдолд бэлэг нь бэлэглэгчийн эсрэг хүчин төгөлдөр болно. Хэрэв бэлэг нь санхүүгийн нөхцлөөс үл хамаарах хувийн бэлэг бол эхнэр, нөхөр хоёрын хооронд хүчинтэй, бүртгэлгүй хүчин төгөлдөр болно.

2 зүйл. Гэрлэлтийн өмнөх эхнэр, нөхрийн бэлэг өгөх амлалт хүчингүй.

3 зүйл. Эхнэр, нөхрийн өгсөн бэлэг нь хүлээсэн өрийг төлж чадахгүй бол бэлэглэгч үнэ цэнийн хомсдолыг хариуцна.

9 дүгээр хэсэг. Эд хөрөнгө хувиарлах ерөнхий заалтууд

1 зүйл. Гэрлэлт цуцлагдах үед эхнэр, нөхрийн хувийн хөрөнгийг эд хөрөнгийг хуваах замаар хооронд нь хуваана. Гэсэн хэдий ч эхнэр, нөхөр нь өөрсдийн хувийн өмчтэй, аль аль нь нөгөө талаасаа орон сууц, гэр ахуйн бараа бүтээгдэхүүнийг авахыг хүсээгүй тохиолдолд эд хөрөнгийг хуваах шаардлагагүй.

Хэрэв гэрлэгчид зөвшөөрвөл Шведийн Татварын газарт бичгээр мэдэгдсэний дараа гэрлэлт цуцлагдахаар хүлээгдэж буй тохиолдолд үл хөдлөх хөрөнгө, эд хөрөнгийг хувааж хуваарилж болно. Энэ тохиолдолд өргөдлийг Шведийн татварын агентлаг бүртгүүлэх ёстой.

2 зүйл. Эд хөрөнгийн хуваарилалтыг гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргасан өдөр, эсвэл гэрлэлт цуцлалгүйгээр нэг тал нь нас барсны улмаас эд хөрөнгийн харилцааны үндсэн дээр хийгдэнэ.

3 зүйл. Эхнэр, нөхөр бүр эд хөрөнгөө хуваах хүртлээ өөрийн эд хөрөнгөө тайлагнах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл эд хөрөнгийг хуваахад чухал ач холбогдолтой мэдээллийг өгөх үүрэгтэй.

4 зүйл. Эд хөрөнгийн хуваарилалтыг гэрлэлт цуцлагдсаны дараа гүйцэтгэнэ. Гэсэн хэдий ч гэрлэлт цуцлуулах тухай асуудал эцэслэн шийдэгдээгүй тохиолдолд эхнэр, нөхрийн аль нэг нь эд хөрөнгөө хуваах хүсэлт гаргасан тохиолдолд эд хөрөнгийг хуваах ажлыг нэн даруй хийх ёстой.

5 зүйл. Эд хөрөнгө хуваах ажлыг эхнэр, нөхөр хамтран гүйцэтгэдэг. Хөрөнгийн хуваарилалтын баримт бичиг гаргаж, хоёулаа гарын үсэг зурсан байх ёстой. Хэрэв эхнэр / нөхрийн аль нэг нь нас барсан бол эд хөрөнгийг хуваарилах ажлыг талийгаачийн өв залгамжлагчид болон бүх нийтийн гэрээслэгчид гүйцэтгэдэг. Энэ тохиолдолд эхнэр / нөхрийн

талаар тогтоосон зүйл нь өв залгамжлагчид болон гэрээслэгчдэд хамаарна.

6 зүйл. Талийгаачийн төлсөн эсвэл төлөх төлбөрийн хөрөнгийг тусгай асрамжийн газар эсвэл төлбөр тооцоонд оруулахаас өмнө аль нэг үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийн маргааны эсрэг эхнэр, нөхрийн бусад өв залгамжлагчид болон гэрээслэгчдийн хооронд эд хөрөнгийн хуваарилалт хийхийг хориглоно.

7 зүйл. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргасан тохиолдолд шаардлагатай хэмжээгээр эхнэр, нөхөр тус бүрийн хөрөнгө, өр төлбөрийг уг арга хэмжээ авах үеийнх шиг тэмдэглэнэ. Хэрэв үл хөдлөх хөрөнгийн бүртгэл авах шаардлагатай бол бүртгэгч томилж болно.

8 зүйл. Гэр бүл цуцлуулах ажиллагаа явуулсан тохиолдолд эд хөрөнгөө хуваах тохиолдолд эхнэр, нөхрийн нэгний эрхийг хамгаалах, шаардлагатай бол шүүх хүсэлтийн дагуу нөгөө талд нь эд хөрөнгө буюу түүний хэсгийг тусгай эзэмшилд байрлуулна.

9 зүйл. Хөрөнгийн хуваарилалт хийсэн ч эхнэр, нөхрийн хөрөнгийг өрөнд хурааж болно. Хэрэв үл хөдлөх хөрөнгийг тусгай эзэмшилд байрлуулсан бол тухайн өрийг нөгөө эхнэр, нөхөр хоёулаа хариуцна.

10 зүйл. Хөрөнгө хуваахаас өмнө эхнэр, нөхөр нь дампуурсан гэж зарлагдсан эсвэл эхнэр, нөхөр нь дампуурсны улмаас эд хөрөнгийг хувааж буцааж авсан бол тухайн гэр бүл болсон эд хөрөнгийг үл хөдлөх хөрөнгийг хувааж шийдтэл дампуурлын газрын захиргаанд байх ёстой. Хэрэв шаардлагатай бол үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулж болно.

11 зүйл. Гэрлэлт цуцлуулах хэрэг эцэслэн шийдэгдээгүй тохиолдолд эхнэр, нөхөр нь нас барсан бол гэрлэлтээ цуцлуулахтай холбоотой эд хөрөнгийг хуваахтай холбогдсон заалтыг баримтална.

12 зүйл. Гэрлэлт цуцлуулах тухай хэрэг эцэслэн шийдэгдээгүй байгаа хугацааг энэ хуульд үйл ажиллагаа явуулсан үеэс гэрлэлтээ цуцлуулах тухай шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл, эсвэл шүүх гэр бүл цуцлуулах асуудлыг няцаах буюу хасах тохиолдолд энэ тухай шийдвэр эцэслэн гарах хүртэл хугацаа гэж ойлгодог.

13 зүйл. Эхнэр нөхрүүд салахаасаа өмнө үл хөдлөх хөрөнгийг хуваах эсвэл үүнтэй холбоотой бусад зүйл дээр тохиролцож болно. Энэ тохиолдолд гэрээний дагуу баримт бичиг боловсруулж, гэрлэгчид гарын үсэг зурсан байх ёстой.

#### 8 дугаар хэсэг. Гэрлэлтийн хэрэг

1 зүйл. Гэрлэлтийн хэрэг нь гэр бүл цуцлах, гэрлэлт хүчинтэй болон хүчингүй талаарх болохыг батлах ажиллагаа явуулсан хэргийг хэлнэ.

2 зүйл. Гэрлэлт хүчинтэй болон хүчингүй талаарх тодорхойлох үйл ажиллагааг зөвхөн эхнэр, нөхрийн хоорондох маргаантай холбоотойгоор гаргаж болно.

3 зүйл. Гэрлэлтийн хэргийг эхнэр, нөхөр хоёрын аль нэг нь оршин суудаг газарт дүүргийн шүүх хянан хэлэлцдэг. Хэрэв тэдгээрийн аль нь ч энэ улсад оршин суудаггүй бол хэргийг Стокгольм дүүргийн шүүх хянан хэлэлцдэг.

4 зүйл. Хэрэв эхнэр, нөхөр хоёулаа салах хүсэлтэй байгаа бол тэд хамтдаа өргөдөл гаргаж болно. Бусад тохиолдолд гэрлэлтийн хэргийн талаар зарлан дуудах өргөдөл гаргаж шаардагдах ёстой.

5 зүйл. Гэр бүл цуцлалтын тохиолдолд шүүх арчлалт, хүүхдийн асрамж, хүүхдийн орон сууц, хүүхдүүдтэй холбоо тогтоох, эд хөрөнгийг хуваах хүртэл гэрлэгчдийн хамтарсан байранд үлдэх эрх, бие биетэйгээ уулзахыг хориглох зэрэг асуудлыг сонсож болно. Ийм асуудлаар нэхэмжлэлийг гэр бүл цуцлуулах нэхэмжлэл гаргасан өргөдөлд оруулсан болно. Хэрэв ийм арга хэмжээ аль хэдийн ирүүлсэн бол нэхэмжлэлийг шүүхийн өмнө амаар буюу тусгайлан зарлан дуудахгүйгээр бичгээр гаргаж болно.

6 зүйл. Гэрлэлт цуцлуулах тухай хүсэлт гарсны дараа шүүх гэр бүл цуцлуулах тухай шийдвэрийг нэн даруй гаргаж болох эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв тусгах хугацаа шаардлагатай бол шүүх талуудад тусгах хугацаа дуусч байгааг мэдэгдэж, хэргийг цаашид хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл өгнө.

7 зүйл. Гэрлэлт цуцлагдсан тохиолдолд шүүх хэргийг эцэслэн шийдсэн шийдвэрийг эхнэр, нөхрийн аль нэгний хүсэлтээр эцэслэн шийдвэрлэж болно.

1. гэрлэгчдийн хэн нь эхнэр нөхрийн хамтарсан байранд үлдэх эрхтэйг, гэхдээ эд хөрөнгийг хуваах хүртэл хамгийн удаан хугацаанд шийдэх;

2. эхнэр, нөхрийнхөө асрамжийн төлбөрийг төлөх үүргийг захиалах.

Шүүх тухайн асуудлыг эцэслэн шийдэгдэх хүртэл хугацаанд эхнэр, нөхрийн аль нэгний хүсэлтээр эхнэр, нөхөр бие биетэйгээ уулзахыг хориглож болно.

Гэрлэлт цуцлуулах тохиолдолд шүүх эцэг эхийн хуулийн заалтыг үндэслэн асран хамгаалалт, орон байр, холбоо барих болон хүүхдийн тэтгэлэг авахад хамаарах зүйл, шүүхийн шийдвэрээр эцэслэн шийдэгдэх хүртэл хугацаанд хамаарах зүйлийг хэрэглэдэг.

8 зүйл. Шүүхээс эхнэр, нөхрийн хамтарсан байранд үлдэх үндэслэлтэй гэж үзсэн эхнэр, нөхрийн гэр ахуйн эд хөрөнгийг ашиглах эрхтэй.

9 зүйл. Шүүх 7-р зүйлд заасны дагуу шийдвэр зарлахаас өмнө нөгөө эхнэр / нөхрийн хувьд нэхэмжлэлийн талаар тайлбар өгөх боломжийг олгоно.

10 зүйл. Гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлтийн талаархи тусгай нэхэмжлэлийг шүүхэд амаар буюу бичгээр гаргана. Хэрэв нэхэмжлэлийг зөвхөн эхнэр, нөхрийн аль нэг нь гаргасан бол шүүх нэхэмжлэлийн талаар бусад эхнэр, нөхөртөө тайлбар өгөх боломжийг олгоно.

11 зүйл. Шүүхэд гэрлэлтээ цуцлуулах тухай хамтарсан өргөдөл гаргасны дараа эсвэл гэрлэлтээ цуцлуулах тухай нэхэмжлэлийг нөгөө эхнэр, нөхөртөө танилцуулсны дараа гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлээ буцааж татсан бол нөгөө эхнэр, нөхөр нь хүсвэл нэхэмжлэлийг үргэлжлүүлэн шалгаж үзнэ.

12 зүйл. Гэрлэгчид эсвэл тэдний хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулахыг шаардах үед нэхэмжлэлийг үндэслэн шүүх хуралдаангүйгээр шүүж болно.

13 зүйл. Шүүх гэрлэлтээ цуцлах шийдвэр гаргасан бол 7-р хэсгийн 1-р догол мөр, 2-р догол мөрийн дагуу зарласан шийдвэрүүдийг нэгэн зэрэг хянана. Шүүх шийдвэр гаргахдаа эхнэр / нөхрийнхөө нөгөө эхнэр / нөхөртөө тэтгэлэг төлөх үүргийн талаар шийдвэр гаргахдаа 7-р хэсгийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу гаргасан шийдвэрийг дахин хянана.

Хүүхдийн тэтгэлэгийг тус улс дараах байдлаар тогтоож байна.

№	Хүүхдийн тоо	Сар бүр орлогоос авах хэмжээ	Нийгмийн халамжаас шууд 254-950 Швед нэгж авдаг байхаар тооцдог.
1	1	254	
2	3	760	
3	4	940	
4	5	950	

### **3.5.ХБНГУлсын хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт**

ХБНГУ-д Гэр бүлийн хууль нь иргэний хуулийн нэг хэсэг бөгөөд гэрлэлт болон гэрлэгчдийн эд хөрөнгө, хамтран амьдрагчид, гэр бүл болон хамаатан садангийн эрх зүйн байдал болон харилцааг зохицуулдаг.

Гэр бүлийн хууль нь гэрлэх болон гэрлэлтийг цуцлах, гэрлэгчдийн эд хөрөнгө мөн гэрлэлтээ цуцалсанаас үүсэх хариуцлага (тэжээн тэтгэх, тэтгэмж өгөх) г.м зохицуулдаг. Үүнээс гадна хамаатан, төрөл садангийн тэтгэмжийн асуудал, эцэг эх, хүүхэд хоорондын эрх үүргүүд, үрчлэх мөн асрамжинд авах зүйлүүд зохицуулагддаг.

Энэхүү хуулинд заасан маргааны асуудлыг гэр бүлийн шүүх шийдвэрлэнэ. Германы гэр бүлийн хууль нь иргэний хуулийн (BaB Bargeliches Gesetz Bvch) –ийн 4-р боть дээр 1297-1921-р зүйлүүд дээр тусгагдсан байдаг.

Хамтран амьдрагч, мөн гэрлээгүй хосуудын эрх зүйн байдал нь (parta- Lebenspartnerschaftsgesetz) гэх хамтран амьдрагчидын хуульд тусгагдсан байдаг. Мөн гэр бүлийн маргааныг шүүхээр шийдвэрлэх процесс нь (ZPO- Zivilprozessordnung) гэх хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хуульд нарийн заасан байдаг.

Германы гэр бүлийн эрх зүйд сүй тавих гэдэг ойлголтын талаар хуульчилсан байна.

Энэ нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 1297-р зүйлд “Сүй тавьсан хосуудад гэрлэгчидийн хууль нөлөөлөхгүй буюу хүчин төгөлдөр хэрэгжихгүй” гэж заажээ. 1298-р зүйлд “Сүй тавьсан талуудын аль нэг нь сүйгээс буцвал нөгөөдөхдөө, мөн түүний эцэг эх юмуу оронд нь төлөөлсөн 3-дагч этгээдүүдэд сүй тавих гэсэн үндслэлээр зарцуулсан мөнгө, хөдөлмөр юмуу эд хөрөнгийг буцаан төлөх үүрэгтэй. Сүйгээс татгалзан цуцлах ноцтой үндэслэл байвал энэ үүргээс чөлөөлөгдөнө.” 1301-р зүйлд “Сүй тавьсан хосууд гэрлэхгүй харин сүйгээ цуцалвал нөгөөдөхдөө сүй тавьсан бэлэг, мөнгө, эд хөрөнгөө буцаан шаардах эрхтэй, эс өгвөл нөгөөдөхөө үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж шүүхээр нэхэмжлэж болно”.гэх зэргээр гэрлэлтийн өмнөх гэж хэлж болох сүйн талаарх зохицуулалтыг хуульчилжээ.

ХБНГУ-ын Иргэний хууль дахь гэрлэхэд харшлах дараах шалтгаан байна. Үүнд:

103.3 насанд хүрээгүй талын эцэг эх юмуу хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч нь гэрлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол гэрлэлтийг батлуулж болохгүй;

130.4. хөдөлмөрийн чадваргүй насанд хүрээгүй хүн гэрлэж болохгүй;

130.5.гэрлэлтэнд харшлах зүйл (гэрлэлтийг хориглох);

130.6.аль нэг тал нь өмнө нь гэрэлсэн, түүнийгээ албан хууль ёсоор цуцлаагүй бол гэрлэж болохгүй’

130.7. дотны төрөл садан, юмуу төрсөн, хагас эгч, ах, дүү нартай гэрлэж болохгүй.

Гэрлэгчдийг өөрсдийн хүсэлтээр тухайн албан тушаалтанд гэрлэх хүсэлт өгсөнөөр батлуулсанд тооцох бөгөөд уг албан тушаалтан гэрлүүлэхээс татгалзаж болохгүй хэрвээ хуулинд харшлах нөхцөл байхгүй бол бүртгэдэг.

Германы гэр бүлийн хуулийн зохицуулалтын нэг онцлог бол тусдаа амьдрагчдын эд хөрөнгийн зохицуулалт юм. 136.1.6.4-т "гэрлэгчид салснаас хойш 6-н сарын дотор нүүсэн эхнэр юмуу нөхөр эргэн ирэх хүсэлт гаргаагүй бол үүнийг нөгөө талдаа тухайн байрыг бүхэлд нь үлдээж байна гэж ойлгоно" гэжээ.

Насанд хүрээгүй хүүхдэд зориулах амьжиргааны тэтгэмжийн доод хэмжээ насанд хүрээгүй хүүхэд хамт амьдардаггүй эцэг эхээс амьдралын амьжиргааг хангуулах үүднээс тэтгэмжийн хувь хэмжээг шаардаж болно. Орлого татварын хуулийн 32-р зүйлийн 6.1-д заасан хүүхдийн оршин амьдрахад зайлшгүй амьжиргааг 2 дахин нэмж өгсөн тэтгэмжийн нувь хэмжээ болно. Үүнээс гадна хүүхдийн тэтгэмжийг дараах байдлаар тогтоож өгсөн байна.

Үёчлэл	Насны хязгаар	Амьжиргааны түвшнээс авах хувь
Түвшин	зургаан нас хүртэл	87%
Түвшин	7-12 нас хүртэлх	100%
Түвшин	13 наснаас дээш	117%

#### Гарчиг 7. Гэрлэлтийг цуцлах

##### Дэд гарчиг 1. Гэр бүл салах шалтгаан

1564 зүйл. Шүүхийн шийдвэрээр гэр бүл салгах тухай

Гэрлэгсдийн аль нэгний эсвэл хоёулангийнх нь хүсэлтийн дагуу, зөвхөн шүүхийн шийдвэрийн үндсэн дээр гэрлэлтийг цуцална. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноор гэр бүл цуцлагдсан гэж үзнэ. Гэрлэлт цуцлах хүсэлтийг дараах зохицуулалтын дагуу гаргана.

1565 зүйл. Гэр бүл сарних (бүтэлгүйтэх)

1.Гэр бүл бүтэлгүйтсэн нөхцөлд түүнийг цуцалж болно. Гэр бүл бүтэлгүйтсэн гэдэгт гэрлэгсдийн хооронд хамтын амьдрал байхаа больсон, ирээдүйд гэрлэгсэд хамтын амьдралыг сэргээнэ гэсэн хүлээлт үгүй болсныг ойлгоно.

2.Гэрлэгсэд тусдаа амьдраад 1 жил болоогүй нөхцөлд гэр бүлийн харилцааг үргэлжлүүлэх нь эсрэг талын хувийн шинж байдлаас болоод нөгөө талд тэвчишгүй хүнд байдал үүсгэхээр бол гэр бүлийг салгаж болно.

1566 зүйл. Гэр бүл сарнисан гэж үзэх хуулийн таамаг

1.Гэрлэгсэд 1 жилийн өмнөөс тусдаа амьдарч байгаа бөгөөд хоёулаа нэгэн зэрэг салах өргөдөл гаргасан эсвэл эсрэг тал салах хүсэлтийг



хүлээн зөвшөөрсөн бол гэр бүл сарнисан гэсэн няцааж үл болох таамаг үйлчилнэ.

2.Гэрлэгсэд 3 жил тусдаа амьдарч байгаа бол гэр бүл сарнисан гэсэн няцааж үл болох таамаг үйлчилнэ.

1567 зүйл. Тусдаа амьдрах

1.Гэрлэгсдийн хооронд гэр ахуйн нэгдэл үгүй болсон, нэг тал хамтын амьдралаас эрс татгалзаж байгаа нөхцөлд тэднийг тусдаа амьдардаг гэж үзнэ. Гэрлэгсэд гэр бүлийн орон сууцанд тус тусдаа амьдарч байвал нэг ахуй өрх гэж үзэхгүй.

2.Гэрлэгсэд эвлэрэхэд зориулан богино хугацаанд хамтран амьдарсан нь энэ хуулийн §1566-д заасан хугацааг түр зогсоох буюу тасалдуулахгүй.

1568 зүйл. Хүнд нөхцөл

1.Гэр бүл сарнисан ч гэсэн гэр бүлийн харилцааг үргэлжлүүлэх нь тухайн гэр бүлд мэндэлсэн насанд хүрээгүй хүүхдэд онцгой шалтгааны улмаас зайлшгүй чухал гэж үзэхээр эсвэл гэр бүл цуцлахыг эсэргүүцэж буй талд туйлын хүнд нөхцөл үүсэхээр бол хүсэлт гаргагчийн ашиг сонирхлыг тооцож үзсэний үндсэн дээр гэр бүлийг цуцлахгүй байж болно.

Дэд гарчиг 1а. Гэр бүл цуцласан нөхцөлд гэр бүлийн орон сууц, гэр ахуйн зүйлсийг хэрхэх тухай

1568 зүйл. Гэр бүлийн орон сууц

(1)Гэрлэгсдийн нэг нь гэр бүл цуцлах нөхцөлд тухайн өрхөд хамт амьдарч буй хүүхдийн сайн сайхан, гэрлэгсдийн ахуйг харгалзан үзэн нөгөө талаас илүүтэйгээр орон сууцанд үлдэх ашиг сонирхолтой эсвэл шударга ёсноос үүдэлтэй бусад шалтгаан бий болох нь тогтоогдвол нөгөө талаас гэр бүлийн орон сууцыг үлдээхийг шаардах эрхтэй.

(2)Гэрлэгсдийн нэг нь орон сууцанд байршуулсан үл хөдлөх хөрөнгийг дангаар эсвэл гуравдагч этгээдтэй хамтран өмчлөх эрхтэй эсвэл нэг талд болон гуравдагч этгээдэд үл хөдлөх хөрөнгөд узуфруктын эрх, бусдын газар дээр барилга байшин барих эрх эсвэл өмчийн эрх зүйн шинжтэй үл хөдлөх хөрөнгө дээр оршин суух эрх бий нөхцөлд эсрэг тал нь гагцхүү шаардлагатай нөхцөлд шударга бус хүндрэлийг даван туулах зорилгоор эдгээрийг өөрт шилжүүлэхийг шаардах эрхтэй. Орон сууц өмчлөх эрх болон урт хугацааны оршин суух эрхэнд энэ зохицуулалт нэгэн адил хамаарна.

(3)Орон сууцыг эзэмшилдээ авч буй гэрлэгч нийинхүү шилжүүлсэн тухай нөгөө тал хөлслүүлэгчид мэдэгдэл хүргэх цаг мөчид, эсвэл орон сууцыг шилжүүлсэн тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох үеэс шилжүүлэх үүрэг бүхий гэрлэгчийн оронд түүний байгуулсан эд хөрөнгө хөлслөх гэрээ эсвэл хамтдаа байгуулсан гэрээг дангаар үргэлжлүүлэх

болно. Энэ хуулийн §563.4-ийг төсөөтэй хэрэглэнэ. Гэрлэгсдийн нэг нь нөгөөгийн ажил хөдөлмөрийн харилцаанд гуравдагч этгээдтэй байгуулсан орон сууц хөлслөх гэрээнд тал болж орохыг гагцхүү гуравдагч этгээд зөвшөөрсөн эсвэл маш хүнд бэрх нөхцөлийг даван туулахад зайлшгүй тохиолдолд л шаардах эрхтэй. Гэр бүлийн орон сууцыг хөлслөх тухай гэрээ байхгүй бол шилжүүлэхийг шаардах эрхтэй гэрлэгч эсвэл үүнийг хөлслөх эрх бүхий этгээдийн аль аль нь гэрээг тухайн газар нутагт тогтсон жишгээр байгуулахыг шаардах боломжтой. Энэ хуулийн § 575.1-д заасан нөхцөлийн дагуу эсвэл хугацаагүй гэрээ байгуулах нь хөлслүүлэгчийн ашиг сонирхолд харш нөхцөлд хөлслүүлэгч гэрээг тодорхой хугацаагаар байгуулахыг шаардаж болно. Хөлсний талаар тохиролцоонд хүрэхгүй бол хөлслүүлэгч тохирох хөлсийг эсвэл тухайн газар нутагт хэвшсэн жишиг хөлсийг шаардах эрхтэй. Энэ зүйлийн 3-5 дахь мөрд заасны дагуу эд хөрөнгө хөлслөх гэрээнд тал болж орох эсвэл гэрээг байгуулахад чиглэсэн шаардах эрх нь гэр бүл цуцлах талаар шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон эсвэл шийдвэрээс хойш 1 жил өнгөрсөн бол дуусгавар болно.

1568 зүйл. Гэр ахуйн хэрэглээний зүйлс

(1) Гэрлэгсдийн хэн нь ч гэрлэлт цуцлах болсноор тухайн өрхөд хамт амьдарч буй хүүхдийн сайн сайхан, гэрлэгсдийн ахуйг харгалзан үзэхэд нөгөө талаас илүүтэйгээр орон сууцанд үлдэх ашиг сонирхолтой эсвэл шударга ёсноос үүдэлтэй бусад шалтгаан бий болох нь тогтоогдвол хамтын өмчлөлд буй ахуйн хэрэглээний зүйлсийн эзэмшил, өмчлөлийг шилжүүлэхийг шаардах эрхтэй.

(2) Гэрлэлтийн явцад хамтын ахуй амьдралд зориулан шилжүүлж авсан ахуйн хэрэглээний зүйлсийг хөрөнгө хуваах мөчид нэг талын дангаар өмчлөх эрх хөдлөшгүй нотлогдсоноос бусад тохиолдолд гэрлэгсдийн хамтын хөрөнгө хэмээн тооцно.

(3) Өмчлөх эрхээ энэ зүйлийн 1-ийн дагуу шилжүүлж буй гэрлэгч тохирох нөхөн төлбөрийг тэнцвэржилтийн журмаар шаардах эрхтэй.

Дэд гарчиг 2. Салсан этгээдэд олгох тэтгэмж

Хэсэг 1. Үндсэн зарчим

§ 1569 Өөрөө өөрийнхөө өмнөөс хариуцлага хүлээх үндсэн зарчим

Гэр бүл цуцалсны дараа гэрлэгсэд тус бүрнээ өөрийгөө тэжээн тэтгэх үүрэгтэй. Хэрэв аль нэг тал ингэх чадваргүй бол дараах зохицуулалтын дагуу эсрэг талаас тэтгэмж гаргуулах эрхтэй.

Хэсэг 2. Тэтгэмж авах эрх

§ 1570 Хүүхэд асрахтай холбоотой тэтгэмж

(1) Гэр бүлийг цуцалсны дараа дундын хүүхдийг асран хамгаалж,

хүмүүжүүлж буй тал нь хүүхэд төрснөөс хойш 3 жилийн хугацаанд нөгөө талаас тэтгэмж авах эрхтэй. Тэтгэмж авах эрхийн хугацааг шударга ёсонд нийцүүлэн сунгаж болно. Үүнд хүүхдийн эрх ашиг, хүүхэд асрах боломж боллоцоог анхаарч үзнэ.

(2) Тэтгэмж авах эрхийн хугацаа дээрхээс гадна хүүхэд асрах болон хөдөлмөр эрхлэх асуудлыг тухайн гэр бүлд зарцуулсан байдал, гэр бүл үргэлжилсэн хугацааг шударга ёсны үүднээс харгалзан дүгнэнэ.

§ 1571 Насан өндөр болсонтой холбоотой тэтгэмж

Салсан гэрлэгч нөгөө талаас дараах тохиолдолд тэтгэмж шаардах эрхтэй:

1. салах үед;

2. дундын хүүхдийг асрах, хүмүүжүүлэх асуудлыг дуусгавар болгох үед;

3. энэ хуулийн §§ 1572 -1573-д заасанчлан тэтгэмж авах эрхийн урьдчилсан нөхцөл дуусгавар болсон үеэс тухайн гэрлэгчийн насны улмаас хөдөлмөр эрхлэлт боломжгүй болсон.

§ 1572 Өвчин эмгэгийн улмаас тэтгэмж олгох:

Салсан гэрлэгч нөгөө талаас дараах тохиолдолд тэтгэмж шаардах эрхтэй:

1. салах үед;

2. дундын хүүхдийг асрах, хүмүүжүүлэх асуудлыг дуусгавар болгох үед;

3. боловсролын сургалт, үргэлжлүүлсэн сургалт эсвэл мэргэжил өөрчлөх сургалт дуусгавар болгох үед;

4. энэ хуулийн §1573-д заасанчлан тэтгэмж авах эрхийн урьдчилсан нөхцөл дуусгавар болсон үеэс эхлэн тухайн гэрлэгчийн өвчлөл, эмгэг, бие махбодийн болон оюун санааны сулралын улмаас хөдөлмөр эрхлэлт боломжгүй болсон.

§ 1573 Хөдөлмөр эрхлээгүй хугацаанд нөхөх тэтгэмж

(1) Гэр бүл цуцалсны дараа гэрлэгчид энэ хуулийн §§ 1570-1572-ын дагуу тэтгэмж авах эрх ноогдоогүй ч гэсэн гэрлэлт цуцалсны дараа зохих хөдөлмөр эрхлэх боломжгүй этгээд тэтгэмж авах эрхтэй.

(2) Тохирох хөдөлмөр эрхэлсэн ч орлого нь бүрэн тэтгэмжтэй (энэ хуулийн § 1578) адил хүрэлцэхгүй нөхцөлд энэ хуулийн §§ 1570-1572-ын дагуу тэтгэмж олгогдоогүй этгээд орлого болон бүрэн тэтгэмжийн зөрүүг эсрэг талаас нэхэмжлэх эрхтэй.

(3) Энэ зүйлийн 1 ба 2-ыг энэ хуульдйн §§ 1570-1572, 1575-ын дагуу бүрэн тэтгэмж олговол зохих нөхцөл үүссэн байсан ч эдгээрийн урдчилсан нөхцөл хожим үгүй болсон тохиолдолд нэгэн адил хэрэглэнэ.

(4) Гэр бүл цуцалсны дараа гэрлэгчийн тохирох хөдөлмөр эрхэлж олох орлого нь зогссон бөгөөд өөрийн тэтгэмжийг гэрлэлтийн дараа баталгаажуулах гэсэн оролдлогууд нь талаар болсон бол тэрээр тэтгэмж шаардаж болно.

(5) Тэрээр тэтгэмжийн зарим хэсгийг тогтвортой хугацаанд баталгаатай болгож чадсан бол бүрэн тэтгэмж ба баталгаажуулсан хэсгийн зөрүүг нэхэмжлэх эрхтэй.

(6) (Хүчингүйд тооцсон).

§ 1574 Тохирох ажил хөдөлмөр эрхлэх

(1) Гэр бүл салсны дараа гэрлэгч тохирох ажил хөдөлмөр эрхлэх үүрэгтэй.

(2) Тохирох ажил хөдөлмөр гэдэгт мэргэжлийн боловсрол, ур чадвар, өмнөх хөдөлмөр эрхлэлт, нас болон эрүүл мэндийн байдал, мөн тухайн гэр бүлийн амьжиргаанд нийцэх ажлыг ойлгоно. Гэр бүлийн амжиргаа гэдэгт гэрлэлт үргэлжлэх хугацаа болон дундын хүүхдийг асарч, хүмүүжүүлсэн хугацааг анхаарч үзнэ.

(3) Тохирох ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах сургалт, үргэлжилсэн сургалт, мэргэжлээ өөрчлөх сургалтыг амжилттай давж чадахаар нөхцөлд гэрлэгч эдгээр сургалтанд хамрагдах үүрэгтэй.

§ 1575 Боловсрол эзэмших, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлээ солих

(1) Гэр бүл болно гэсэн хүлээлтийн улмаас эсвэл гэрлэлтийн явцад сургалтанд хамрагдаж чадаагүй, сургалтаа орхисон этгээд тохирох ажил хөдөлмөр эрхлэхийн тулд нэн даруй сургалтанд хамрагдсан бөгөөд амжилттай дүүргэж чадахаар бол энэ хугацаанд эсрэг талаас тэтгэмж шаардах эрхтэй. Тэтгэмжийн хугацаа нь дээрх сургалт үргэлжлэх хамгийн дээд хугацаагаар олгогдох боломжтой; энэ хугацааг тооцоход гэр бүлээс болж удааширсан нөхцөлийг анхаарч үзнэ.

(2) Салсан этгээд гэр бүл болсны улмаас үүссэн сөрөг талыг арилгахын тулд сургалтанд хамрагдаж байвал дээрх зохицуулалтыг төсөөтэй хэрэглэнэ.

(3) Салсан гэрлэгч дээрх сургалтаа дүүргэсний дараа энэ хуулийн §1573-ын дагуу тэтгэмж шаардвал түүнд тохирох ажил хөдөлмөрийг (энэ хуулийн §1574. 2) тодорхойлоход боловсролын түвшинг харгалзан үзэхгүй.

§ 1576 Шударга ёсны улмаас тэтгэмж олгох

Салсан этгээд нь бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хөдөлмөр эрхлэх боломжгүй бөгөөд талуудын аль алиных нь ашиг сонирхлыг дэнслэн үзэхэд тэтгэмж олгохгүй байх нь хэт бүдүүлэг гэж үзэхээр бол эсрэг талаас тэтгэмж шаардах эрхтэй. Хүнд эсвэл хүндэтгэх шалтгаан

гэдэгт гэрлэлт цуцлахад хүргэснээс бусад шалтгааныг мөн оролцуулж үзнэ.

#### § 1577 Хэрэгцээт байдал

(1) Гэр бүл цуцалсны дараа гэрлэгч өөрийн орлого, хөрөнгөөс өөрийгөө хангалттай тэжээн тэтгэж чадахаар бол энэ хуулийн §§ 1570-1573, 1575 болон 1576-ийн дагуу тэтгэмж шаардах эрхгүй.

(2) Тэтгэмж төлөх үүрэг бүхий этгээд бүрэн тэтгэмж (энэ хуулийн §§ 1578 болон 1578b) олгохооргүй бол тэтгэмж авах эрх бүхий этгээдийн орлогыг харгалзан тооцохгүй. Бүрэн тэтгэмжээс давсан орлогыг харгалзах нь талуудын эдийн засгийн байдал, шударга ёсонд нийцэх нөхцөлд л хасан тооцно.

(3) Эрх бүхий этгээд суурь хөрөнгөө захиран зарцуулах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй эсвэл талуудын эдийн засгийн ашиг сонирхлыг харгалзан үзэхэд шударга бус байвал чингэх шаардлагагүй.

(4) Гэрлэлт цуцлах үед эрх бүхий этгээдийн тэтгэмж түүний хөрөнгөөс бүрэн хангагдана гэж үзэхээр байсан ч хожим хөрөнгө нь үгүй болсон бол тэтгэмж шаардах эрхгүй. Хөрөнгө үгүй болох үед дундын хүүхэд асрах, хүмүүжүүлэхтэй холбогдон тухайн этгээдээс хөдөлмөр эрхлэхийг шаардах боломжгүй бол дээрх зохицуулалт үйлчлэхгүй.

#### § 1578 Тэтгэмжийн хэмжээ

(1) Тэтгэмжийн хэмжээг тухайн гэр бүлийн харилцаанд хэвшсэн үзүүлэлтээр тодорхойлно. Тэтгэмж нь амьдралын нийт хэрэгцээг хамарна.

(2) Амьдрах хэрэгцээ гэдэгт эрүүл мэндийн зохих даатгалд хамрагдах, асран сувилуулахад шаардлагатай зардал, мөн энэ хуулийн §§ 1574, 1575-д тусгасан ерөнхий болон мэргэжлийг боловсрол эзэмших, мэргэжил дээшлүүлэх эсвэл ахин мэргэжил эзэмших зардал тус тус багтана.

(3) Гэр бүл цуцалсны дараа гэрлэгч энэ хуулийн §§ 1570 -1573 эсвэл § 1576-ийн дагуу тэтгэмж авах эрхтэй бол түүний амьдрах хэрэгцээнд өндөр насны болон хөдөлмөрийн чадвар алдахтай холбоотой даатгалын зардал багтана.

§ 1578a Хохирлын улмаас илүү зардал гарсан бол үүнийг хамрах тухай таамаг

Бие махбодь, эрүүл мэндийн хохирлын улмаас гарсан илүү зардлыг энэ хуулийн § 1610а-г тусгасан хэлбэрээр тооцно.

#### § 1578b Шударга бус нөхцөлд тэтгэмжийг бууруулах, хязгаарлах

(1) Гэр бүл цуцлуулсны дараа дундын хүүхдийг асрах, хүмүүжүүлэх ашиг сонирхлыг харгалзан үзсэний дүнд гэр бүлийн

хэрэгцээнд суурилан тэтгэмжийн хэмжээг тогтоосон байдал нь шударга бус гэж үзэхээр нөхцөлд гэрлэгчийн тэтгэмж шаардах эрхийг зохих хэрэгцээнд нийцүүлэн бууруулах боломжтой. Ингэхдээ анх гэр бүл болсноор өөрийгөө тэтгэх боломж бололцоо хэрхэн буурч сөрөг байдал үүссэн, мөн гэр бүл оршин тогтносон хугацаатай харьцуулахад тэтгэмжийг багасгах нь шударга бус эсэхийг харгалзаж үзнэ. Энэ зүйлийн 2 дахь өгүүлбэрт заасан сөрөг байдал нь дундын хүүхдийг асрах, хүмүүжүүлэх болон гэр бүл орших хугацаан дахь гэр ахуйг хөтлөх, хөдөлмөр эрхлэх зэргээс үүдсэн нөхцөлийг ойлгоно.

(2) Гэр бүл цуцалсны дараа дундын хүүхдийг асрах, хүмүүжүүлэх ашиг сонирхлыг харгалзан үзсэн ч хугацаагүй тэтгэмж олгох нь шударга бус нөхцөлд гэрлэгчийн тэтгэмж шаардах эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлана. Энэ зүйлийн 1 -ийн 2, 3 дахь өгүүлбэрийг төсөөтэй хэрэглэнэ.

(3) Тэтгэмжийг бууруулах, хугацааг хязгаарлах аргыг хамтатган хэрэглэж болно.

§ 1579 Хэт шударга бус гэж үзэх нөхцөлд тэтгэмжийг хязгаарлах, хасах

Дараах тохиолдолд дундын хүүхдийг асрах, хүмүүжүүлэх ашиг сонирхлыг харгалзан үзсэн ч гэсэн тэтгэмж шаардах нь шударга бус гэж үзэхээр бол тэтгэмж шаардах эрхийг хасах, бууруулах эсвэл хугацаагаар хязгаарлах боломжтой:

1. гэр бүл маш богино хугацаанд оршин тогтносон; үүнийг тогтоохдоо эрх бүхий этгээд нь дундын хүүхдийг асрах, хүмүүжүүлэхтэй холбогдуулан энэ хуулийн § 1570-ын дагуу тэтгэмж шаардах эрхтэй эсэхийг харгалзаж үзнэ,

2. эрх бүхий этгээд байнгын хамтын амьдралтай болсон,

3. эрх бүхий этгээд нь тэтгэмж олгох тал болон түүний төрөл садны эсрэг хүнд гэмт хэрэг, хүнд санаатай зөрчил үйлдсэн гэм буруутай,

4. эрх бүхий этгээд нь өөрийн хэрэгцээт байдлыг санаатай үүсгэсэн,

5. эрх бүхий этгээд нь тэтгэмж олгох үүрэг бүхий этгээдийн маш чухал хөрөнгийн ашиг сонирхлыг дур мэдэн үгүйсгэсэн үйлдэл хийсэн,

6. эрх бүхий этгээд нь тусдаа амьдарч эхлэхээс өмнө гэр бүлээ тэжээн тэтгэх үүргээ нилээд урт хугацаанд бүдүүлгээр зөрчиж байсан,

7. эрх бүхий этгээд нь тэтгэмж олгох үүрэг бүхий этгээдийн эсрэг илт хүнд, өөрөөс шалтгаалсан буруу үйлдэл хийсэн эсвэл

8. энэ зүйлийн №1-7-д заасантай адилтгахуйц хүнд бусад нөхцөл үүссэн.

### § 1580 Мэдээлэл өгөх үүрэг

Салсан гэрлэгсэд нэг талын шаардлагаар нөгөөдөө орлого, хөрөнгийн байдлынхаа талаар мэдээлэл өгөх үүрэгтэй. Энэ хуулийн § 1605-ыг төсөөтэй хэрэглэнэ.

### Хэсэг 3. Төлбөрийн чадвар ба дараалал §1581 Төлбөрийн чадвар

Тэтгэмж төлөх үүрэг бүхий этгээдийн орлогын болон хөрөнгийн байдлыг түүний хүлээсэн үүргийн хамт авч үзвэл зохих этгээдэд тэтгэмж олгосноор өөрийгөө хангалттай тэжээн тэтгэх чадахгүй эрсдэл үүсэхээр байвал тэрээр гагцхүү салсан гэрлэгсдийн хэрэгцээ, орлогын ба хөрөнгийн байдалд нийцэх хэмжээгээр тэтгэмжийг олгоно. Суурь хөрөнгөө захиран зарцуулах явдал нь үр ашиггүй эсвэл талуудын эдийн засгийн байдлыг харгалзан үзэхэд шударга бус байвал тэрээр ийн захиран зарцуулах үүрэггүй.

§ 1582 Хэд хэдэн тэжээн тэтгүүлэх эрх бүхий этгээдийн зэрэгцээ шаардлагаа хангуулах дараалал

Тэжээн тэтгүүлэх эрх бүхий хэд хэдэн этгээд байвал салсан этгээдийн тэтгэмж авах дарааллыг энэ хуулийн § 1609-ийн дагуу тодорхойлно.

### § 1583 Хөрөнгийн тогтолцооны нөлөө

Тэтгэмж төлөх үүрэг бүхий этгээд нь шинээр гэрлэж, гэр бүлийн дундаа хамтаар өмчлөх хөрөнгийн тогтолцоог сонгосон бол энэ хуулийн § 1604-г төсөөтэй хэрэглэнэ.

### § 1584 Хэд хэдэн тэжээн тэтгэх үүрэг бүхий этгээдийн дараалал

Гэр бүлээ цуцлуулсан гэрлэгч эсрэг талд тэтгэмж өгөх үүрэг бүхий төрөл саднаас түрүүлж хариуцлага хүлээнэ. Гэрлэгч тэтгэмж төлөх чадваргүй болсон бол эрх бүхий этгээдийн төрөл садан хариуцлага хүлээнэ. Энэ хуулийн § 1607. 2 ба 4-ийг төсөөтэй хэрэглэнэ.

Хэсэг 4. Тэжээн тэтгэх шаардлагыг гэрээгээр тодорхойлох § 1585 Тэтгэмж олгох хэлбэр

(1) Тогтмол олгох тэтгэмжийг мөнгөн тэтгэмж хэлбэрээр төлнө. Тэтгэмжийг сар бүр урьдчилж олгоно. Тэтгэмж шаардах эрх нь сарын явцад эрх бүхий этгээд ахин гэрлэсэн, нас барсны улмаас дуусгавар болсон ч үүрэг гүйцэтгэгч сарын тэтгэмжийг бүрэн олгоно.

(2) Хүндэтгэн үзэх шалтгаан бий бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн эрхийг хэт хязгаарлаагүй нөхцөлд тэтгэмжийн оронд эрх бүхий этгээд нь нэг удаагийн хөрөнгө орлуулалтын хэлбэрээр нөхөн төлбөр шаардах эрхтэй.

### § 1585a Үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэсэгсэл

(1) Шаардлагатай нөхцөлд үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгсэл санал болгох ёстой. Ийнхүү санал болгох үүрэг нь

тэтгэмж төлөхөд саад учирхааргүй эсвэл энэ нь үүрэг гүйцэтгэгчийн эрхийг шударга бусаар хязгаарлах нөхцөлд үүсэхгүй. Гүйцэтгэлийг хангавал зохих үнийн дүн нь онцгой тохиолдолд шаардлагатайгаас бусад тохиолдолд нэг жилд олгох тэтгэмжийн хэмжээнээс хэтрэх ёсгүй.

(2) Үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгслийн төрөл зүйлийг нөхцөл байдлаас тодорхойлно; энэ хуулийн § 232-т заасан хязгаарлалт үйлчлэхгүй.

#### § 1585 b Өнгөрсөн дэх тэтгэмж

(1) Онцгой хэрэгцээ гарсан нөхцөлд (энэ хуулийн § 1613. 2) эрх бүхий этгээд нь өнгөрсөнд зориулан тэтгэмж шаардаж болно.

(2) Бусад тохиолдолд эрх бүхий этгээд энэ хуулийн § 1613.1-ийн дагуу өнгөрсөнд гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэл эсвэл үүрэг гүйцэтгээгүйгээс учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.

(3) Нэхэмжлэл гаргахаас 1-с дээш жилийн өмнөх гүйцэтгэл ба хохирлыг гацхүү эсрэг тал санаатайгаар төлбөрөөс зайлсхийсэн гэж үзэх нөхцөлд нэхэмжилнэ.

#### § 1585c Тэтгэмжийн талаарх гэрээний тохиролцоо

Гэрлэгсэд гэр бүл салсны дараа тэтгэмж төлөх үүрэг хүлээх тухай гэрээгээр тохиролцож болно. Гэр бүл цуцалсан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнөх тохиролцоог нотариатаар гэрчлүүлнэ. Энэ хуулийн § 127a нь гэр бүлийн хэрэг хянан хэлэлцэх шүүхийн өмнө тэмдэглэл хөтлөх тохиолдолд үйлчилнэ.

#### Хэсэг 5. Тэтгэмж шаардах эрх дуусгавар болох

##### § 1586 Эрх бүхий этгээд ахин гэрлэх, хамтран амьдрах, нас барах

(1) Эрх бүхий этгээд ахин гэрлэсэн, хамтран амьдрал үүсгэсэн эсвэл нас барсан бол тэтгэмж авах шаардах эрх дуусгавар болно.

(2) Өнгөрсөн дэх үүргийн гүйцэтгэлийг эсвэл үүрэг гүйцэтгээгүйгээс учирсан хохирлын нэхэмжлэх эрх хэвээр үлдэнэ. Ахин гэрлэх, хамтран амьдрал үүссэн эсвэл нас барах үед үүссэн байсан сарын тэтгэмжид энэ зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

##### § 1586a Тэтгэмж шаардах эрхийг сэргээх

(1) Гэр бүл цуцалсаны дараа гэрлэгч шинээр гэрлэсэн, хамтран амьдрал үүсгэсэн эргээд эиэ гэр бүл, хамтран амьдралаас салсан ба өмнөх гэр бүлд төрсөн хүүхдийг асран хамгаалах, өсгөх үүрэгтэй бол өмнөх гэрлэгчээс энэ хуулийн § 1570-ын дагуу тэтгэмж шаардах эрхтэй.

(2) Хожим салсан гэр бүлийн хамтрагч нь өмнөх гэр бүлийн хамтрагчаас түрүүлж хариуцлага хүлээнэ. Энэ зохицуулалтыг хамтран амьдрагчийн хувьд төсөөтэй хэрэглэнэ.

##### § 1586b Үүрэг гүйцэтгэгч нас барсан ч үүрэг үл дуусгавар болох



(1) Үүрэг гүйцэтгэгч нас барсан ч тэтгэмж төлөх үүрэг нь түүний өвлөгчид өвөөс гүйцэтгэвэл зохих өр төлбөр хэлбэрээр шилжинэ. Энэ хуулийн § 1581-д заасан хязгаарлалт үйлчлэхгүй. Өвлөгч нь гэрлэгсэд салаагүй нөхцөлд эрх бүхий этгээдэд оногдох байсан заавал ноогдох хэсгээс илүү хэмжээгээр хариуцлага хүлээхгүй.

(2) Заавал ноогдох хэсгийг тооцоход гэрлэгсдийн амьдарч байсан гэр бүлийн хөрөнгийн тогтолцоог харгалзаж үзэхгүй.

Дэд гарчиг 3. Тэтгэмжийг тэнцвэржүүлэх

§ 1587 Тэтгэмжийг тэнцвэржүүлэх тухай хуулийн үйлчлэл

Тэтгэмжийг тэнцвэржүүлэх тухай хуулийн дагуу гэрлэгсдийн дотоод гадаадад олж авсан эрхийг тэнцвэржүүлэх шаардлагатай; ялангуяа үүнд өндөр насны тэтгэмжийн даатгал, төрийн албан хаагчийн болон мэргэжлийн хангамж, ажлын байрнаас өндөр насны хангамж авах эсвэл сайн дурын өндөр насны болон тахир дутуугийн хангамжтай холбоотой эрхүүд хамаарна.

Гэрлэлт нь зөвхөн гэрлэгчдийн аль нэгийг нь эсхүл хоёулангийнх нь гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр зөвхөн шүүхийн журмаар цуцлагдана. Гэрлэлт цуцлахад гэрлэлт бүтэхгүй болсон байх, гэрлэгчдийн хоорондын хамтын амьдрал үгүй болсон байх шалгуурыг тавьдаг. Хүүхдийн тэтгэлгийн асуудалд төрөөс тэр бүр тусламж үзүүлдэггүй гэхэд болно. Хүсвэл шүүх орлогоос /дундаж цалин/ 800 маркаас 2667 хүртэл маркаар тооцож гаргуулна.

*Хүүхдийн тэтгэлгийн хэмжээ*

№	Нас	Маркаар	
		Доод хэмжээ	Дундаж хэмжээ
1	7 нас хүртлэх	116	222
2	7-14 нас хүртлэх	140	268
3	14-18 нас хүртлэх	167	315

Австри улсын гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтаас: Гэр бүл нь тогтвортой. Ганц бие эцэг, эхчүүдийг сар бүр 240 франкын татвараас чөлөөлнө. Гэр бүлд байгаа хүүхэд бүрээр бодож 34 франкын татвараас чөлөөлдөг. Хамт амьдрах эсэхэд хамааралгүй тэтгэвэр төлүүлдэг. Эцэг, эх зөвшөөрөхгүй байсан ч шийднэ. Шаардлагатай нэмэгдэл зардлыг шийдвэрлэж өгдөг. Хэргийг шуурхай шийдвэрлэж гүйцэтгэдэг.

№	Нас	Сар бүр орлогоос авах хэмжээ	Эцэг, эх нь хаяад явбал төрөөс эхний ээлжинд хариуцаж дараа нь төр алдсан мөнгөний 90%-ийг
1	0-5	16%	
2	6-10	18%	
3	11-15	20%	

4	15-аас дээш	22%	олж авсан амжилттай байдаг байна.
---	-------------	-----	-----------------------------------

Франц улсын гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтад гэрлэлт цуцлалт тэр бүр байдаггүй. Хэрэв цуцлах бол дараах гурван үндэслэлээр цуцладаг байна.

-Эхнэр нөхөр харилцан зөвшилцсөн буюу эд хөрөнгийн харилцаагаа хэрхэн зохицуулах тухай, хүүхдээ хүмүүжүүлэх, тэтгэлэг нөхөн олговор олгох талаар тохиролцсон хамтын өргөдлийг шүүхэд гаргасан бол

-Хамтын амьдрал зогсоосон бол гэрлэгчид 3 жилээс багагүй хугацаагаар хамт амьдраагүй, хэн нэг нь цаашид хамтын амьдрал үргэлжлүүлэх боломжгүй байгаа бол

-Гэрлэгчдийн хэн нэг нь буруутай бол гэрлэлтийг цуцладаг байна. Гэрлэлт цуцласнаас нэг хүүхдэд нийгмийн халамжаас 40-800 франк олгодог. Шүүх тэтгэлгийг тогтоодог ба дунджаар нэг хүүхдэд 100 франк олгож байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ-ЗӨВЛӨМЖ**

### **4.1.Дүгнэлт**

Судалгааны багийн гишүүдээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийг судлан үзээд дараах дүгнэлтэд хүрлээ.

Монгол Улсын хэмжээнд 2010-2019 оны хооронд жилд дунджаар 16,305 гэр бүл шинээр бүртгүүлсэн байх ба 2019 оныг өмнөх жилүүдийн дундажтай харьцуулахад 26,1 хувиар өссөн байна. Гэрлэгчдийн тоо өсөх үзэгдлийг даган гэр бүл цуцлуулах байдал мөн өссөн байна. Тухайлбал, жилд дунджаар 3630 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байх ба 2019 оныг өмнөх жилүүдийн дундажтай харьцуулахад 19,7 хувиар өссөн үзүүлэлт гарч байна. Гэр бүл салалтын шалтгааныг маш олон талаас тайлбарладаг ба гэр бүл салалтын нийтлэг шалтгааныг судлаачид соёлын ялгаа /харь орны хүнтэй гэрлэсэн, мөн хоёр өөр гэр бүлийн соёлын мөргөлдөөн/, гэр бүлийн гишүүд хариуцлагаа бүрэн ухамсарлаагүй, гэрлэх хүнээ сайн таньж мэдээгүйгээс үүсэх хэрүүл маргаан, үл ойлголцол, санхүүгийн хомсдол, цалин орлого, амьдралын батлагаа, шилжилт хөдөлгөөн, архидалт, муу зуршил, гэр бүлээс гадуурх харилцаа, хууралт, хүчирхийлэл, дарамт шахалт гэж тайлбарлаж байна.

Гэр бүл цуцлалт нь дээрх олон сөрөг нөлөөтэй бөгөөд энэхүү сөрөг нөлөөлөл нь хүүхдэд хүндээр тусдаг нь хамгийн харамсалтай юм. Салж буй гэр бүлийн хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогоос шалтгаалан сөрөг үйл явц ажиглагддаг ба дунд, ахлах ангийн хүүхдэд гэр бүл салалт илүү хүндээр тусдаг гэсэн судалгаа байна. Тухайлбал: хүүхэд аав, ээжийнхээ аль нэгийг сонгох болдог, эсвэл дунд нь хаягддаг, мөн гэр бүл салалтын шалтгааныг өөртөөгөө холбон ойлгож гутралд ордог гэх мэт асуудлууд бий болдог байна. Мөн түүнчлэн гэр бүл салалтаас үүдэн эцэг, эхээс хүүхдэд тавих хараа хяналт суларснаас хүүхэд муу зуршилтай хүмүүстэй нийлэх, цаашлаад гэрээсээ дайжих, өрхийн орлогод өөрчлөлт орж, санхүүгийн асуудал үүссэнээс хүүхэд хөдөлмөр эрхлэх гэх мэт сөрөг үр дагаварууд үргэлжилсээр байна.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага /насанд хүрээгүйчүүдийн хорих анги /-д 2020 оны 09 дүгээр сарын 01-ны байдлаар гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй 30 хүүхдээс судалгаа авахад 10 нь буюу 30% нь эцэг эхтэйгээ амьдардаг, үлдсэн 20 нь буюу 70% нь эцэг эх нь салсан, гэр бүлээсээ дайжсан хүүхдүүд байна.

Монгол Улсад жилд дунджаар иргэний хэргийн шүүхээр 43,000 орчим хэрэг шийдвэрлэгддэгийн 11.5 хувь нь гэр бүлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн хэрэг байна.

Гэр бүлийн хуулийн дагуу шийдвэрлэсэн нийт хэргийн 71 хувийг гэр бүл цуцлалт, 9 хувийг эцэг тогтоосон, 0,3 хувийг эцэг, эх байх эрхээ хасуулсан, 16 хувийг хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 0,7 хувийг гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, 3 хувийг бусад хэрэг маргаан эзэлж байна.

1.Монгол Улсад шүүхийн журмаар хүүхдийн тэтгэлэг гаргуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал:

Эрт дээр үеэс Монголчуудын гэр бүл, төрөл төрөгсөд, нутаг нутгийнхаа орчинд өөрсдийн зан заншил, хэв уламжлалаараа өрх гэр үүсгэж, эхнэр нөхөр бололцон, үр хүүхдээ хүмүүжүүлж, хүний дайтай хүн болгож, ахуй амьдралаа дээшлүүлэн, төр нийгмийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн юм.

1926 онд батлагдсан Иргэний хуулиас хойш 1958,1979,1999 оны хуулиудаар гэр бүлийн харилцаа, түүн дотроо хүүхдийн тэтгэлэгийн асуудлыг зохицуулж иржээ.

2.Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт:

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль зэрэг хууль тогтоомжоор хүүхдийн эрхийг хангах, тэжээн тэтгэхтэй холбоотой зохицуулалт байна.

3.Монгол Улсын хэмжээнд хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд хийсэн шинжилгээ:

Сүүлийн 5 жилийн дунджаас үзэхэд нийт төлбөр авагч хүүхдийн 62 хувь нь 0-11 насны, 38 хувь нь 11 ба түүнээс дээш насны хүүхэд байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар хүүхдийн тэтгэлгийн биелүүлбэл зохих 12783 гүйцэтгэх баримт бичгийн 41,8 тэрбум төгрөгөөс 1481 гүйцэтгэх баримт бичгийн 15,8 тэрбум төгрөгийг бодитой биелүүлснээс 10,6 тэрбус төгрөгийг хэсэгчлэн төлүүлжээ. Гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 11,6 хувийн үзүүлэлттэй, 11302 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна. Улсын дүнгээр хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичгийн биелэлт гүйцэтгэх хуудсаар 2018 онд 10.1, 2019 онд 11.6 буюу 0.5 хувь, мөнгөн дүнгээр 2018 онд 32.7, 2019 онд 37.8 буюу 5.1 хувь өссөн үзүүлэлт харагдаж байна.

Хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичгийн дуусгавар болж буй үндэслэлийг судлаж үзвэл 15 хувь нь насанд хүрсэн, 1 хувь нь нас барсан, 1 хувь нь тэтгүүлэгч хүүхэд бусдад үрчлэгдсэн, 35 хувь нь тэтгэлэг бүрэн төлөгдсөн, 30 хувь нь талууд эвлэрсэн, 17 хувь нь төлбөр авахаас татгалзсан гэх шалтгаанаар гүйцэтгэх баримт бичгийг хаасан байна.

21 аймгийн 599 иргэн, 380 төлбөр авагчаас шүүхээс тогтоосон хүүхдийн тэтгэлгийн хувь хэмжээний талаарх таны санал? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 46% нь хангалттай, 23,7% нь хангалтгүй, 15,1% нь холбогдох хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай, 15% нь сайн мэдэхгүй байна гэсэн бол **төлбөр авагчдын** 23,9% нь хангалттай, 27,8% нь хангалтгүй, 21,5% нь холбогдох хуульд тэтгэлгийн хувь хэмжээг нэмэх талаар өөрчлөлт оруулах, 0,7% нь сайн мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн байна.

Түүнчлэн хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа этгээдэд ямар хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогч иргэдийн 14,6% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нь бүрэн тогтоож, хураан авах, 59,7% нь төлбөр төлөгч этгээдийг албадан ажил хийлгэж, цалин хөлсийг нь тооцох, 23,8% нь төлбөр төлөхөөс зайлсхийж буй этгээдэд шийтгэл оногдуулах, 1,6% нь бусад гэсэн хариултыг өгчээ. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг сайжруулах талаарх таны бодол? гэсэн асуултад судалгаанд оролцогч **иргэдийн** 29,8% нь төрөөс хүүхдийн тэтгэлгийн мөнгийг эхний ээлжинд бүрэн гарган, төлбөр авагчийн дансанд шилжүүлэн, дараа нь тэтгэлэг төлөгчөөс шийдвэр гүйцэтгэгч албадан гаргуулж, төрийг хохиролгүй болгох, 21% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг бүрэн тогтоож, эд хөрөнгөнөөс нь албадан гаргуулах, 43,2% нь төлбөр төлөгчийг албадан хөдөлмөр эрхлүүлж, тэтгэлгийг гаргуулах, 5,8% нь бусад арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.

4. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаарх судалгаа:

Хүүхдийн тэтгэлгийн гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх зорилго бүхий асуулыг 140 шийдвэр гүйцэтгэгчээс авахад дараах хариултыг өгсөн байна.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг та хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 7,8% нь хангалттай, 14,2% нь хангалтгүй, 77,8% сайжруулах шаардлагатай гэсэн хариултыг өгсөн нь дээрх харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

5. Гадаадын зарим орны хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа:

Гадаадын ихэнхи оронд гэрлэлтийн гэрээг байгуулж хэвшсэн ба энэхүү гэрээгээр гэр бүл цуцалсан тохиолдолд эд хөрөнгийн маргааныг хэрхэн шийдвэрлэх, тухайлан хүүхдийн тэтгэлэг төлөх талаар тусган талууд баталгаажуулсан байдаг тул тухайн харилцаанд маргаан гарах нь бага байдаг байна.

#### **4.2.Зөвлөмж**

Судалгааны ажлын дүгнэлттэй уялдуулан дараах зөвлөмжийг гаргаж байна.Үүнд:

1.Иргэний хуулийн 32 дугаар зүйлд гэрлэгчид зөвхөн хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулахаар заасан тул хүүхдийн тэжээн тэтгэх эрхийн тухай асуудлыг орхигдуулсан байна. Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн практикт гэрлэлтийн гэрээ хийж буй асуудал учир дутагдалтай бага байна. Зүй нь гэрлэлтийн гэрээнд зөвхөн хөрөнгийн асуудал бус үр хүүхдээ тэжээн тэтгэх асуудлыг тусгасан байдлаар хуульчилж, гэр бүл батлуулахад зайлшгүй гэрээг харгалзан үздэг байх нь зүйтэй гэж үзлээ.

2.Хүүхдийн тэтгэлэг төлөгч нь төлбөрийн чадваргүй, ажил хөдөлмөр эрхэлддэггүй, төлбөр төлөхөөс зайлсхийх асуудал шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад дийлэнхи байна. Иймд хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлхийж буй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, тухайлбал, албадан сургалтад хамруулах, албадан хөдөлмөр эрхлүүлж хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх, жолоодох эрхийг түдгэлзүүлэх, нийтэд мэдээлэх зэрэг албадлагын шинжтэй арга хэмжээг авах шаардлагатай байна.

3.Хүүхдийн тэтгэлэгээ төлөх асуудал нь хувь хүний ёс зүй, зан байдалтай шууд холбоотой тул хувь хүний хандлагыг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байх нь зүйтэй гэж үзлээ.

## **ТАВ.ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ**

Нэг. Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Гэр бүлийн тухай хууль 1999 он
3. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль 1996 он
4. Иргэний бүртгэлийн тухай хууль 1996 он
5. Иргэний хууль 2002 он
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017
8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 он

Хоёр. Ном, сурах бичиг:

1. Иргэний хуулийн тайлбар 2005 он
2. Т. Мөнхжаргал Гэр бүлийн эрх зүй 1995 он
3. Ц. Алтанцэцэг Иргэн, бизнесийн эрх зүйн гарын авлага 114-120 х2006 он
4. Т. Намжил. Гэр бүл судлал. 2004 он, 131 дэх тал
5. С. Баасандорж. Гэр бүлийн эрх зүй. 2015 он

## ЗУРГАА.ХАВСРАЛТ

### БРАЧНЫЙ ДОГОВОР

Г. \_\_\_\_\_  
" \_\_\_\_ " \_\_\_\_\_ Г.

Гражданин \_\_\_\_\_ Российской Федерации  
\_\_\_\_\_ и гражданка Российской Федерации  
\_\_\_\_\_, именуемые далее "супруги",  
добровольно по взаимному согласию вступая в брак, в целях  
урегулирования взаимных имущественных прав и обязанностей как в  
браке, так и в случае его расторжения заключили настоящий брачный  
договор о нижеследующем:

#### 1. ПРЕДМЕТ ДОГОВОРА

1.1. Супруги договариваются о том, что на все имущество, нажитое  
супругами совместно в браке, независимо от того, на чьи доходы оно  
было приобретено, устанавливается режим совместной собственности.  
Для отдельных видов имущества, специально указанных в настоящем  
договоре или дополнении к нему, может устанавливаться иной режим.

1.2. Имущество, принадлежавшее каждому из супругов до  
вступления в брак, а также имущество, полученное одним из супругов  
во время брака в дар, в порядке наследования или по иным  
безвозмездным сделкам, является его собственностью.

1.3. К моменту заключения настоящего договора гр.  
\_\_\_\_\_ принадлежит следующее имущество:

- квартира общей площадью \_\_\_\_\_ кв. м, находящаяся по адресу:  
\_\_\_\_\_;
- автомобиль \_\_\_\_\_, двигатель N \_\_\_\_\_, кузов N \_\_\_\_\_,  
государственный номер \_\_\_\_\_, зарегистрированный в  
\_\_\_\_\_;
- предметы мебели согласно прилагаемому к договору списку;
- золотые и серебряные украшения, а также ювелирные изделия из  
драгоценных и полудрагоценных камней согласно прилагаемому к  
договору списку;
- гараж для автомобиля, расположенный по адресу:  
\_\_\_\_\_.

Гр. \_\_\_\_\_ к  
моменту

(фамилия, имя, отчество)

заклучения настоящего договора принадлежит следующее имущество:

- \_\_\_\_\_;



-  
\_\_\_\_\_  
-  
\_\_\_\_\_  
-  
\_\_\_\_\_.

1.4. К общему имуществу, нажитому во время брака, относятся доходы каждого из супругов от трудовой деятельности, предпринимательской деятельности и результатов интеллектуальной деятельности, полученные ими пенсии, пособия и иные денежные выплаты, не имеющие специального назначения. Владение и пользование общим имуществом осуществляется по обоюдному согласию.

1.5. Право на общее имущество принадлежит также супругу, который в период брака осуществлял ведение домашнего хозяйства, уход за детьми или по другим уважительным причинам не имел самостоятельного дохода.

1.6. Вещи индивидуального пользования (одежда, обувь и другие), за исключением драгоценностей и других предметов роскоши, хотя и приобретенные в период брака за счет общих средств супругов, признаются собственностью того супруга, который ими пользовался.

1.7. Доходы целевого назначения (суммы материальной помощи, суммы, выплаченные в возмещение ущерба в связи с утратой трудоспособности вследствие увечья или иного повреждения здоровья и т.п.) признаются собственностью супруга, которому они выплачены.

1.8. Супруги вправе распоряжаться общим имуществом по взаимному согласию. Согласие супруга на совершение другим супругом сделки с общим имуществом предполагается, если другой супруг не выскажет возражений против сделки до ее совершения. Для совершения сделок с недвижимым имуществом (в том числе с квартирами, жилыми и нежилыми помещениями, земельными участками и т.п.), транспортными средствами и иным имуществом, сделки с которым подлежат нотариальному удостоверению или государственной регистрации, необходимо предварительное письменное согласие другого супруга. Если сделка по соглашению сторон или в силу закона совершается в нотариальной форме, согласие другого супруга на совершение такой сделки также должно быть нотариально удостоверено. Предварительное письменное согласие другого супруга необходимо при отчуждении и приобретении имущества, если сумма сделки превышает \_\_\_\_\_ рублей, независимо от вида имущества, в отношении которого совершается сделка.

1.9. В любой момент в период брака супруги по взаимному соглашению вправе изменить установленный настоящим договором режим совместной собственности.

## **2. ПРАВА И ОБЯЗАННОСТИ СУПРУГОВ**

2.1. Каждый супруг обязан проявлять надлежащую заботу о совместном имуществе и об имуществе, принадлежащем другому супругу, принимать все необходимые меры для предотвращения уничтожения или повреждения имущества, а также для устранения угрозы уничтожения или повреждения, в том числе производить необходимые расходы как за счет общих денежных средств, так и за счет иных доходов.

Каждый супруг обязан соблюдать права и законные интересы другого супруга, установленные настоящим брачным договором и законом, как в браке, так и после его расторжения.

2.2. Супруги обязаны воздерживаться от заключения рискованных сделок. Под рискованными сделками понимаются сделки, невыполнение обязательств по которым может привести к утрате значительной части совместного имущества либо к существенному сокращению доходов супругов.

2.3. Каждый из супругов имеет право пользоваться имуществом другого супруга, принадлежавшим ему до вступления в брак, в соответствии с назначением имущества.

2.4. В период брака каждый из супругов вправе распорядиться принадлежавшим ему до брака имуществом по своему усмотрению, однако доходы по таким сделкам супруги признают общей совместной собственностью.

2.5. Каждый из супругов обязан уведомлять своего кредитора (кредиторов) о заключении, изменении или о расторжении настоящего брачного договора.

2.6. В случае расторжения брака имущество, принадлежавшее супругам до вступления в брак, в массу имущества, подлежащую разделу, не входит.

2.7. При расторжении брака общее имущество подлежит разделу в равных долях.

### **3. ОТВЕТСТВЕННОСТЬ СУПРУГОВ**

3.1. Каждый из супругов несет ответственность в отношении принятых на себя обязательств перед кредиторами в пределах принадлежащего ему имущества. При недостаточности этого имущества кредитор вправе требовать выдела доли супруга-должника, которая причиталась бы супругу-должнику при разделе общего имущества, для обращения на нее взыскания.

3.2. Супруг не несет ответственности по сделкам, совершенным другим супругом без его согласия.

3.3. На общее имущество взыскание может быть обращено лишь по общим обязательствам супругов. При недостаточности этого имущества супруги несут по указанным обязательствам солидарную ответственность своим имуществом.

3.4. Ответственность супругов за вред, причиненный их несовершеннолетними детьми, определяется гражданским законодательством.

#### **4. ВСТУПЛЕНИЕ В СИЛУ, ИЗМЕНЕНИЕ И ПРЕКРАЩЕНИЕ ДОГОВОРА**

4.1. Настоящий договор вступает в силу со дня государственной регистрации заключения брака.

4.2. Настоящий договор подлежит нотариальному удостоверению.

4.3. Действие договора прекращается в момент государственной регистрации расторжения брака.

4.4. Супруги вправе в любой момент внести в настоящий договор изменения и дополнения. Односторонний отказ от исполнения настоящего договора не допускается.

4.5. Все спорные вопросы, которые могут возникнуть в период действия настоящего договора, в случае недостижения супругами согласия разрешаются в судебном порядке.

#### ПОДПИСИ СТОРОН:

Гр.

\_\_\_\_\_  
паспорт: серия \_\_\_\_\_ N \_\_\_\_\_, выдан

\_\_\_\_\_

\_\_\_\_\_  
адрес:

\_\_\_\_\_.

\_\_\_\_\_  
(подпись)

Гр.

\_\_\_\_\_  
паспорт: серия \_\_\_\_\_ N \_\_\_\_\_, выдан

\_\_\_\_\_

\_\_\_\_\_  
адрес:

\_\_\_\_\_.

\_\_\_\_\_  
(подпись)

## ГЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

\_\_\_\_\_ " \_\_\_\_ " \_\_\_\_\_

ОХУ-ын иргэн \_\_\_\_\_ ба ОХУ-ын иргэн \_\_\_\_\_ цаашид "гэрлэгчид" гэх бөгөөд харилцан тохиролцсоны үндсэн дээр сайн дураар гэрлэлтээ батлуулж, гэрлэлтийн явцад болон салсан тохиолдолд харилцан өмчлөх эрх, үүргээ зохицуулах зорилгоор гэрлэлтийн гэрээг дараах байдлаар байгуулав.

### 1. Хэлэлцээрийн сэдэв

1.1. Гэрлэгчид гэрлэснээс хойшид олж авсан бүх эд хөрөнгийг хэний орлогоос үл хамааран дундын өмчлөлд хамруулна гэж эхнэр, нөхрүүд зөвшөөрч байна. Энэхүү гэрээнд тусгайлан заасан тодорхой төрлийн эд хөрөнгийн хувьд өөр өөрөөр тогтоож болно.

1.2. Гэрлэхээс өмнө эхнэр нөхөр тус бүрт харьяалагддаг байсан эд хөрөнгө, түүнчлэн гэрлэлтийн хугацаанд эхнэр, нөхрийн аль нэгэнд бэлэг, өв залгамжлал, бусад үнэ төлбөргүй гүйлгээгээр хүлээн авсан эд хөрөнгө нь түүний өмч мөн.

1.3. Энэхүү гэрээг байгуулах үед \_\_\_\_\_ дараахь өмчийг эзэмшдэг:

- нийт талбай \_\_\_\_\_ кв. м, байршил: \_\_\_\_\_;
- машин \_\_\_\_\_, хөдөлгүүр N \_\_\_\_\_, кузов N \_\_\_\_\_, улсын дугаар \_\_\_\_\_, \_\_\_\_\_ -д бүртгэлтэй;
- гэрээнд хавсаргасан жагсаалтын дагуу тавилга;
- гэрээнд хавсаргасан жагсаалтын дагуу алт, мөнгөн эдлэл, түүнчлэн үнэт, хагас үнэт чулуугаар хийсэн үнэт эдлэл;
- машины гараж, байршил: \_\_\_\_\_.

Одоог хүртэл \_\_\_\_\_

(Бүтэн нэр)

Энэхүү гэрээг байгуулахад дараахь өмч хамаарна:

- \_\_\_\_\_;
- \_\_\_\_\_;
- \_\_\_\_\_;
- \_\_\_\_\_.

1.4. Гэрлэлтийн үеэр олж авсан нийтлэг өмч хөрөнгөд эхнэр, нөхөр тус бүрийн хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэх, оюуны бүтээл эрхэлсний орлого, тэдний авсан тэтгэвэр, тэтгэмж, бусад зориулалтын бус мөнгөн төлбөр зэрэг орно. Дундын өмчийг эзэмших, ашиглахыг харилцан тохиролцсоны үндсэн дээр хэрэгжүүлдэг.

1.5. Дундын өмчийг захиран зарцуулах эрх нь гэрлэлтийн хугацаанд гэр бүлийн харилцааг зохицуулах, хүүхэд асрах зэрэг бусад

хүндэтгэн үзэх шалтгаанаар бие даасан орлогогүй байсан эхнэр, нөхөрт нэгэн адил хамаарна.

1.6. Гэрлэлтийн явцад эхнэр/нөхрийнхөө дундын өмчийн зардлаар олж авсан боловч үнэт эдлэл болон бусад тансаг эд зүйлээс бусад хувийн эд зүйлс (хувцас, гутал гэх мэт) -ийг ашигласан эхнэр/нөхрийн өмч гэж хүлээн зөвшөөрнө.

1.7. Зориулалтын орлого (материаллаг тусламжийн хэмжээ, гэмтэл бэртэл, эрүүл мэндэд учирсан бусад хохирлын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсаны улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн дүн) нь түүнийг авсан эхнэр/нөхрийн өмч болохыг хүлээн зөвшөөрнө.

1.8. Гэрлэгчид дундын өмчийг харилцан тохиролцож захиран зарцуулах эрхтэй. Нөгөө тал /эхнэр/нөхөр/ нь хэлцэл хийхээс өмнө эсэргүүцэл гаргаагүй бол бусад тал /эхнэр/нөхөр/ нь дундын эд хөрөнгөөр хэлцэл хийхийг зөвшөөрсөн эхнэр, нөхрийн зөвшөөрлийг авна. Нотариатаар гэрчлүүлэх, улсын бүртгэлд бүртгүүлэх үл хөдлөх хөрөнгө (орон сууц, орон сууцны болон орон сууцны бус газар, газар гэх мэт), тээврийн хэрэгсэл болон бусад эд хөрөнгөтэй хэлцэл хийхийн тулд нөгөө тал /эхнэр/нөхөр/-ын урьдчилсан бичгээр өгсөн зөвшөөрөл шаардлагатай. Хэрэв хэлцэл нь талуудын тохиролцсоны дагуу эсвэл хуулийн дагуу нотариатаар гэрчлэгдсэн бол нөгөө эхнэр/нөхрийн ийм хэлцэл хийх зөвшөөрлийг мөн нотариатаар гэрчлүүлэх ёстой. Хэлцэл хийгдэж буй үл хөдлөх хөрөнгийн төрлөөс үл хамааран гүйлгээний хэмжээ \_\_\_\_\_ рублиас хэтэрсэн тохиолдолд бусад эхнэр, нөхрийн урьдчилсан бичгээр өгсөн зөвшөөрөл шаардлагатай.

1.9. Гэрлэлтийн аль ч үед гэрлэгчид харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд заасан хамтын өмчлөлийн дэглэмийг өөрчлөх эрхтэй.

## 2. Эхнэр, нөхрийн ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Эхнэр, нөхөр тус бүр дундын эд хөрөнгө болон бусад эхнэр, нөхөрт хамаарах эд хөрөнгийг зохих ёсоор хариуцаж, эд хөрөнгийг устгах, гэмтээхээс урьдчилан сэргийлэх, устгах, эвдрэх аюулыг арилгах, үүнд шаардлагатай зардлыг хоёуланг нь нийтлэг сангаас гаргах, бусад орлогын зардлаар. Гэр бүлийн хүн бүр гэрлэлтийн болон гэрлэлтээ цуцлуулсны дараа энэхүү гэрлэлтийн гэрээ болон хуулиар тогтоосон бусад эхнэр/нөхрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дагаж мөрдөх үүрэгтэй.

2.2. Гэрлэгчид эрсдэлтэй гүйлгээ хийхээс татгалзах үүрэгтэй. Эрсдэлтэй гүйлгээ гэж үүрэг хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс дундын эд хөрөнгийн үлэмж хэсэг алдагдах эсвэл эхнэр нөхрийн орлого мэдэгдэхүйц буурахад хүргэж болзошгүй гүйлгээ гэж ойлгодог.

2.3. Гэрлэгчид тус бүр гэрлэлтийн өмнө өөрт нь хамааралтай байсан эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах эрхтэй.

2.4. Гэрлэлтийн үеэр эхнэр, нөхөр тус бүр өөрт нь хамаарах эд хөрөнгийг өөрийн үзэмжээр захиран зарцуулах эрхтэй боловч гэр бүлийн хүмүүс ийм гүйлгээний орлогыг дундын өмч гэж хүлээн зөвшөөрнө.

2.5. Гэрлэгчид тус бүр энэхүү гэрлэлтийн гэрээг байгуулах, өөрчлөх, цуцлах тухай зээлдүүлэгчид (зээлдүүлэгчдэд) мэдэгдэх үүрэгтэй.

2.6. Гэрлэлтээ цуцлуулах тохиолдолд гэрлэхээс өмнө гэрлэгчдийн өмчлөлд байсан эд хөрөнгийг хуваах зүйлд хамруулахгүй.

2.7. Гэрлэлт цуцлагдсаны дараа дундын эд хөрөнгийг тэнцүү хуваана.

### 3. ГЭР БҮЛИЙН ХАРИУЦЛАГА

3.1. Гэрлэгчид тус бүр өөрийн эд хөрөнгийн хүрээнд зээлдүүлэгчдэд хүлээсэн үүргээ хариуцна. Хэрэв энэ үл хөдлөх хөрөнгө хангалтгүй бол зээлдүүлэгч нь нийтлэг эд хөрөнгийг хуваах тохиолдолд төлөх ёстой байсан хувь хэмжээг хариуцагчаас гаргуулахаар нэхэмжлэх эрхтэй.

3.2. Эхнэр, нөхөр нь түүний зөвшөөрөлгүйгээр эхнэр/нөхрийн хийсэн гүйлгээг хариуцахгүй.

3.3. Цуглуулгыг зөвхөн гэрлэгчдийн ерөнхий үүргийн дагуу дундын өмчөөс авах боломжтой. Хэрэв энэ үл хөдлөх хөрөнгө хангалтгүй бол гэрлэгчид эдгээр үүргийг эд хөрөнгөтэйгээ хамтран хариуцна.

3.4. Насанд хүрээгүй хүүхдэд нь учирсан гэм хорын төлөө эхнэр, нөхрийн хариуцлагыг иргэний хуулиар тогтоодог.

### 4. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

4.1. Энэхүү гэрээ нь гэрлэлтийн улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Энэхүү гэрээг нотариатаар гэрчлүүлнэ.

4.3. Гэр бүл цуцлалтыг улсын бүртгэлд бүртгүүлэх үед гэрээг цуцална.

4.4. Гэрлэгчид энэхүү гэрээнд хэдийд ч нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхээс нэг талт татгалзахыг зөвшөөрөхгүй.

4.5. Гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд гарч болох бүх маргаантай асуудлын талаар гэрлэгчид тохиролцоогүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

Талуудын гарын үсэг:

Гр.

\_\_\_\_\_  
паспорт: \_\_\_\_\_ гаргасан цуврал \_\_\_\_\_ N

\_\_\_\_\_

\_\_\_\_\_  
хаяг:

\_\_\_\_\_.

\_\_\_\_\_  
(гарын үсэг)

гр.

\_\_\_\_\_ /  
паспорт: цуврал \_\_\_\_\_ N \_\_\_\_\_, гаргасан  
\_\_\_\_\_

\_\_\_\_\_  
хаяг:  
\_\_\_\_\_.

\_\_\_\_\_  
(гарын үсэг)